

Сангийн сайдын 2023 оны 12 дугаар
сарын 25-ны өдрийн А/2460 дугаар
тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

ҮЙЛЧИЛГЭЭ АВАХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН
ЖИШИГ БАРИМТ БИЧИГ

2024 он

I БҮЛЭГ.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗААВАРЧИЛГАА

А.ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

1. Тендерийн цар хүрээ

1.1.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “Хууль” гэх)-ийн дагуу өгөгдлийн хүснэгтэд заасан захиалагч III бүлэгт тодорхойлсон үйлчилгээ (цаашид “үйлчилгээ” гэх) худалдан авахаар тендер шалгаруулалтыг зохион байгуулна. Тендер шалгаруулалтын нэр болон дугаарыг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.2.Тендер шалгаруулалт багцтай бол энэ тухай мэдээллийг өгөгдлийн хүснэгтэд заана.

1.3.Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа үед энэ тухай өгөгдлийн хүснэгтэд заана.

2. Санхүүжилтийн эх үүсвэр болон төсөвт өртөг

2.1.Тендер шалгаруулалтын нийт болон багц тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, батлагдсан төсөвт өртгийг өгөгдлийн хүснэгтэд тусгана.

3. Худалдан авах ажиллагааны хууль тогтоомж

3.1.Энэ худалдан авах ажиллагаанд хуулийн 2.1-д заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4. Худалдан авах ажиллагааны цахим систем

4.1.Тендер шалгаруулалтыг Сангийн сайдын баталсан “Цахим системээр худалдан авах ажиллагаа зохион байгуулах, түүний тасралтгүй, аюулгүй ажиллагааг хангах журам”-ын дагуу худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) /цаашид “цахим систем” гэх/-ээр зохион байгуулна.

5. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

5.1.Захиалагч, сонирхогч этгээд, оролцогч болон хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдлийн талаар холбогдох албан тушаалтан, хууль хяналтын байгууллагад хууль тогтоомжийн дагуу мэдэгдэнэ.

5.2.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20, 20¹, 21 дүгээр зүйлд заасан хориглолт, хязгаарлалтад хамаарах этгээд тендер шалгаруулалтад оролцох эрхгүй байна.

6. Сонирхогч этгээд, оролцогчид тавигдах ерөнхий шаардлага

6.1.Аж ахуй эрхлэгч нь хуулийн 22.10-т зааснаар үйлчилгээний хураамж төлснөөр тус тендер шалгаруулалтын сонирхогч этгээд болно.

6.2.Сонирхогч этгээдийн төлсөн үйлчилгээний хураамжийг аливаа үндэслэлээр буцаан олгохгүй.

6.3.Оролцогчтой холбоотойгоор хуулийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй буюу ерөнхий шаардлагыг хангасан

байна.

6.4.Оролцогч хуулийн 6 дугаар зүйлд нийцүүлэн тендер ирүүлнэ.

6.5.Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.

6.6.Монгол Улсын хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд зааснаар бүртгүүлсэн мэдээлэлд үндэслэнэ.

6.7.Монгол Улсын олон улсын гэрээнд үл нийцэх, худалдааны хоригт хамаарах этгээд тендер ирүүлэх эрхгүй.

7. Туслан гүйцэтгэгч, түншлэлд тавигдах шаардлага

7.1.Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.

7.2.Туслан гүйцэтгүүлэх гэрээ хуулийн 6.4-т заасныг зөрчсөн бол захиалагч тухайн туслан гүйцэтгүүлэх гэрээ, туслан гүйцэтгэгчид холбогдох баримт бичгийг тендер хянан үзэхэд харгалзан үзэхгүй.

7.3.Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.

7.4.ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.

7.5.Түншлэлийн гишүүн, туслан гүйцэтгэгч тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн жагсаалтад бүртгэгдсэн хугацаа дуусгавар болоогүй бол ерөнхий шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

Б.АГУУЛГА

8. Тендер шалгаруулалтын баримт бичиг

8.1.Тендер шалгаруулалтын баримт бичиг нь доор дурдсан бүлэг болон түүнд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөс бүрдэнэ:

I Бүлэг. Тендер шалгаруулалтын зааварчилгаа;

II Бүлэг. Өгөгдлийн хүснэгт;

III Бүлэг. Техникийн тодорхойлолт, тавигдах шаардлага;

IV Бүлэг. Тендерийн үнэлгээний шалгуур үзүүлэлт;

V Бүлэг. Тендерийн жишиг маягт;

VI Бүлэг. Гэрээний нөхцөл.

8.2.Сонирхогч этгээд ТШЗ, өгөгдлийн хүснэгтэд заасан шаардлага, шалгуур үзүүлэлт, гэрээний нөхцөл, тендерийн жишиг маягт, техникийн тодорхойлолт болон түүнд оруулсан аливаа өөрчлөлт, иш татсан хууль, журам, зааврыг судалж, тэдгээрт нийцүүлэн тендер бэлтгэнэ.

9. Тендер шалгаруулалтын баримт бичгийг тодруулах

9.1.Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичигт заасан асуудлаар тодруулга авах бол энэ тухай хүсэлтийг тендерийн нээлтээс ажлын таваас доошгүй өдрийн өмнө бичгээр захиалагчид гаргаж болно.

9.2.Тодруулга авах хүсэлтийг өгөгдлийн хүснэгтэд заасан хаягаар хүлээн авна.

9.3.Тодруулга авах хүсэлтэд үйлчилгээний хураамж төлсөн баримтыг хавсаргана.

9.4.Захиалагч тодруулга авах хүсэлтийн хариуг албан бичгээр үйлдэж, цахим системд нийтэлснээр хүргүүлсэн гэж тооцно.

9.5.Захиалагч тодруулгын үр дүнд тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл ТШЗ-ы 11-д заасныг мөрдөнө.

10. Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт

10.1. Хуулийн 19.4-т зааснаар уулзалт зохион байгуулах, эсхүл ажлын талбайтай танилцуулах бол Өгөгдлийн хүснэгтэд заана.

10.2. Уулзалтад сонирхогч этгээд, түүний төлөөлөл оролцоно.

10.3. ТШЗ-ны 10.1-д заасан уулзалтад оролцоогүй аж ахуй эрхлэгч тендер шалгаруулалт шалгаруулалтад оролцож болно.

11. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах

11.1. Тендер хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө захиалагч тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

11.2. Тендер шалгаруулалтын баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулсан бол түүнийг цахим системд нийтэлснээр хүчинтэйд тооцогдоно.

11.3. Хэрэв тендер нээхээс ажлын таван өдрийн дотор тендер шалгаруулалтын баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бол тендер хүлээн авах эцсийн хугацааг ажлын таваас доошгүй өдөр байхаар тооцож, шаардлагатай хугацаагаар сунгана.

V. ТЕНДЕР БЭЛТГЭХ

12. Тендер шалгаруулалтын баримт бичгийн болон тендерийн хэл

12.1. Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ.

12.2. Зөвхөн гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх үйлчилгээ авах тендер шалгаруулалтын хувьд Монгол Улсын олон улсын гэрээг үндэслэн хэлийг өгөгдлийн хүснэгтэд өөрөөр зааж болно.

12.3. Хэрэв ТШЗ-ны 12.2-т зааснаар бэлдсэн тохиолдолд тендер шалгаруулалтын баримт бичгийн монгол хэл болон гадаад хэлээр бэлтгэсэн хувилбар хоорондоо зөрвөл монгол хэлээр бэлтгэсэн хувилбарыг баримтална.

12.4. Тендер хянан үзэх, үнэлэхэд захиалагч гадаад хэлээр үйлдсэн баримт бичгийн орчуулгыг үндэслэх ба оролцогч өөрөө, эсхүл бусад этгээд орчуулсан эсэхээс үл хамааран үнэн зөв, зөрүүгүй болохыг захиалагчийн өмнө хариуцна.

13. Тендерийн иж бүрдэл

13.1. Тендер нь хуулийн 21.1-д нийцүүлж бэлтгэсэн үйлчилгээ үзүүлэх техникийн болон үнийн санал байна.

13.2. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер дараах баримт бичиг, мэдээллээс бүрдэнэ:

13.2.1.ТШЗ-ны 14-т заасны дагуу бэлтгэсэн маягтууд;

13.2.2.оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;

13.2.3.ТШЗ-ны 15-д заасны дагуу бэлтгэсэн хувилбарт санал;

13.2.4.оролцогч ТШЗ-ны 16-д заасан ерөнхий шаардлагыг хангасан болохыг нотлох баримт бичиг;

13.2.5.тендерт оролцогчийн чадавх, туршлага ТШЗ-ны 17, 18, 19-д заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангахыг нотлох баримт бичиг;

13.2.6.санал болгож буй үйлчилгээ ТШЗ-ны 20-д заасан шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг;

13.2.7.ТШЗ-ны 21-д заасан үйлчилгээ үзүүлэх төсөв;

13.2.8.ТШЗ-ны 21.5-д заасан тохиолдолд холбогдох тайлбар;

13.2.9.Түншлэлээр, эсхүл туслан гүйцэтгэгчтэй бол холбогдох гэрээ.

13.3.Оролцогч өөрийн тендерийн бүх баримт бичиг, мэдээллийн хүчинтэй байдлыг нягтлах үүрэгтэй бөгөөд үнэн зөвийг захиалагчийн өмнө хариуцна.

13.4.Оролцогч хуулийн 22.7, 22.10-т заасныг үндэслэн тендерийн баталгаа хүргүүлж, үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээнэ.

14. Тендерийн жишиг маягтууд

14.1.Оролцогч V бүлэгт заасан маягтын мэдээллийг хуулийн 21.1.3-т зааснаар цахим системд үүсгэсэн маягтад бөглөж, илгээнэ.

15. Хувилбарт санал

15.1.Өгөгдлийн хүснэгтэд заасан бол хуулийн 11.10-т заасан шаардлагад нийцэх хувилбарт саналыг тендерийн хамт ирүүлж болно.

16. Ерөнхий шаардлагыг магадлах баримт бичиг

16.1.Оролцогчийн ерөнхий шаардлага хангасан эсэхийг дараах баримт бичгээр магадална. Үүнд:

16.1.1.ТШЗ-ны 14.1-д заасны дагуу бөглөж ирүүлсэн V бүлгийн Маягт 1.

16.1.2.Ерөнхий шаардлагыг хангасан эсэхийг магадлахтай холбоотой ирүүлэх бусад баримт бичгийг хуулийн 7 дугаар зүйлд нийцүүлэн өгөгдлийн хүснэгтэд заана.

16.2.Гадаадын этгээд нь үүсгэн байгуулагдсан, эсхүл

оршин суугаа улсын төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан дараах баримт бичиг, эсхүл түүнтэй адилтгах баримт бичгийг ирүүлнэ:

16.2.1. хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ, түүнийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг тодорхойлох баримт бичиг;

16.2.2. гадаадын иргэн, харьяалалгүй хүн бол паспорт, түүнийг орлох баримт бичиг;

16.2.3. тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар тухайн улсын хуулиар татварын хугацаа хэтэрсэн өргүй болохыг нотлох баримт бичиг.

16.3. Захиалагч оролцогчийн ерөнхий нөхцөлийг магадлах зорилгоор зөвхөн ТШЗ-ны 16.1, 16.2.2-т заасан баримт бичгээс бусад баримт бичгийг ирүүлэхийг оролцогчоос шаардахгүй ба шаардлагатай бусад нөхцөлийг оролцогчийн ирүүлсэн мэдэгдэл, хуулийн 15.2-т заасан мэдээлэлд үндэслэн магадална.

16.4. Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1, 16.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.

17. Чадавхын болон туршлагын шаардлага

17.1. Захиалагч ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлага тогтооход хуулийн 15 дугаар зүйлийг баримтална.

17.2. Хуулийн 15.2-т заасан цахим системээр дамжуулан шалгах боломжтой, олон нийтэд нээлттэй мэдээллийг нотлох баримтаар ирүүлэхгүй.

17.3. Түншлэлийн хувьд төлөөлөх эрх бүхий гишүүн, гишүүн хамтдаа ТШЗ-ны 18, 19-д заасан чадавхын болон туршлагын шаардлагыг бүрэн хангасан байна.

17.4. Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн ТШЗ-ны 18, 19-д чадавхын болон туршлагын шаардлагын 40-аас дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байна.

17.5. Туслан гүйцэтгэгч нь энэ зүйлд заасан шаардлага, шалгуур үзүүлэлтийн өөрт холбогдох хэсгийг хангаж байгааг нотлох баримт бичгийг тендерт ирүүлнэ.

18. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт

18.1. Хуулийн 16.5-д зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан санхүүгийн чадавхын шаардлага хангасан байна.

18.2. Санхүүгийн чадавхын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 16.2, 16.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

18.3. Оролцогчийн дансны мэдээлэл, түүний үлдэгдлийн талаар харилцагч банкны мэдэгдлээс бусад банк, санхүүгийн байгууллагын мэдэгдлийг оролцогчийн санхүүгийн чадавхыг хянан үзэхэд харгалзан үзэхгүй. Захиалагч энд зааснаас бусад асуудлаар харилцагч банкны тодорхойлолт ирүүлэхийг шаардахгүй.

18.4. Монгол Улсын хуулийн этгээдийн банк, санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх

талаар лавлагааг Зээлийн мэдээллийн тухай хуулийн 4.1.5-д заасан этгээдээс цахим системээр авч, тендерт ирүүлэх ба уг асуудлаар банк, санхүүгийн байгууллагаас лавлагаа ирүүлэхийг шаардахгүй.

19. Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт

19.1.Хуулийн 17.4-т зааснаар оролцогч өгөгдлийн хүснэгтэд заасан техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангасан байна.

19.2.Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг хангах нотлох баримт ирүүлэхийг захиалагч шаардах бол хуулийн 17.2.1, 17.2.3, 17.2.4-т заасан баримт бичгээс сонгож өгөгдлийн хүснэгтэд заана.

19.3.Үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай зөвшөөрөл, эсхүл гэрчилгээ байгаа бол өгөгдлийн хүснэгтэд заана.

19.4.ТШЗ-ны 19.3-т заасан тусгай зөвшөөрлийн шаардлагыг түншлэлийн гишүүн тус бүр хангасан байна. Хэд хэдэн зөвшөөрөл, гэрчилгээ шаардсан бол түншлэлийн гишүүд хамтдаа бүрэн хангасан байна.

20. Санал болгож буй үйлчилгээ шаардлагад нийцсэнийг нотлох баримт бичиг

20.1.Санал болгож буй үйлчилгээ нь III бүлэгт заасан техникийн тодорхойлолт, тавигдах шаардлагад нийцсэнийг нотлох баримтыг тендерт ирүүлнэ.

20.2.III бүлэгт заасан техникийн тодорхойлолтын аль нэг зүйлээс зөрүүтэй, орхигдуулсан бол энэ тухай тайлбарыг ирүүлнэ.

20.3.Үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор тендер шалгаруулалтад оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдээс бараа, үйлчилгээ авахаар санал болгосон бол шаардлагад нийцэхгүй гэж үзнэ.

21. Тендерийн үнэ ба үнийн хөнгөлөлт

21.1.Оролцогчийн санал болгож буй үнэ, үнийн хөнгөлөлт нь энэ зүйлд заасан шаардлагад нийцсэн байна.

21.2.Үнийн задаргаанд тусгайлан тусгасан эсэхээс үл хамааран тендерийн үнэд хуулийн 27.13-т заасан зардлыг багтсанд тооцно.

21.3.Үнийн хөнгөлөлт санал болговол үнийн хөнгөлөлт тооцсоны дараах үнийг “тендерийн үнэ” гэж үзнэ.

21.4.Хууль болон өгөгдлийн хүснэгтэд өөрөөр заагаагүй бол оролцогчийн санал болгосон үнэ нь гэрээний хэрэгжилтийн явцад тогтмол байх бөгөөд тохируулга хийхгүй. Тохируулга хийх нөхцөлтэй үнэ санал болгосон тендерийг шаардлага хангаагүй гэж үзнэ. Өгөгдлийн хүснэгтэд үнийн тохируулга хийхийг зөвшөөрсөн тендер шалгаруулалтад тогтмол үнэ санал болгосон тендер ирүүлсэн нь тендерээс татгалзах үндэслэл болохгүй ба үнийн тохируулга нь гэрээний хэрэгжилтийн явцад тэгтэй тэнцүү гэж үзнэ.

21.5.Хуулийн 21.5-д заасан тохиолдолд тендер шалгаруулалтын оролцогчийн тендерийн үнэ төсөвт өртгийн 80 хувиас доош бол уг үнэ нь үйлчилгээний хамрах хүрээ, чанар болон гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхгүй талаар үндэслэл бүхий тайлбарыг тендерт

ирүүлнэ.

22. Тендерийн валют

22.1. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тендерийн үнийг Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай хуулийн 4.1, 4.2-т заасны дагуу үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэхээр заана.

23. Тендер хүчинтэй байх хугацаа

23.1. Оролцогч хуулийн 21.1.1-д заасны дагуу тендер нээснээс хойш өөрийн тендер хүчинтэй байх хугацааг ажлын 30-аас багагүй өдөр байхаар маягт 1-д заана.

23.1. Захиалагч хуулийн 28.8-д зааснаар тендер хүчинтэй байх хугацаа сунгах хүсэлт гаргасан бол оролцогч өөрийн ТШЗ-ны 23.1-д заасан хугацааг сунгаж болно.

23.2. Оролцогч тендерийн хүчинтэй байх хугацааг сунгасан бол ТШЗ-ны 24-т заасан тендерийн баталгааны хүчинтэй байх хугацаа мөн адил тендерийн баталгааны нөхцөлийн дагуу сунгагдахыг баталгаа гаргагч болон оролцогч хариуцна.

23.3. Хуулийн 32.5-д зааснаар тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж буй тохиолдолд оролцогчийн тендерийн хүчинтэй байх хугацаа нь тухайн ажлын санхүүжилтийн эх үүсвэр батлагдсаны дараа гэрээ байгуулах хүртэл хугацаанд хүчинтэй байхаар заана.

24. Тендерийн баталгаа

24.1. Захиалагч хуулийн 14.1-д заасан тохиолдолд төсөвт өртгийн 0.5 хувиар тооцсон “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцсэн тендерийн баталгаа ирүүлэхийг өгөгдлийн хүснэгтэд заана.

24.2. Хуулийн 14.6-д зааснаар дараах тохиолдолд тендерийн баталгааг хуульд заасан хувь, хэмжээгээр улсын орлого болгоно. Үүнд:

24.2.1. ТШЗ-ны 23-т заасан тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө өөрийн тендерээс бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн татгалзсан;

24.2.2. гэрээ байгуулах эрх авсан оролцогч гэрээ байгуулах, эсхүл гүйцэтгэлийн баталгаа ирүүлээгүй;

24.2.3. Захиалагчийн шийдвэртэй холбогдуулан Сангийн яаманд гаргасан гомдлыг бүхэлд нь үндэслэлгүй гэж шийдвэрлэсэн.

24.3. Тендер шалгаруулалтыг багцад хуваасан бол тендерийн баталгааг багц тус бүрд ирүүлнэ.

24.4. Түншлэлийн хувьд түүнийг төлөөлөх эрх бүхий гишүүн тендерийн баталгааг ирүүлнэ.

Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ

25. Тендер баталгаажуулах, илгээх

25.1. Тендерийг хуулийн 22.1-д зааснаар баталгаажуулан, тендерийн баталгаа шаардсан тохиолдолд тендерийн баталгааг ТШЗ 24-т зааснаар илгээнэ.

25.2. ТШЗ-ны 25.1-д заасны дагуу баталгаажуулсан этгээд оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд бол итгэмжлэл ирүүлэх шаардлагагүй.

25.3. Оролцогчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд тендерийг тоон гарын үсгээр баталгаажуулсан бол

V бүлэгт заасан маягтыг ТШЗ-ны 25.1-д зааснаар тамга, тэмдгээр баталгаажуулсан гэж үзнэ. Энэ тохиолдолд маягтыг баталгаажуулахтай холбоотой итгэмжлэл үйлдэх, хуулийн этгээдийн тамга, тэмдгээр баталгаажуулахыг шаардахгүй.

25.4. Оролцогч хуулийн 22.5-д заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг ил болгохгүйгээр илгээх бол хуулийн 22.6.3-т заасан мэдэгдлийг V бүлгийн 07-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.

25.5. Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь тус баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ.

26. Тендер хүлээн авах эцсийн хугацаа

26.1. Тендер хүлээн авах эцсийн хугацааг өгөгдлийн хүснэгтэд заана. Огноо, цагийг цахим системийн серверийн цагаар тооцно.

26.2. Захиалагч тендерийн нээлтийг цахим системээр өгөгдлийн хүснэгтэд заасан огноо, цагт зохион байгуулна. Тендерийн нээлтэд оролцогч, эсхүл түүний төлөөлөгч байлцах эрхтэй.

Д. ЗАХИАЛАГЧ ШИЙДВЭР ГАРГАХ

27. Тендерийн талаар тодруулга авах

27.1. Захиалагч тендерийн талаар тодруулга авах тохиолдолд хуулийн 25 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

28. Тендерийг шаардлагад нийцсэн эсэхийг хянан үзэх

28.1. Тендерийг хянан үзэхэд хуулийн 26 дугаар зүйлд заасан журам, ТШЗ-ны 13-т заасан тендерийн иж бүрдэл, холбогдох мэдээллийн сангаас илгээсэн мэдээлэл, оролцогч болон түүний тендерийн талаар авсан тайлбар, тодруулгад үндэслэн хянан үзнэ.

29. Тендерийг үнэлэх

29.1. Захиалагч тендерийг хуулийн 27 дугаар зүйл, Сангийн сайдын “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-ын дагуу үнэлж, харьцуулна.

30. Арифметик алдааг залруулах

30.1. Тендерийн үнийн арифметик алдааг “Тендер үнэлэх, давуу эрх олгох аргачлал, заавар”-т зааснаар залруулна.

30.2. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу арифметик алдааг залруулсан тухай мэдээллийг оролцогчид хүргүүлнэ.

31. Үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт

31.1. Өгөгдлийн хүснэгтэд заасан бол IV бүлэгт заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж, харьцуулах үнийг хийсвэрээр нэмэгдүүлнэ.

32. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлох

32.1. Тендерийн харьцуулах үнийг тодорхойлоход дараах дарааллыг баримтална:

32.1.1. ТШЗ-ны 21.1-д зааснаар санал болгосон тендерийн үнийг тогтоох;

32.1.2. ТШЗ-ны 21.3-д заасны дагуу санал болгосон

үнийн хөнгөлөлт тооцох;

32.1.3. ТШЗ-ны 30.1-д заасны дагуу тендерийн үнэд хийсэн арифметик алдааг залруулах;

32.1.4. ТШЗ-ны 29.1.1, 29.1.2, 29.1.3-т заасан үнийг шаардлагатай бол ТШЗ-ны 22.1-д заасан валютад хөрвүүлэх;

32.1.6. ТШЗ-ны 31.1-д заасан үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлж тооцох.

32.2. ТШЗ-ны 1.2-т заасны дагуу хоёр ба түүнээс дээш багцтай тендер шалгаруулалтад хэд хэдэн багцад хамтад нь хамгийн бага харьцуулах үнэ санал болгосон тендерийг тодорхойлох, түүнд санал болгосон үнийн хөнгөлөлтийг тооцохдоо дараах аргачлалыг баримтална:

32.2.1. багц тус бүрийн хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг сонгох;

32.2.2. хоёр ба түүнээс дээш багцад гэрээ байгуулах эрх авсан тохиолдолд үнийн хөнгөлөлт үзүүлэхээр санал болгосон тендерийн үнээс уг үнийн хөнгөлөлтийг тендер илгээх маягтад тодорхойлсон аргачлалын дагуу тооцсоны дараа шаардлагатай бол түүний харьцуулах үнийг дахин тодорхойлно. Ийнхүү тодорхойлохдоо хоёр ба түүнээс дээш багцад хамгийн бага харьцуулах үнэтэй тендер ирүүлсэн этгээд нь ТШЗ-ны 34-д зааснаар дахин магадлахад шаардлага хангаж байхыг шаардана;

32.2.3. дээрх үнэлгээг хийсний дараа тендерийн харьцуулах үнэд үндэслэн захиалагч гэрээ байгуулах эрхийг нэг багцад, хэд хэдэн багцад, эсхүл бүх багцад олгох хувилбаруудыг тооцож, гэрээний үнийн нийлбэр нь хамгийн бага байх хувилбарыг сонгох.

32.3. ТШЗ-ны 15.1-д зөвшөөрсний дагуу хувилбарт санал ирүүлсэн тендер “хамгийн сайн” гэж үнэлэгдсэн бол түүний хувилбарт саналыг хянан үзэж, үнэлнэ.

32.4. ТШЗ-ны 32.3-т зааснаар тендерийн саналын хувилбарыг хянан үзэх, үнэлэхэд үндсэн тендерийг үнэлсэн журмыг баримтална.

33. Тендерийг эрэмбэлэх

33.1. Захиалагч тендерүүдийг эрэмбэлэхэд хуулийн 27.5, 27.6-д заасныг баримтална.

34. Оролцогчийн чадавхыг дахин магадлах

34.1. Захиалагч хэд хэдэн багцад хамгийн сайн үнэлэгдсэн тендер ирүүлсэн оролцогчийг тэдгээр багцад заасан гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхтай эсэхийг, мөн санал болгосон хүний нөөц, тоног төхөөрөмжийн мэдээлэл өөр бусад төсөл, арга хэмжээний мэдээлэлтэй давхацсан тохиолдолд дахин магадална.

II БҮЛЭГ. ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

34.2. ТШЗ-ны 34.1-д заасны дагуу дахин магадлахад зөвхөн ТШЗ-ны 18.1-д заасан санхүүгийн чадавх, ТШЗ-ны 19.1-д заасан техникийн чадавх, туршлага, гэрээний үүрэг гүйцэтгэх чадавхын шаардлага, шалгуур үзүүлэлтийг хангах эсэхийг тендер хянан үзэхэд ашигласан баримт бичиг, мэдээлэлд үндэслэнэ.

34.3. Оролцогчийн чадавхыг дахин магадалж, хуулийн 27.10-т зааснаар гэрээ байгуулах эрх олгоно.

Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ

35. Мэдэгдэл хүргүүлэх

35.1. Захиалагч хуулийн 28 дугаар зүйлд заасан шийдвэрийг хуулийн 24.1-д зааснаар ажлын 15 өдрийн дотор гаргаж, оролцогчдод мэдэгдэнэ.

36. Гүйцэтгэлийн баталгаа

36.1. Хуулийн 42.1-д заасан тохиолдолд гэрээ байгуулах эрх авсан оролцогч тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн гурван хувийн үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ.

36.2. Гүйцэтгэлийн баталгаа, урьдчилгаа төлбөрийн баталгааг “Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам”-д нийцүүлэн гаргана.

37. Урьдчилгаа төлбөр

37.1. Гэрээг хэрэгжүүлж эхлүүлэхтэй холбогдох зардалд урьдчилгаа төлбөр олгохгүй.

38. Гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах

38.1. Захиалагч VI бүлгийн гэрээний нөхцөлийн гэрээ баталгаажуулах маягыг түүнд заасан зааврын дагуу шаардлагатай хэсгийг эцэслэн нөхөж, оролцогчид хүргүүлнэ.

38.2. Захиалагч тендер шалгаруулалтын үр дүнд нийлүүлэгчтэй гэрээ байгуулахад тендер шалгаруулалтын баримт бичгийн VI бүлэг дэх гэрээний нөхцөлийг баримтална.

38.3. Шалгарсан оролцогч ТШЗ-ны 38.1-д зааснаар ирүүлсэн гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан захиалагчаас шаардсан хугацааны дотор хүргүүлнэ.

38.4. Захиалагч хуулийн 30.4-т зааснаар ажлын 10 өдрийн дотор гэрээг баталгаажуулаагүй бол гэрээ байгуулах шийдвэрт заасан нөхцөлөөр гэрээ байгуулсанд тооцогдоно.

39. Тендер шалгаруулалтын гомдол

39.1. Хууль болон Сангийн сайдын баталсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-ын дагуу гомдлыг хянан шийдвэрлэнэ.

ТШЗ-ны холбогдох заалт	А. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ
ТШЗ 1.1	Захиалагч: "Эрдэнэс Оюу Толгой" ХХК
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын нэр: "Хэрлэн Тооно" төслийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах
ТШЗ 1.1	Тендер шалгаруулалтын зарлалын дугаар: ЭОТХХК/20240101004
ТШЗ 1.2	Тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: "Багцгүй"
ТШЗ 1.3	Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: "Үгүй"
ТШЗ 2.1	Санхүүжилтийн эх үүсвэр нь: "Оюу Толгой" ХХК
ТШЗ 3.1	Нийт төсөвт өртөг: 10,143,960,000.0 (Арван тэрбум нэг зуун дөчин гурван сая есөн зуун жаран мянга) төгрөг Үүнээс 2024 онд санхүүжих дүн: 4,057,584,000.0 (Дөрвөн тэрбум тавин долоон сая таван зуун наян дөрвөн мянга) төгрөг Шалгарсан оролцогчтой гэрээ байгуулах үед тухайн онд санхүүжих дүнд өөрчлөлт оруулж болно.
ТШЗ 6.5	Тендер шалгаруулалтад оролцох гадаадын этгээд үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу эцсийн өмчлөгчөөр бүртгэгдсэн этгээдийн мэдээллийг ирүүлнэ.
ТШЗ 7.1	Тендерт ирүүлэх түншлэлийн гэрээ, туслан гүйцэтгүүлэх гэрээ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан шаардлага хангасан байна.
ТШЗ 7.3	Түншлэлийн болон туслан гүйцэтгэгчийн хувиар оролцохыг зөвшөөрсөн болохыг түншлэлийн гишүүн болон туслан гүйцэтгэгч цахим системээр баталгаажуулсан байна.
ТШЗ 7.4	ТШЗ-ны 7.3-т заасан нь гадаадын этгээд түншлэлийн гишүүн, эсхүл туслан гүйцэтгэгчээр ороход хамаарахгүй.
Б. АГУУЛГА	
ТШЗ 9.1	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хаяг: Хүлээн авагчийн нэр: "Эрдэнэс Оюу Толгой" ХХК Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Блю ская цамхаг 8 дугаар давхар, 803 тоот. Утасны дугаар: 7007 8085 Цахим шуудангийн хаяг: tender.gov.mn Сонирхогч этгээд тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээллийг тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5-аас доошгүй хоногийн өмнө захиалагчаас авах хүсэлтийг бичгээр эсхүл тоон гарын үсгээр баталгаажуулан цахимаар гаргаж болно.

	<p>Тендерийн баримт бичгийн тодруулга, нэмэлт мэдээлэлтэй холбогдуулан захиалагч тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 2-оос доошгүй хоногийн өмнө тендерийн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт оруулах, тендер хүлээн авах эцсийн хугацааг сунгах эрхтэй ба энэ нь тендерийн баримт бичгийн салшгүй нэг хэсэг байна.</p> <p>Захиалагч тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийн хариуг хүсэлт гаргагчийн нэрийг дурдалгүйгээр хүсэлтийг тодруулгын хамт албан бичгээр гаргаж Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) дэх тендер шалгаруулалтын баримт бичгийн “тодруулга” хэсэгт нийтэлнэ. Ийнхүү нийтэлсэн даруйд тус тодруулга, нэмэлт мэдээллийг бүх сонирхогч этгээдүүдэд нэгэн зэрэг хүргүүлсэнд тооцно.</p> <p>Сонирхогч этгээд тендер шалгаруулалтын баримт бичгийн салшгүй хэсэг болох тодруулга, нэмэлт, өөрчлөлтийг тендер хүлээж авах эцсийн хугацаа хүртэл шалган нягталж, түүнд нийцүүлэн тендер бэлтгэх үүрэгтэй.</p>
ТШЗ 10.1	Тендер ирүүлэхийн өмнөх уулзалт зохион байгуулах эсэх: “Үгүй”
В. ТЕНДЕР БЭЛТГЭХ	
ТШЗ 12.1	<p>Тендер шалгаруулалтын хэл: “Монгол хэл”</p> <p>Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер Монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг баталгаат орчуулгын төвөөр орчуулж тендерт бэлтгэн ирүүлнэ. Орчуулсан материалд олон улсын мэргэжлийн хэллэг, техник хэллэг, стандарт норм, нормативын нэршлийг олон улсад зөвшөөрөгдсөн нэр томъёогоор ирүүлнэ.</p>
ТШЗ 12.1	Тендер оролцогч Үнийн саналыг энэ тендерийн баримт бичгийн V бүлэгт заасан Маягт-1-ийн мэдээллийг бөглөж, илгээнэ.
ТШЗ 13.2.2	<p>Оролцогчийн итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдээс өөр этгээд тендерийг баталгаажуулсан бол холбогдох хууль тогтоомжид нийцүүлсэн олгосон итгэмжлэл /гадаадын этгээдийн хувьд итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрхтэй этгээдийг нотлох баримт/;</p> <p><i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./</i></p>
ТШЗ 15.1	Хувилбарт санал ирүүлэхийг: “Зөвшөөрөхгүй”
ТШЗ 16.1.2	<p>Ерөнхий шаардлагыг магадлахад шаардагдах бусад баримт бичиг: “Шаардана”</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлэх шаардлагагүй бөгөөд “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгана. <p><i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх</i></p>

	<p><i>баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./</i></p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсын, эсхүл байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, нийгмийн даатгалын хураамж, төлбөрөө тухайн тендер зарласнаас хойших өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. - Монгол Улсын хуулийн этгээд Нийгмийн даатгал, татварын тодорхойлолтыг ирүүлэх шаардлагагүй, “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn болон “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан Татварын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас шалгана. <p><i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар, нийгмийн даатгалын хураамж, төлбөрөө төлсөн болохыг нотлох баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./</i></p> <ul style="list-style-type: none"> - “Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем” www.tender.gov.mn -ээр дамжуулан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын тодорхойлолт ирүүлнэ. Анхааруулга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авах хүсэлтийг тендерт оролцогч Худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-д өөрийн үндэсний тоон гарын үсэг ашиглан тендерийн нээлтээс өмнө хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэг сонгож цахим хэлбэрээр ирүүлнэ. Түншлэлээр оролцож буй тохиолдолд түншлэлийн төлөөлөх эрх бүхий этгээд нь түншлэлийн гэрээг цахим системд баталгаажуулсны дараа гишүүн этгээдийн хүчин төгөлдөр тодорхойлолтыг тендер илгээх холбогдох хэсэгт сонгож илгээнэ. <p><i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./</i></p>
ТШЗ 16.4	Түншлэлийн гишүүн тус бүр ТШЗ-ны 16.1.2-т заасан баримт бичиг ирүүлнэ.
ТШЗ 17.4	<p>Тендер шалгаруулалтад түншлэлээр оролцож байгаа тохиолдолд түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн Санхүүгийн чадавхын шаардлага ТШЗ 18.1.</p> <p>Түншлэлийн төлөөлөх эрх бүхий гишүүн техникийн чадавх болон туршлагын шаардлага ТШЗ 19.1-д заасан чадавхын болон туршлагын шаардлагын 40-өөс дээш хувийг, түншлэлийн гишүүн тус бүр 25 ба түүнээс дээш хувийг хангасан байх шаардлагатай.</p> <p>Оролцогч тендерийн үнийн 20 хүртэл хувийг нэг, эсхүл түүнээс дээш тооны этгээдээр туслан гүйцэтгүүлэхээр санал ирүүлж болно.</p> <p>Тендерт оролцогчийн дэлгэрэнгүй танилцуулгыг ирүүлнэ.</p>
ТШЗ 18.1	Санхүүгийн чадавхын шаардлага: “Шаардана”

	<ul style="list-style-type: none"> - Борлуулалтын орлогын хэмжээ: Сүүлийн 3 жил (2021, 2022, 2023 он)-ийн борлуулалтын орлогын нийт хэмжээ нь төсөвт өртгийн 30 хувь буюу 3,043,188,000 төгрөгөөс багагүй байна. - Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээ: Батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй байна. - Өр төлбөртэй холбогдох шаардлага: Банк санхүүгийн байгууллагад тендер шалгаруулалт зарласнаас хойших өдрийн байдлаар хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байна. <i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./</i> 												
<p>ТШЗ 18.2</p>	<p>Санхүүгийн чадавхыг хянан үзэхэд үндэслэл болгох баримт бичиг:</p> <ol style="list-style-type: none"> 1. Санхүүгийн тайланг өөрийн тендертээ хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим системээр дамжуулан Сангийн яамны цахим санхүүгийн тайлангийн www.e-balance.mof.gov.mn мэдээллийн системээс тендерт оролцогчдын санхүүгийн тайлангаас сүүлийн 3 жилийн борлуулалтын орлого, болон бусад шаардлагатай мэдээллийг шалгана. 2. Түргэн хөрвөх хөрөнгийн хэмжээг нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийн аль нэгээр эсвэл нийлбэрээр тодорхойлно. Үүнд: <ul style="list-style-type: none"> - Тендерт оролцогчийн харилцагч банкны дансны үлдэгдэл; - Харилцагч банкнаас авч болох мөнгөн дүн бүхий зээлийн тодорхойлолт ирүүлнэ. /судлан үзэх боломжтой гэх мэт банканд бодитой санхүүгийн үүрэг хүлээлгээгүй тодорхойлолтыг үнэлгээнд харгалзан үзэхгүй/ 3. Тендерт оролцогч нь хугацаа хэтэрсэн зээлийн өр төлбөргүй талаар харилцагч банк тус бүрээс тодорхойлолт ирүүлэх. /Ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно/ <p><i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан дээрх баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./</i></p>												
<p>ТШЗ 19.1</p>	<p>Техникийн чадавх болон туршлагын шаардлага: “Шаардана”</p> <p>Үйлчилгээ үзүүлэх хүний нөөц: “Шаардана”</p> <ol style="list-style-type: none"> 1. Зөвлөхийн санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод төвшин: <table border="1" data-bbox="443 1765 1481 2065"> <thead> <tr> <th data-bbox="443 1765 507 1854">№</th> <th data-bbox="507 1765 667 1854">Албан тушаал</th> <th data-bbox="667 1765 778 1854">Тоо</th> <th data-bbox="778 1765 970 1854">Мэргэжил</th> <th data-bbox="970 1765 1161 1854">Боловсрол, мэргэжлийн ур чадвар</th> <th data-bbox="1161 1765 1481 1854">Туршлага</th> </tr> </thead> <tbody> <tr> <td data-bbox="443 1854 507 2065">1</td> <td data-bbox="507 1854 667 2065">Багийн ахлагч</td> <td data-bbox="667 1854 778 2065">1</td> <td data-bbox="778 1854 970 2065">Усны барилга байгууламжийн буюу Гидротехникийн инженер</td> <td data-bbox="970 1854 1161 2065">Мэргэжлээр ээ магистр болон түүнээс дээш зэрэгтэй,</td> <td data-bbox="1161 1854 1481 2065">- Төслийн удирдагч нь тухайн салбарт усны барилга байгууламжийн чиглэлээр 20-иос доошгүй жил, усны</td> </tr> </tbody> </table>	№	Албан тушаал	Тоо	Мэргэжил	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Туршлага	1	Багийн ахлагч	1	Усны барилга байгууламжийн буюу Гидротехникийн инженер	Мэргэжлээр ээ магистр болон түүнээс дээш зэрэгтэй,	- Төслийн удирдагч нь тухайн салбарт усны барилга байгууламжийн чиглэлээр 20-иос доошгүй жил, усны
№	Албан тушаал	Тоо	Мэргэжил	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Туршлага								
1	Багийн ахлагч	1	Усны барилга байгууламжийн буюу Гидротехникийн инженер	Мэргэжлээр ээ магистр болон түүнээс дээш зэрэгтэй,	- Төслийн удирдагч нь тухайн салбарт усны барилга байгууламжийн чиглэлээр 20-иос доошгүй жил, усны								

					зөвлөх инженер байх	инженеринг, төлөвлөлтийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ТЭЗҮ-ийн төслийг удирдаж байсан туршлагатай байх - Ижил төстэй төслүүдийг удирдаж байсан туршлагатай байх, - Төсөлтэй холбоотой усны инженеринг, техник, технологийн талаар хэрэгжүүлсэн туршлагатай байх,
2	Багийн ахлагчийн орлогч	1	Усны барилга байгууламжийн буюу Гидротехникийн инженер	Мэргэжлээр ээ магистр болон түүнээс дээш зэрэгтэй, зөвлөх инженер байх	- Багийн ахлагчийн орлогч нь тухайн салбарт усны барилга байгууламжийн чиглэлээр 20-иос доошгүй жил, усны инженеринг, төлөвлөлтийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ТЭЗҮ-ийн төсөлд оролцож байсан туршлагатай байх, - Төсөлтэй холбоотой усны инженеринг, техник, технологийн талаар хэрэгжүүлсэн туршлагатай байх	
3	Санхүү, эдийн засгийн судалгааны багийн ахлагч	1	Санхүү, эдийн засагч	Мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх	- Багийн ахлагч нь 10-аас доошгүй жил санхүү, эдийн засаг, менежментийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай байх, - Төсөлтэй холбоотой олон улсад болон Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төслүүд дээр удирдаж ажиллаж байсан туршлагатай байх	
4	Санхүү, эдийн засгийн судалгаан	1	Санхүү, эдийн засагч	Мэргэжлээр бакалавр ба түүнээс	- Багийн ахлагчийн орлогч нь 10-аас доошгүй жил санхүү,	

		ы багийн ахлагчийн орлогч			дээш зэрэгтэй байх	эдийн засгийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай байх, - Төсөлтэй холбоотой олон улсад болон Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төслүүд дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх
	5	Инженер техникийн судалгааны багийн ахлагч	1	Усны барилга байгууламжийн инженер	Мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх	- Багийн ахлагч нь 10-аас доошгүй жил усны инженеринг, томоохон боомтын төлөвлөлт, ус дамжуулах хоолойн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай байх, - Төсөлтэй холбоотой олон улсад болон Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төслүүдийг удирдаж, оролцож байсан туршлагатай байх
	6	Инженер техникийн судалгааны багийн орлогч	1	Усны барилга байгууламжийн инженер	Мэргэжлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх	- Багийн ахлагч нь 10-аас доошгүй жил усны инженеринг, томоохон боомтын төлөвлөлт, ус дамжуулах хоолойн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай байх, - Төсөлтэй холбоотой олон улсад болон Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төслүүдийг удирдаж, оролцож байсан туршлагатай байх
	7	Эдийн засагч	1	Эдийн засагч	Мэргэжлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх	- Эдийн засагч нь 10-аас доошгүй жил санхүү, эдийн засгийн чиглэлээр төсөл хөтөлбөр

						<p>хэрэгжүүлж байсан туршлагатай байх,</p> <ul style="list-style-type: none"> - Төсөлтэй холбоотой олон улсад болон Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй томоохон төслүүд дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх.
8	Төсөвчин	1		Төсвийн чиглэлээр мэргэшсэн ба түүнээс дээш зэрэгтэй байх.	<ul style="list-style-type: none"> - Тэргүүлэх төсөвчин нь 10-аас доошгүй жил тухайн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай байх, - Төсөлтэй холбоотой олон улсад болон Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй томоохон төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх, - Гүйцэтгэгч, хөрөнгө оруулагч нарын хүсэлт захиалгаар мөрдөж буй барилгын норм дүрэм, арга зүйн дагуу төсөв зохиож, барилга объектын ертгийг тодорхойлох хэлцлийн үнийг тооцох чиглэлээр мэргэшсэн байх 	
9	Санхүүгийн мэргэжилтэн	2	Санхүү, эдийн засагч	Санхүүгийн чиглэлээр бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй байх.	<ul style="list-style-type: none"> - Мэргэжилээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Олон улс болон Монгол улсад хэрэгжүүлсэн төслүүдэд санхүүгийн дүн шинжилгээ хийж ажилласан туршлагатай байх 	
10	Хуульч	1	Хуульч	Магистр ба түүнээс дээш зэрэгтэй,	<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил 	

					хуульч мэргэшилтэй байх.	ажилласан туршлагатай байх,
11	Гидрогеологич инженер	2	Гидрогеологич	Гидрогеологич мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх.		<ul style="list-style-type: none"> - Олон улс болон Монгол улсад газар доорх усны хайгуул судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Газрын доорх усны загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх.
12	Гидрологич	2	Гидрологич, ус зүйч	Магистр ба түүнээс дээш зэрэгтэй		<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх. - Гадаргын усны тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх
13	Усны барилга байгууламжийн инженер	2	Усны барилга байгууламжийн буюу Гидротехникийн инженер	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэшсэн инженер байх		<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Усны дэд бүтцийн төслүүд дээр ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх, - Усны төрөл бүрийн барилгын гидравлик тооцоо, гидравлик загварын туршилт, хийцийн загварын туршилт дээр ажиллаж байсан туршлагатай байх
14	Ус хангамжийн инженер	2	Ус хангамжийн инженер	Бакалавр болон түүнээс дээш		<ul style="list-style-type: none"> - Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил

					зэрэгтэй, мэргэшсэн инженер байх	ажилласан туршлагатай байх, - Ус хангамжийн чиглэлээр ижил төстэй төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх
	15	Усан сан төлөвлөл тийн инженер	1	Усны барилга байгууламж ийн буюу Гидротехник ийн инженер	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэшсэн инженер байх	- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх, - Инженерийн тооцоо, аргачлалын сонголтыг хийх чадвартай байх
	16	Боомт болон ус хуримтлу улах сангийн төлөвлөл тийн инженер	2	Усны барилга байгууламж ийн буюу Гидротехник ийн инженер	Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй, мэргэшсэн инженер байх	- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх, - Инженерийн тооцоо, аргачлалын сонголтуудыг хийх чадвартай байх
	17	Инженер геологич	1	Инженер геологич	Магистр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төслийн геологийн хайгуул, судалгааны чиглэлээр ажилласан туршлагатай байх, - Инженерийн тооцоо, аргачлалын сонголтуудыг хийх чадвартай байх
	18	Геодезий н инженер	1	Геодезийн инженер	Магистр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төслийн геодезийн чиглэлээр

						ажилласан туршлагатай байх, - Геодезийн хайгуул, судалгаа боловсруулалт хийх чадвартай байх
19	Загас судлаач	1	Загас судлаач			- Мэргэжлийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх, - Загас үржүүлэх ажлын туршлагатай байх
20	Хөрс судлаач	1	Хөрс судлаач		Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх, - Хөрс судлаач чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх
21	Барилгын инженер	1	Иргэний ба үйлдвэрийн барилгын инженер		Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх, - Барилгын инженерийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх
22	Автозамын инженер	1	Автозамын инженер		Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлийн чиглэлээр 5-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, - Ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байх, - Замын инженерийн чиглэлээр ажиллаж байсан туршлагатай байх
23	Механик инженер	1	Механик инженер		Бакалавр ба түүнээс	- Мэргэжлийн чиглэлээр 5-аас

				дээш зэрэгтэй	доошгүй ажилласан туршлагатай байх	жил
24	Цахилгааны инженер	1	Цахилгааны инженер	Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлийн чиглэлээр доошгүй ажилласан туршлагатай байх	5-аас жил
25	Автоматикийн инженер	1	Автоматикийн инженер	Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлийн чиглэлээр доошгүй ажилласан туршлагатай байх	5-аас жил
26	Газарзүй мэдээллийн системийн инженер	1	Газарзүй мэдээллийн системийн инженер	Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлийн чиглэлээр доошгүй ажилласан туршлагатай байх	5-аас жил
27	Зургийн техник	1	Усны барилга байгууламжийн инженер	Бакалавр ба түүнээс дээш зэрэгтэй	- Мэргэжлийн чиглэлээр доошгүй ажилласан туршлагатай байх	5-аас жил

Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн:

- Багийн ахлагч,
- Инженерийн техникийн судалгааны багийн ахлагч,
- Боомт болон ус хуримтлуулах сангийн төлөвлөлтийн инженерийн аль нэг нь,
- Усан сан төлөвлөлтийн инженер,
- Ус хангамжийн инженерийн аль нэг нь,
- Усны барилга байгууламжийн инженерийн аль нэг нь үндсэн ажилтан байна.

Бусад санал болгож буй ажилтан нь үндсэн болон гэрээт байж болно.

2. Үйлчилгээ үзүүлэхэд ашиглагдах үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгсэл: **“Шаардахгүй”**
3. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн туршлага: **“Шаардана”**
Сүүлийн 3 жил буюу 2021, 2022, 2023 онуудын нийлбэр нь батлагдсан төсөвт өртгийн 30 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагатай байна.
Ижил төстэй ажил гэдэгт усан сан, алсын зайд ус дамжуулах шугам болон усан цахилгаан станцын ТЭЗҮ боловсруулж, батлуулж байсан туршлагыг тооцно.
4. Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх шаардлага: **“Шаардана”**
Тендерт оролцогч Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэх эрх авсан ижил төстэй ажил, үйлчилгээний гэрээний талаарх мэдээллийг энэ тендерийн баримт бичгийн V бүлэгт заасан Маягт 4-ийн дагуу мэдээллийг бөглөж, илгээнэ.
/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./

ТШЗ 19.2

Техникийн чадавх болон туршлагын шаардлагыг нотлох баримт бичиг:

1. Үйлчилгээ үзүүлэх хүний нөөцийн шаардлагыг нотлох дараах баримт бичиг ирүүлнэ.

- Тендерт оролцогчийн үндсэн ажилтан, хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллах ажилтны мэдээллийг V бүлэгт заасан маягтын дагуу гаргаж, тэдгээрийн ажлын туршлагыг ажилтан тус бүрээр ирүүлнэ.
- Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим систем /www.tender.gov.mn/-ээр дамжуулан санал болгоно. Цахим системээр санал болгоогүй тохиолдолд хянан үзэхгүй. (Хүний нөөцийн мэдээллийг худалдан авах ажиллагааны цахим систем www.tender.gov.mn-ээр дамжуулан илгээх зааварчилгааг хэрэглэгчийн хөтөч хэсэгт орж танилцана уу.)
- Санал болгож буй ажилтны сургууль төгссөн дипломын хуулбарыг ирүүлэх шаардлагагүй, төрийн мэдээлэл, солилцооны ХУР системээр дамжуулан Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллийн сангаас шалгана. (Тендерт оролцогч нь Төрийн үйлчилгээний нэгдсэн систем /e-mongolia/-д ажилтнуудын дээд боловсролын дипломын мэдээлэл байршсан эсэхийг урьдчилан шалгах шаардлагатайг анхаарна уу.)
- Санал болгож буй үндсэн ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийн даатгуулагчийн төрлийн код 01001, 22001 төлөгдсөн үндсэн ажилтан гэж үнэлгээнд харгалзан үзэх бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийг “Төрийн мэдээлэл солилцооны ХУР систем”-ээр дамжуулан шалгах тул НД-8 маягтаар гаргасан тайланг ирүүлэх шаардлагагүй. Үндсэн ажилтны сүүлийн 3 сарын хугацаанд нийгмийн даатгал төлөлтийг цахим системээр шалгана.
- Гэрээгээр ажиллах бол хөлсөөр ажиллах гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх ба хөлсөөр ажиллах гэрээг өөрийн тендерт ирүүлнэ.
- Гадаадын их, дээд сургууль төгссөн бол дипломын хуулбарыг орчуулан ирүүлнэ.
- Монгол улсын зөвлөх инженерийн Мэргэшлийн зэргийн гэрчилгээг ажилтан тус бүрээр өөрийн тендерт ирүүлнэ.
- Санал болгох ажилтанд шаардагдах туршлагын доод төвшинд заасны дагуу багийн гишүүд тус бүрээр нотлох нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн хуулбарыг ажилтан тус бүрээр ирүүлнэ.

Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд ажиллах хүчний жагсаалтыг ирүүлэхдээ дипломын хуулбар, мэргэшсэн, зөвлөх зэрэгтэй ажилтны хүчин төгөлдөр мэргэжлийн гэрчилгээг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./

2. Ижил төстэй ажил хийж гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээллийг V бүлгийн Маягт 2, Маягт 3, Маягт 4-ийн дагуу бэлтгэж ирүүлнэ.

	<p>3. Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад шаардлага: “<i>Шаардана</i>”</p> <ul style="list-style-type: none"> • Үйлчилгээ үзүүлсэн гэрээний хуулбар, • Гэрээ дүгнэсэн акт, эсхүл тухайн үйлчилгээг цаг хугацаанд нь чанартай гүйцэтгэсэн талаарх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ. • Төрийн захиргааны болон төрийн захиргааны төв байгууллын мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж батлуулсан байна. /Хуулбар үнэн гэсэн тэмдэг эсхүл нотариатаар баталгаажуулан ирүүлнэ./ <p><i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./</i></p> <p>Тендерт шалгарсан тохиолдолд санал болгож буй үйлчилгээг гэрээний үнэ, хугацаанд багтаан ажлын даалгаврын дагуу чанартай гүйцэтгэн хүлээлгэн өгөх тухай албан мэдэгдлийг баталгаажуулж ирүүлнэ.</p> <p>Ажлын даалгаврын шаардлага нөхцөлийг хүлээн зөвшөөрч буй тухай албан мэдэгдлийг баталгаажуулж ирүүлнэ.</p> <p>Тендерт шалгарсан тохиолдолд ТЭЗҮ боловсруулж, батлуулах, хүлээлгэн өгөх нарийвчилсан хуваарьт төлөвлөгөөг боловсруулан баталгаажуулж ирүүлнэ.</p>
<p>ТШЗ 19.3</p>	<p>Тусгай зөвшөөрөл/зөвшөөрөл: “<i>Шаардана</i>”</p> <p>Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Тендерт оролцогчийг эрх бүхий болохыг нотлохтой холбоотойгоор дараах тусгай зөвшөөрлүүдтэй байх шаардлагатай. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Барилга, хот байгуулалтын яамнаас олгодог барилга, байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл: <ul style="list-style-type: none"> - ЗТ-4.2 Өндөр төвөгшилтэй усны барилга байгууламжийн зураг төсөл; - ЗТ-4.4 Ус хангамж, ариутгах татуургын системийн шугам сүлжээ, түүнтэй холбогдох барилга, байгууламжийн технологийн ажлын зураг; - ЗТ-10.1 ТЭЗҮ /тухайн ажлын төслийн хүрээнд/; - ЗТ-10.2 Барилга байгууламжийн ажлын төсөв; - ЗТ-9.2 Өндөр болон онцгой төвөгшилтэй барилга байгууламжид зориулсан судалгааг инженер-геологийн энгийнээс дунд зэргийн нөхцөлтэй байршилд; - “Геодезийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрөл. 2. Эрчим хүчний яамнаас олгодог тусгай зөвшөөрөл: <ul style="list-style-type: none"> - ТЗ-8.2: 0.01-100 Мвт болон түүнээс дээш хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах;

	<p>- ТЗ-8.4: 04-110 кВ болон түүнээс дээш цахилгаан дамжуулах шугам, дэд станцын барилгын байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах.</p> <p><i>/Хэрэв гадаадын хуулийн этгээд тендер ирүүлэх тохиолдолд үүсгэн байгуулагдсан улсын эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичгийг консулын баталгаа эсхүл апостиль гаргуулан өөрийн тендерт хавсарган ирүүлнэ./</i></p> <p>Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ. Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.</p>
ТШЗ 21.4	Оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад: “Тохируулахгүй тогтмол байна”
ТШЗ 24.1	<p>Тендерийн баталгааны дүн: Тендерийн баталгааны дүнг төсөвт өртгийн 0.5 хувь буюу 50,719,800 /Тавин сая долоон зуун арван есөн мянга найман зуун/ төгрөг</p> <p>Хүчинтэй байх хугацаа: Тендер хүчинтэй байх хугацаанаас хойш 28 хоног байна.</p>
Г. ТЕНДЕР ИЛГЭЭХ, НЭЭХ	
ТШЗ 25.5	<p>Оролцогчдод ил болох баримт бичгийн жагсаалт:</p> <p>Тендерт оролцогч нь Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь файл үүсгэн ирүүлнэ.</p> <p>Тус файлын эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн эрх бүхий этгээд баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>Тендерт оролцогч хуульд заасан үндэслэлээр нууцалж буй баримт бичиг, мэдээлэл бүрд хамаарах хууль зүйн үндэслэлийг тодорхой тайлбарласан тайлбарыг V бүлгийн Маягт 12-ын дагуу нууцлахгүйгээр ирүүлнэ.</p> <p>Бүх материалыг нууцалж ирүүлсэн тохиолдолд татгалзах үндэслэл болно.</p>
ТШЗ 26.1	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Огноо: 2024.08.20</p> <p>Цаг: 11 цаг 00 минут</p>
ТШЗ 26.2	<p>Тендерийн нээлтийг доор дурдсан хугацаанд цахим системээр хийх бөгөөд нээлтийн мэдээллийг оролцогч цахим системээр хүлээн авна.</p> <p>Огноо: 2024.08.20</p> <p>Цаг: 11 цаг 30 минут</p>


	Тендер нээлтэд оролцох боломжтой газрын хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Блю скай цамхаг 8 дугаар давхар, 803 тоот.
Д. ТЕНДЕРИЙГ ХЯНАН ҮЗЭХ, ҮНЭЛЭХ	
ТШЗ 31.1	Тендер үнэлэх үндсэн шалгуурыг харьцуулах үнээс өөрөөр тогтоох эсэх: “Үгүй”
Е. МЭДЭГДЭЛ ХҮРГҮҮЛЭХ, ГЭРЭЭ БАЙГУУЛАХ	
ТШЗ 36.1	Шалгарсан оролцогч гүйцэтгэлийн баталгаа ирүүлэх эсэх: “Тийм” Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт заасны дагуу Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ. Гүйцэтгэлийн баталгааг тухайн онд санхүүжих дүнгийн 3 хувь буюу 121,727,520 /Нэг зуун хорин нэгэн сая долоон зуун хорин долоон мянга таван зуун хорин мянга/ төгрөг.

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

[Үйлчилгээний даалгаврыг хавсаргана уу.]

БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
АГЕНТЛАГ УСНЫ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



З.БАТБАЯР

2023 оны 9 дүгээр сарын 06 өдөр

**“ХЭРЛЭН ТООНО” ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН
ҮНДЭСЛЭЛИЙН СУДАЛГААГ ШИНЭЧЛЭХ, ТОДОТГОЛ
БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Дугаар 23/02

Улаанбаатар хот
2023 он

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

АҮЦ	:	Аж үйлдвэрийн цогцолбор
БНБД	:	Барилгын норм ба дүрэм
БОАЖЯ	:	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОНБНУ	:	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
ДНБ	:	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЗГ	:	Засгийн газар
НҮБ	:	Нэгдсэн үндэстний байгууллага
ӨМӨЗО	:	Өвөр монголын өөртөө засах орон
ТХН	:	Төсөл хэрэгжүүлэх нэгж
ТЭЗҮ	:	Техник эдийн засгийн үндэслэл
ТЭЗУС	:	Техник эдийн засгийн урьдчилсан судалгаа
ТЭХС	:	Төвийн эрчим хүчний систем
УННМ	:	Усны нөөцийн нэгдсэн менежмент
УИХ	:	Улсын их хурал
УУХҮЯ	:	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
УЦС	:	Усан цахилгаан станц
ЭЗЧБ	:	Эдийн засгийн чөлөөт бүс
ЭХЯ	:	Эрчим хүчний яам
ОТ	:	ОюуТолгой

Агуулга

Агуулга.....	3
A. Ерөнхий мэдээлэл.....	5
1. Танилцуулга.....	5
1.1. Удиртгал.....	5
1.2. Монгол Улсын Засгийн газрын бодлого.....	6
1.3. ТЭЗҮ-ийн тодотголыг гүйцэтгэхэд ашиглах материал.....	7
1.4. Ач холбогдол, судлагдсан байдал.....	8
1.4.1. Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор төслийн хүрээнд “Бүс нутаг хооронд ус тээвэрлэх боломж, ТЭЗҮ боловсруулах” эрэл, хайгуулын судалгаа /Хэрлэн-Тооно/.....	9
1.4.2. Хэрлэн гол дээр олон жилийн урсацын тохируулга бүхий ус хуримтлуулах усан сан байгуулан голын экологийн чадамжийг сайжруулах “Хэрлэн-Говь” төсөл. Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа.....	10
1.4.3. Говийн бүсийн үйлдвэр уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн техник эдийн засгийн үндэслэл.....	10
1.5. Төсөлд хамрагдах бүс нутаг.....	11
1.6. Төслийн хамрах хүрээ.....	11
2. ТЭЗҮ-д тодотгол хийх.....	18
2.1. судалгааны ажлын зорилго.....	18
2.1. Судалгааны үе шат, хийх ажил, зорилт.....	19
B. СУДАЛГААНЫ ҮЕ ШАТУУДАД ХИЙХ АЖЛУУД.....	21
3. ТЭЗҮ-ийн судалгаа.....	21
3.1. Танилцуулга.....	21
3.2. Инженер-техникийн судалгаа.....	21
3.2.1. Инженерийн хайгуул, судалгааны ажил.....	21
3.2.2. Инженер-геодезийн хайгуулын ажил, зураглал бэлдэх.....	22
3.2.3. Бичил уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээ.....	23
3.2.4. Ус зүйн судалгаа.....	23
3.2.5. Геологи, геофизик, гидрогеологи, инженер-геологийн хайгуул, судалгаа.....	24
3.2.6. Газар хөдлөлт, чичирхийллийн судалгаа.....	26
3.2.7. Барилгын материалын хайгуул судалгаа.....	27
3.3. ТЭЗҮ-ийн техникийн тооцоо, шийдэл.....	28
3.3.1. Хэрлэн голын урсацын тохируулга, гидротехникийн барилга байгууламжийн техникийн шийдэл.....	28
3.3.2. Хиймэл нуурын техникийн үндсэн үзүүлэлтүүдийн хувилбарууд, сонголт.....	28
3.3.3. Гидротехникийн барилгын төрөл хийц, үндсэн хэмжээнүүдийг тодорхойлох.....	28
3.3.4. Гидравлик судалгаа.....	29
3.3.5. Усан сангийн ажиллагаа, түүний загварчлал.....	30
3.3.6. Усан цогцолборын ашиглалтын хувилбарууд, тэдгээрээс сонголт хийх.....	31
3.3.7. Техникийн зураг төсөл.....	31
3.3.8. Тогтворжилтын тооцоо, судалгаа.....	33
3.4. Ус дамжуулах хоолойн гидравлик тооцоо.....	33
3.4.1. Ус дамжуулах хоолойн материалын сонголт.....	33
3.4.2. Өргөлтийн насос станцын шийдэл.....	33
3.4.3. Ус цэвэршүүлэх, халдваргүйжүүлэх байгууламж.....	34
3.4.4. Ус нөөцлөх усан сан (Хиймэл нуур).....	34
3.4.5. Дэд бүтцийн барилга байгууламж.....	34
3.4.6. Гидро-механик болон цахилгаан-механик тоног төхөөрөмжийн зураг төсөл.....	35
3.4.7. Төслийн эрчим хүчний хэрэглээ, цахилгаан хангамжийн төлөвлөлт.....	35
3.4.8. Усан цахилгаан станцын техникийн тодорхойлолт.....	36
3.4.9. УЦС-аас цахилгаан дамжуулах шугам, ТЭХС-д холбогдох байдал.....	36
3.4.10. Авто замын төлөвлөлт, төлөвлөлтийн норм.....	36

3.4.10	Авто замын төлөвлөлт, төлөвлөлтийн норм	36
3.4.11	Холбоо, мэдээлэл, телеметрийн удирдлага	37
3.4.12	Төслийн ашиглалтын байгууламжууд.....	37
3.4.13	Ажлын тоо хэмжээ	38
3.4.14	Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө	38
3.4.15	Боомтын аюулгүй байдлын бодлого.....	38
3.4.16	Ажлын байрны эрүүл мэнд болон аюулгүй байдлын үнэлгээ	38
3.4.17	Ажил гүйцэтгэх төлөвлөгөө	38
4.	Санхүү, эдийн засгийн судалгаа	39
4.1.	Танилцуулга	39
4.2.	Төслийн санхүү, эдийн засгийн эрсдэл	40
4.3.	Гол судалгаанууд.....	40
4.3.1	Төслийг хэрэгжүүлэх эсвэл төслийг хэрэгжүүлээгүйн улмаас гарах үр дүн	40
4.3.2	Хууль журам, дүрэм, үнэ тарифыг тооцох.....	41
4.3.3	Төслөөр бий болох үндсэн байгууламжуудын менежментийн хувилбар.....	42
4.3.4	Төслийн хүрээнд усны хэрэгцээ, усны үнэ тарифыг тооцох.....	42
4.3.5	Төслийн нийт өртгийн тооцоо	42
4.3.6	Ашиглалтын зардал ба цэвэр орлого	42
4.3.7	Шууд ба шууд бус өгөөжийн судалгаа	43
4.3.8	Байгаль орчин, нийгмийн салбарт учирч болзошгүй хохирол.....	44
4.3.9	Төслийн нийгэм эдийн засгийн судалгаа.....	44
4.3.10	Төслийн эрсдэлийг харьцуулах хэлбэрээр үнэлэх.....	45
4.3.11	Төслийн үр ашгийн тооцоо	45
4.3.12	Санхүү, эдийн засгийн шинжилгээ	46
С.	Зөвлөхийн хүлээлгэж өгөх зүйлс	47
5.	Ажлын үр дүн	47
5.1	Танилцуулга	47
5.2	Боловсруулах материалууд	47
5.2.1	ТЭЗҮ-ийн тайлан.....	47
5.2.2	Санхүү эдийн засгийн үнэлгээ.....	48
6.	ТЭЗҮ-ийн менежмент	49
6.1.	Үүрэг, хариуцлага	49
6.2.	Зөвлөхийн ажлын хуваарь	49
6.3.	Мэдээлэл, баримт мэдээлэл болон баримт бичгийн эзэмшил болон хяналт	50
7.	Зөвлөх багийн шаардлага	51

А. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

1. Танилцуулга

1.1. Удиртгал

Монгол орны агаарын дундаж хэм сүүлийн 80 жилд 2.2 хэмээр дулаарсан нь дэлхийн дунджаас даруй хоёр дахин өндөр байна. 2020 онд хийсэн цөлжилтийн үнэлгээгээр Монгол орны нийт нутаг дэвсгэрийн (76.8 хувь буюу 120.3 сая га талбай газар нутаг цөлжилтөд тодорхой хэмжээгээр өртсөнөөс 22.9 хувь буюу 30 орчим сая га талбай нь цөлжилтийн хүчтэй, нэн хүчтэй зэрэглэлд хамрагдаж)¹ байна.

Дэлхийн дулаарлын нөлөөгөөр Монгол орны томоохон голуудын урсац эрс багасаж, жижиг гол горхи, нуур цөөрөм ширгэж голуудын эрэг татам дагуух экологийн тэнцвэрт байдал алдагдаж, хуурайшилт хүчтэй явагдаж байгаа нь туйлын сэтгэл эмзэглүүлсэн асуудал болоод байна.

Цаашид Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх, уур, амьсгалын өөрчлөлт, цөлжилт, усны нөөцийн хомсдол, шар шороон шуурганы эсрэг тэмцэх бодлого, зорилт, арга барил, хандлагаа эрс өөрчлөн, бодитой үр дүнд хүрэхийн тулд экосистемийг тэтгэх үндсэн нөхцөл болох усны нөөцийг хуримтлуулж, гадаргын усыг ашиглах, хамгаалах асуудал нэн чухлаар тавигдаж байна.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, “Шинэ сэргэлтийн бодлого”-д “Хөх морь” төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгох, усан хангамжийг нэмэгдүүлэх төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан, барилга байгууламжийн ажлыг эхлүүлнэ гэж тусгасан.

Эдгээр төсүүдийн нэг хэсэг болох Хэрлэн-Тооно чиглэлийн төслүүдийн судалгааны үр дүнгээс үзэхэд Хэрлэн голын экосистемд нөлөөлж буй хүчин зүйлсийн 79.6% нь уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой байна. Иймд Хэрлэн голын урсцыг тэтгэх хүн ам, мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, эрчим хүчний үйлдвэрлэлийн өсөн нэмэгдэх хэрэгцээг хангахын тулд гадаргын ус хуримтлуулж, ашиглах хамгаалах олон зориулалттай усан цогцолбор барих төслийн техник эдийн засгийн үндэслэлд нэмэлт тодотгол хийх шаардлагатай байна.

Эдийн засаг, нийгмийн үүднээс гарч ирж буй усны хэрэгцээг богино хугацаанд нөхөн сэргээгдэх нөөцөөр хангах шаардлагатай ба энэ нь үндсэндээ гол, мөрний усны нөөц бөгөөд хурдан нөхөгдөх нөөц баялаг юм. Манай орны гол мөрний жилийн дундаж урсцын 60-70 хувь нь гадагш хил даван урсан гардаг ба үлдсэн хувь нь хөрсөнд нэвчин газрын доорх усыг тэжээх болон нууруудад цутган улмаар ууршин хорогддог онцлогтой.

Хил даван тасралтгүй урсан алдагдаж буй гадаргын усны нөөцийг хур бороо, ус элбэг үертэй үед нь усан санд хуримтлуулан дүүргэж аваад ус бага, ган гачигтай үед нь гол горхио тэжээж түүнийг байнгын жигд, амьд урсгалтай байлгаж, голын дагуу амьдарч байгаа ард олон, ус хэрэглэгчдийг усны нөөцийн хомсдолоос хамгаалах санал санаачилгын хүрээнд “Хэрлэн гол дээр олон зориулалттай усан цогцолбор, усан сан байгуулах” төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тодотгол хийж боломжит хамгийн сайн хувилбарыг сонгох ажил хамрагдаж байна.

Төсөл хэрэгжих бүс нутгийн ус хэрэглээний хэтийн төлөвийг хангах зорилгоор тухайн бүс нутгийн газар доорх усны нөөц боломжийг авч үзэхийн зэрэгцээ Өмнөд говийн бүсээс алслагдмал зайд байгаа хойд бүс нутгийн усны эх үүсвэрийг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байна.

¹ Байгаль орчны төлөв байдлын тайлан-2018 он

Төсөл нь техник, эдийн засгийн хувьд үр ашигтай байж болох боловч байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг тооцохгүйгээр уг төслийг хэрэгжүүлэх асуудлыг авч үзэх боломжгүй юм.

1.2. Монгол Улсын Засгийн газрын бодлого

Гадаргын усны нөөцийг хур бороо, ус элбэг үертэй үед нь усан санд хуримтлуулан дүүргэж аваад ус бага, ган гачигтай үед нь гол горхио тэжээж байнгын жигд, амьд урсгалтай байлгаж, голын дагуу амьдарч байгаа ард иргэд, ус хэрэглэгчдийг усны нөөцийн хомсдолоос аврах санал санаачилгыг хэрэгжүүлэх талаар Монгол улсын УИХ, Засгийн газраас онцгой анхаарч дараах бодлогын баримт бичгүүдэд тусгасан байдаг. Үүнд:

1. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа 2050" Монгол улсын хөгжүүлэх урт хугацааны бодлогын баримт бичгийн 6.3 дахь зорилтод Усны нөөцийн хомсдолоос сэргийлж, гадаргын усыг хуримтлуулан, эрэлт хэрэгцээг хүртээмжтэй хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж заасан. Тус зорилтын хүрээнд 2021-2030 он хэрэгжүүлэх үйл ажиллагааны 3-т Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхэлнэ;
2. Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн Зорилт 6.3-д Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ гэж заасан бөгөөд үйл ажиллагааны 6.3.2-т газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулж, томоохон голууд дээр урсцын тохируулгатай, олон зориулалтаар ашиглах усан сан барьж эхэлнэ;
3. Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.1.11-д "Хөх морь" төслийн хүрээнд гадаргын усны хуримтлал бий болгон усан хангамжийг нэмэгдүүлэх Орхон-Онги, Хэрлэн-Тооно төслийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан төслийн байгууламжийн ажлыг эхлүүлнэ;
4. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор баталсан Шинэ сэргэлтийн бодлогын Эрчим хүчний сэргэлтийн 2.2-т Сэргээгдэх эрчим хүчийг зохистой харьцаагаар хөгжүүлэн усан болон хуримтлуурын станц барьж, эрчим хүчний нэгдсэн системийн найдвартай, тогтвортой байдлыг хангана, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын Усны нөөцийг хуримтлуулж, говийн бүсийн ус хангамжийн хүртээмжийг нэмэгдүүлэх төслүүд болох "Хөх морь" төслийг хэрэгжүүлэхээр тус тус тусгасан байна.
5. УИХ-ийн 2010 оны 7-р сарын 15-ны өдрийн 48 тоот тогтоолоор баталсан "Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ийн 3.5.1.7 заалт буюу Монгол орны гадаргын усны ашиглалтыг сайжруулах үүднээс томоохон гол, мөрөнд урсцын тохируулга хийж, усан сангуудыг байгуулах тухай заалт;
6. Засгийн газрын 2010 оны 6-р сарын 16-ны өдрийн 151 тоот тогтоолоор баталсан "Өмнөд говийн дэд бүтцийг хөгжүүлэх хөтөлбөр"-ийн 3.1.3.3 заалтын "Усны хэрэгцээг

газрын доорх болон гадаргын усаар, хосолмол аргаар хангах бодлого барьж ирээдүйд өсөн нэмэгдэх усны хэрэгцээг “Хэрлэн-Говь” төслийг хэрэгжүүлж хангах хувилбар боловсруулж шийдвэрлэх;

7. Засгийн газрын 2017 оны 8-р сарын 17-ны өдөр “Хэрлэн гол дээр урсцын тохируулга хийх төсөл”-ийг хэрэгжүүлэхэд шаардагдах ТЭЗҮ, БОНБНҮ хийлгэх ажлыг зохион байгуулж, санхүүжилтийг шийдвэрлэх тухай 232 тоот тогтоол;

1.3. ТЭЗҮ-ийн тодотголыг гүйцэтгэхэд ашиглах материал

Монгол Улсын хуулиуд:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Усны тухай хууль;
- Хот байгуулалтын тухай хууль;
- Газрын тухай хууль;
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль;
- Барилгын тухай;
- Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль;
- Авто замын тухай хууль;
- Авто тээврийн тухай хууль;
- Эрчим хүчний тухай хууль;
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
- Гамшгаас хамгаалах тухай хууль;
- Галын аюулгүй байдлын тухай хууль;
- Хамгаалалтын бүс тогтоох тухай;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын тухай;
- Тусгай хамгаалалтай газар нутгийн тухай хууль;
- Тусгай хамгаалалтай газар нутгийн орчны бүсийн тухай хууль;
- Ойн тухай хууль;
- Аялал жуулчлалын тухай хууль;
- Соёлын өвийг хамгаалах тухай хууль;
- Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль;

Норм, нормативууд:

- Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07)
- Зураг төслийн ажлын жишиг үнэ (БД 81-16-12)
- Усны барилга байгууламжийн зураг төслийн ажлын жишиг норм (БД 81-106-11)
- ЗГ-ын 2009 оны 204 дүгээр тогтоол, Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрэм
- ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоол, Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм
- Усны барилга, байгууламжийн зураг төсөл зохиох үндсэн журам (БНБД 33-01-03)
- Усны барилга байгууламжийн ажлын төсвийн суурь норм (БНБД 81-33-10)
- Барилгын төсөв зохиох дүрэм (БНБД 81-95-12)
- Зургийн ерөнхий инженер (ерөнхий архитектор)-ийн дүрэм (БНБД 11-06-03)
- Барилга, байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл (БНБД 11-07-04)
- Барилгын инженер геологийн ажил (БНБД 11-03-01)
- Усны барилга байгууламжийн инженер, хайгуул судалгааны ажлын жишиг норм (БД 81-105-11)
- Барилгын үйлдвэрлэлийн зохион байгуулалт (БНБД 12-01-09)
- Барилга угсралтын ажилд мөрдөх хөдөлмөр хамгааллын үлгэрчилсэн заавар (БД 12-101-05)
- Барилгын геодезийн ажил (БНБД 11-08-06)
- Барилгын орчны тохижилтын ажил (БНБД 3.01.06-9)
- Барилгын газар шороо ба буурь, суурийн ажил (БНБД 3.02.01-9)

- Голын гидротехникийн барилга байгууламж (БНБД 33-03-05)
- Усны барилга байгууламжийн буурь (БНБД 33-04-09)
- Усны барилга байгууламжийн ачаалал ба үйлчлэл (БНБД 33-05-09)
- Усны барилга байгууламжийн бетон ба төмөр бетон бүтээц (БНБД 33-06-09)
- Усан хангамж, бохир ус, гадна шугам сүлжээ, түүний барилга байгууламж (БНБД 3.05.04-90)
- Ус хангамж, ариутгах татуургын сүлжээний хуванцар хоолойг төсөллөх ба угсрах (БНБД 40-102-06)
- Усан хангамж, гадна сүлжээ ба байгууламж (БНБД 40-02-06)
- Байгууламж ба барилгын бүтээцийг зэврэлтээс хамгаалах (БНБД 3.04.03-90)
- Шороон боомт (БНБД 33-07-09)
- Бетон ба төмөр бетон боомт (БНБД 33-08-09)
- Хот, суурины дэвсгэр газарт хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ өгөх аргачилсан заавар (УББ 30-201-09)
- Барилгын орчны тохижилтын ажил (БНБД 3.01.06-90)
- Тохижилт, бусад ажил (БНБД 81-59-05)
- Ус зүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм (БНБД 2.01.14-86)
- Шороон боомт /БНБД 33-07-09)
- Авто замын гүүр ба хоолой төсөллөх (БНБД 32-02-03)
- Хот суурины гудамж талбайн төлөвлөлт (БНБД 32-04-06)
- Бетонон суваг, үерийн ус зайлуулах хоолой. Техникийн шаардлага (MNS AASHTO M 86M : 2005)
- Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах, зөвшөөрөлцөх, экспертиз хийх дүрэм (ЗТБХБ-ын сайдын 2011 оны 226 дугаар тушаал)
- Инженерийн шугам сүлжээний зураглалын ажил (БД 11-105-06)-ыг үндэслэн байр зүйн зургийн тодруулалт хийсэн дэвсгэр зураг ашиглах
- Авто зам төсөллөх (БНБД 32-01-07)
- Хот суурины гудамж, зам төлөвлөлт (БНБД 32-01-04)
- Барилга байгууламжийн инженер-экологийн судалгаа (БД 11-102-07)
- Барилгын нэгж талбайн төсөвт өртөг, төсвийн жишиг үнэлгээ (БД 81-106-16)
- Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал (БНБД 21-01-02)
- Ариутгах татуурга. Гадна сүлжээ ба байгууламж (БНБД 40-01-14)
- Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм (БД 43-101-03)
- MNS 5873:2008 Барилгын зураг. Ерөнхий төлөвлөгөөний ажлын зургийн таних тэмдэглэгээ;
- Инженерийн үйлчилгээ-Барилга, дэд бүтэц болон үйлдвэрийн барилга байгууламж, Нэр томьёо, тодорхойлолт (MNS EN 16310:2023)
- Бусад норматив баримт бичиг, норм, дүрэм, заавар.

Олон улсын шаардлага, стандарт:

- Олон улсын банк, санхүүгийн байгууллагын ТЭЗҮ-д тавигдах шаардлага
- Олон улсын зөвлөх инженерүүдийн холбоо (FIDIC)-ны ТЭЗҮ боловсруулах шаардлага, стандарт
- Бусад олон улсын баримт бичиг, норм, дүрэм, заавар.

1.4. Ач холбогдол, судлагдсан байдал

Судалгааны ажлын зорилго нь Хэрлэн голын тооцоолсон байршил дээр олон зориулалттай усан цогцолбор байгуулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, Өмнөд говийн зүүн бүсийн өсөн нэмэгдэж байгаа ус хэрэглээний хэтийн төлөвийг хангах ус хангамжийн хувилбаруудыг нарийвчлан гаргаж, бүх хувилбаруудын инженер техникийн шийдэл, санхүү эдийн засаг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн хувьд харьцуулан судалж боломжтой хувилбарыг сонгох асуудал юм.

ТЭЗҮ-г урьд өмнө хийгдсэн хайгуул, судалгаа, тооцооны материалд үндэслэн нарийвчлан шинэчлэн боловсруулсан байна.

- ТЭЗҮ ажлын үр дүнгээр усны нөөц, техник технологийн боломж, санхүү, эдийн засгийн нөхцөлүүд, байгаль орчин ба нийгмийн нөлөөллүүдийн харьцуулалтаар Өмнөд говийн Зүүн бүсийн ус хэрэглээг говийн газар доорх усны эх үүсвэр болон хойд бүсийн гадаргын усны эх үүсвэрээс хосолсон байдлаар хангах буюу Хэрлэн голын урсцад тохируулга хийж говийн бүс рүү далд шугам хоолойгоор усыг дамжуулан ус хэрэглэгчдэд хүргэх явдал юм.
- Монгол улсын нийт газар нутаг болон говийн бүс нутагт сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж байгаа цөлжилтийг бууруулах багасгахын тулд техник технологийн шинэ шийдлийг эрэх хайх замаар инженерчлэлийн шийдлийг гаргах
- Хэрлэн гол дээр боомт бүхий олон жилийн урсцын тохируулгатай ус хуримтлуулах хиймэл нуур байгуулах замаар гадаргын усыг ашиглах хувилбарыг сонгоно.
- ТЭЗҮ-ийн хүрээнд шаардлагатай инженерийн байгууламжийг байгальд ээлтэйгээр шийдэх хэд хэдэн хувилбар гаргах, түүний ажлын зураг боловсруулах, байршлыг шийдэх .
- Тухайн бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх хямд зардлаар эрчим хүчийг ашиглаж бэлчээрийн аж ахуй, газар тариалангийн бүс нутгийг хөгжүүлэх усан хангамжийн систем бий болгох

Хэрлэн гол дээр болон говийн бүсийн ус хангамжийг нэмэгдүүлэх урьдчилсан судалгааны дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. “Монхидроконстракшн” ХХК-ний 2014 онд боловсруулсан **Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор төслийн хүрээнд “Бүс нутаг хооронд ус тээвэрлэх боломж, ТЭЗҮ боловсруулах” эрэл, хайгуулын судалгаа /Хэрлэн-Тооно/**
2. “Престиж инженеринг” ХХК-ний 2015 онд боловсруулсан **Хэрлэн гол дээр олон жилийн урсцын тохируулга бүхий ус хуримтлуулах усан сан байгуулан голын экологийн чадамжийг сайжруулах “Хэрлэн-Говь” төсөл. Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа.**
3. “Престиж инженеринг” ХХК-ийн 2021 онд боловсруулсан **Говийн бүсийн үйлдвэр уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн техник эдийн засгийн үндэслэл.**

1.4.1. Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор төслийн хүрээнд “Бүс нутаг хооронд ус тээвэрлэх боломж, ТЭЗҮ боловсруулах” эрэл, хайгуулын судалгаа /Хэрлэн-Тооно/

Үйлдвэр, Хөдөө аж ахуйн яамны захиалгаар 2014 онд “Монхидроконстракшн” ХХК төслийг хийж гүйцэтгэсэн байна. Төсөл нь Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын нутагт Тооно уулын дэргэд Хэрлэн гол дээр 2400 м урт, 40 м өндөр боомт байгуулж 900 сая.м³ гадаргын усыг хуримтлуулан Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор хүртэл 2 өргөлтийн насос станцаар 235 км урт 800 мм голчтой хос хоолойгоор тээвэрлэх судалгааны ажлыг гүйцэтгэж Барилга, хот байгуулалтын яамны Барилгын хөгжлийн төвөөс Зураг төслийн баримт бичгийн магадлалын ерөнхий дүгнэлтийг гаргуулсан байна. Судалгааны ажлын хүрээнд дараах суурь судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- a. Боомт байгуулах талбайд байрзүйн зураглал;
- b. Боомт байгуулах талбайн инженер геологийн судалгаа;
- c. Хэрлэн голын олон жилийн харуулын мэдээг ашиглан гүйцэтгэсэн ус зүйн тооцоо;
- d. Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор хүртэл шугам хоолойн трасс дагуу инженер геологийн судалгааны ажил;
- e. Судалгааны ажлын тайлан;
- f. Судалгааны ажлын боомт болон дамжуулах шугам хоолойн ажлын зураг;
- g. Судалгааны ажлын төсөв зэргийг хийж гүйцэтгэсэн.

1.4.2. Хэрлэн гол дээр олон жилийн урсцын тохируулга бүхий ус хуримтлуулах усан сан байгуулан голын экологийн чадамжийг сайжруулах “Хэрлэн-Говь” төсөл. Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа.

Усны үндэсний хорооны захиалгаар 2015 онд “Престиж инженеринг” ХХК төслийг хийж гүйцэтгэсэн байна. Төсөл нь Хэнтий аймгийн Хэрлэнбаян-Улаан сум баруун зүгт 20 км-т Хэрлэн гол дээр 25 м өндөр далан байгуулж 300-350 сая.м³ гадаргын усыг хуримтлуулан Сайншанд хүртэл 2 өргөлтийн насос станцаар 335 км урт 600-1400 мм голчтой хоолойгоор тээвэрлэх судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна. Судалгааны ажлын хүрээнд дараах суурь судалгааг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

- a. Өмнө хийгдсэн судалгааны материал цуглуулах, дүгнэлт гаргах;
- b. Усны нөөцийн менежментийн судалгаа;
- c. Төсөл хэрэгжих бүс нутгийн ус хэрэглээг тодорхойлох;
- d. Хэрлэн голын усзүй, урсцын горимын судалгаа хийх ;
- e. Хэрлэн гол дээр байгуулах усан сангийн хөндлүүрийн хувилбарууд, сонгосон хувилбарын характеристикийг тодорхойлох ;
- f. Санхүү эдийн засгийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн.
- g. Инженерчлэлийн хийцийн ажлын зураг боловсруулах.
- h. Цөлжилтийн эсрэг авах арга хэмжээнүүдийг тодорхой болгох, түүний үр дүн ач холбогдлыг гаргаж тодорхойлох.
- i. Энэ судалгаагаар хийгдэх техник технологийг ашиглаж усан цахилгаан станц, сэргээгдэх эрчим хүчийг гаргаж хосолсон байгальд ээлтэй ашиглахаар сонгох,
- j. Хэрлэн голын нөөц тодорхойлсон дэвсгэр зургийг хамгийн сүүлийн байдлаар гаргаж ирэх

1.4.3. Говийн бүсийн үйлдвэр уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн техник эдийн засгийн үндэслэл.

Өмнөд говийн бүсийн үйлдвэр, уурхайг эхний ээлжинд газрын доорх усан эх үүсвэрээс хангах ба ус хангамжийн шугам хоолой нь ирээдүйд хойд бүсийн гадаргын усны эх үүсвэртэй хосолсон байдлаар ажиллах боломжтой байхаар төлөвлөлтийг хийсэн.

Үүний дагуу эхний ээлжид “Сайн-Ус, Бор хөөвөр, Долоодын говь ба Цагаанцавын газрын доорх усны эх үүсвэрүүдээс Өмнөд говийн бүсийн уул уурхай, үйлдвэрийн бүс, хүн амын ус хангамжийг шийдвэрлэх” төслийн Техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан.

Өмнөд говийн бүсэд шинээр баригдсан төмөр зам дагуу төлөвлөгдөж буй ус хангамжийн системийг дараах 3 хэсэгт хуваан төлөвлөж судалгаанд авч үзсэн.

1. Сайн-Ус, Бор хөөвөр, Долоодын говийн газрын доорх усны эх үүсвэрээс Сайншанд орчимд байрлах 2х200,000 м³-ийн ус нөөцлөх усан сан хүртэл
2. Сайншандын 2х200,000 м³-ийн ус нөөцлөх усан сангаас Цагаанцавын 2х100,000 м³-ийн ус нөөцлөх усан сан хүртэл
3. Цагаанцавын газрын доорх усны эх үүсвэр, 2х100,000 м³-ийн ус нөөцлөх усан сангаас Тавантолгойн 2х200,000 м³-ийн ус нөөцлөх усан сан хүртэл

Төслийн хүрээнд хүн ам, хөдөө аж ахуй, байгаль орчин, уул уурхай, үйлдвэрүүдийн ус хэрэглээг нийтэд нь авч үзсэн болно.

ТЭЗҮ-ийн шатанд дараах ажлуудыг хамруулж, тооцоо судалгааг хийсэн байна. Үүнд:

- Ашиглалтын цооногуудын байршил, гүний насосны хүчин чадлыг тодорхойлох;
- Цооногуудаас ус цуглуулах салбар шугам хоолойн байршлын сонголт, шугамын диаметр, хоолойн материалын сонголт;
- Ус цуглуулах усан сангийн төлөвлөлт, эзлэхүүн тодорхойлох;

- Өргөлтийн насос станцын төлөвлөлт, өргөлтийн насосны хүчин чадлыг тодорхойлох, хувилбаруудын техник-эдийн засгийн харьцуулалт;
- Ус нөөцлөх усан сангийн төлөвлөлт, эзлэхүүн тодорхойлох;
- Ус дамжуулах гол шугам хоолойн трассын судалгаа, хоолойн материал сонголт, техник-эдийн засгийн харьцуулалт;
- Ус дамжуулах шугам хоолойн хяналт удирдлагын алсын зайн удирдлагын төлөвлөлт, хувилбаруудын харьцуулалт;
- Гүний худаг, өргөлтийн насос станц хүртэлх ЦДАШ, дэд станцууд;

1.5. Төсөлд хамрагдах бүс нутаг

Хэрлэн гол дээр урсцын тохируулга хийх зорилгоор боомт бүхий томоохон хиймэл нуур байгуулж, гадаргын усыг хуримтлуулан хамгаалж зохистой ашиглах төсөл нь Монгол орны эдийн засгийн ач холбогдол бүхий Зүүн бүс, Өмнөд говийн бүсийн зүүн хэсгийг хамрах бөгөөд энэ нутгийн ихэнх хэсэг нь байгалийн хуурай бүс нутагт хамаарах юм. Өөрөөр хэлбэл төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт Хэнтий аймгийн 3 сум, Төв аймгийн 2 сум, Говьсүмбэр аймгийн 3 сум, Дорноговь аймгийн 8 сум, Өмнөговь аймгийн 3 сумын газар нутаг хамрагдаж байна.

Монгол Улсын стратегийн ач холбогдол бүхий шинээр нээсэн арвин нөөцтэй том орд газрууд нь Монгол Улсын өмнө хэсэгт говийн бүсэд байгаа бөгөөд ашиглах, олборлох, боловсруулах уул уурхай, газрын тос, эрчим хүчний үйлдвэрүүдийг энэ бүсэд барьж байгуулж байна. Тухайлбал Оюу толгой, Таван толгойн олборлох баяжуулах үйлдвэрүүд ашиглалтад орсон бөгөөд цаашид Таван толгойн цахилгаан станц, газрын тос боловсруулах үйлдвэр, зэс хайлуулах үйлдвэр, кокс, гангийн үйлдвэрүүд зэрэг томоохон төслүүд үе шаттайгаар ашиглалтад орохоор төлөвлөгдөж байна. Иймд тухайн бүс нутагт өсөн нэмэгдэж буй усны хэрэгцээг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар хангах шаардлага тулгарч байна. Хэрлэн гол дээр ус хуримтлуулах усан сан байгуулж, урсцын тохируулга хийн, ус дамжуулах хоолойгоор дамжуулан усаар хангах нь Говийн бүс нутгийн өсөн нэмэгдэж буй хот суурин, хүн ам, хөдөө аж ахуй, байгаль хамгаалах зориулалтаар ашиглах, томоохон уул уурхайн үйлдвэрийн ус хангамжтай хамтад нь шийдвэрлээд зогсохгүй ногоон байгууламжуудыг дахин сэргээх, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэхэд усны эх үүсвэрийг шинээр бий болгох, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг бууруулж, нөхөн сэргээхэд чиглэсэн асуудлуудыг хамтад нь шийдвэрлэх боломж бүрдэх юм.

1.6. Төслийн хамрах хүрээ


Төслийн хүрээнд судалгааны материалыг үндэслэн газар дээр нь очиж боомт барих болон алсын зайд дамжуулах шугам хоолойн трассуудыг харьцуулж эдийн засаг, нийгэм, экологийн хувьд хамгийн үр ашигтай хувилбарыг сонгон дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэх юм. Үүнд:

Ерөнхий ажлын хамрах хүрээнд доорх ажлуудыг оруулах ба инженерчлэлийн шийдэл, арга зам, шинэ оновчтой хувилбар ажилбар тус бүр дээр нарийвчилсан зураг, төсөв, аргачлал, эдийн засгийн тооцоо цаашид ашиглалтын арга механизм, хууль эрх зүйн оновчтой орчин, үр өгөөжийн бодит тооцоо гээд олон тал дээр суурилсан байх юм.

1. Олон зориулалт бүхий усан цогцолбор


- Боомт
- Ус авах барилга
- Ус халиагуур, ус хаях барилга

- Ус нэвтрүүлэх хоолой
 - Ёроолын ус гаргуур
 - Загас өнгөрүүлэх, хамгаалах байгууламж
 - Барилгын үед голын зарцуулга өнгөрөөх байгууламж
 - Усан цахилгаан станц
 - Ус нөөцлөх талбай байгуулах
 - Борооны болон үерийн усыг тодорхой зайнд цуглуулах, хадгалах, тунгаах, ус татах хоолой хийж цөөрөм рүү холбож хийх
2. Алсын зайд дамжуулах шугам хоолой
- Өргөлтийн насос станц, усан сан
 - Цахилгаан дамжуулах шугам
 - Мэдээлэл холбооны шугам
 - Автозам
 - Нөөц тодорхойлсон дэвсгэр зураг
3. Эдийн засгийн судалгаа
4. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
5. Бусад холбогдох судалгааны ажлуудаас бүрдэнэ.




Зураг 1.1 Хэрлэн-Говь төсөл хамрагдах бүс нутаг


Хэрлэн-Тооно усан цогцолбороос Зүүн өмнөд говийн бүсэд орших төв суурин, уул уурхайн үйлдвэрүүдийг усаар хангах гол шугам хоолойн трассын дагуух нэгдмэл зураг




Зураг 1.2 Хэрлэн-Тоонот усан цогцолбороос усаар хангах гол шугам хоолойн трассын дагуух нэгдмэл зураг



Зураг 1.3 Говийн бүсийн усны эрэлт хэрэгцээ болон газрын доорх усны ашиглалтын нөөцийн харьцаа



Зураг 1.4 Хангайн бүсийн голуудаас говийн бүсийг усаар хангах боломж



Таних тэмдэг:

- Их эрэлт
- - - Дунд эрэлт
- Бага эрэлт
- Газрын доорх усны ашиглах боломжит нөөц
- - - Хэрлэн-Говь төсөл хэрэгжсэнээр ашиглах боломжит усны хэмжээ
- - - Орхон-Говь, Орхон-Онги төслүүд хэрэгжсэнээр ашиглах боломжит усны хэмжээ

Зураг 1.5 Говийн бүсийн усны эрэлт хэрэгцээ болон газрын доорх ус болон гадаргын усыг хослуулан ашиглах боломж

2. ТЭЗҮ-д тодотгол хийх судалгааны ажлын зорилго

ТЭЗҮ-д тодотгол хийж техникийн зураг төсөл боловсруулах судалгааны ажлын гол зорилго нь Хэрлэн гол дээр урсцын тохируулга бүхий ус хуримтлуулах усан сан байгуулж, усан сангаас усыг алсын зайд дамжуулж говийн бүсийн хүн ам, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэр, уурхайг усаар хангах төслийг инженер техник, санхүү, эдийн засгийн хувьд хэрэгжүүлэх боломжит хувилбарт дүн шинжилгээ хийхэд оршино. Судалгааны ажил нь дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

- Техник, санхүү, эдийн засгийн асуудлуудаар мэргэжлийн өндөр түвшинд өргөн хүрээнд судалгаа шинжилгээ хийх;
- Техник, эдийн засаг, техникийн зураг төслийг боловсруулж, хэрэгжилтийн төлөвлөгөөний төслийг бэлтгэх;
- Шаардагдах хөрөнгийн хэмжээг үе шат бүрт тооцон гаргаж, техник, эдийн засаг, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн үнэлгээг нэгтгэн төсөл хэрэгжих үндэслэлийг тодорхойлох;
- Ус хэрэглээний хэтийн төлөвийг хангахын тулд гадаргын болон газар доорх усны эх үүсвэрээс хосолсон байдлаар хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтын үр ашгийн оновчтой шийдэлд хүрэх;
- Усан сангаас усыг алсын зайд дамжуулж, говийн бүсийн хүн ам, мал аж ахуй, газар тариалан, үйлдвэр, уурхайг усаар хангах төлөвлөгөөний хэрэгжилтийн үе шатуудыг тодорхойлох;
- Цөлжилтийг -бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг тодорхой болгох, түүний үр дүн ач холбогдлыг судлах.

Техникийн зураг төсөл нь Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоомж, БНБД-ийн шаардлагуудыг хангасан, олон улсын холбогдох дүрэм журмын дагуу хийгдсэн байх шаардлагатай бөгөөд ТЭЗҮ-ийн судалгааны ажлын үр дүн нь чанарын хувьд олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөх, санхүүжилтийн шийдвэр гаргахад хангалттай түвшинд боловсруулсан байх шаардлагатай юм.

Зөвлөх нь боомт, хиймэл нуур байгуулах, ус дамжуулах шугам барих ижил төстэй төслүүдэд судалгааны ажил хийж байсан туршлагатай, Монгол улсад инженерийн аливаа шатны зураг төсөл зохиох эрх бүхий, энэ чиглэлийн ажлын туршлагатай, үндэсний болон олон улсын компани байж болох бөгөөд шаардлагатай бол тэдгээр компаниуд түншлэн хамтран гүйцэтгэж болно.

Зөвлөх нь Засгийн газрын бодлого, хөтөлбөртэй уялдуулж цөлжилтийг бууруулах, үр нөлөөг тооцох.

ТЭЗҮ боловсруулах судалгааны ажлаас гарсан үр дүнгээр уг төсөл нь байгаль орчин болон нийгмийн хүчин зүйлүүдийн үүднээс хэрэгжүүлэх үндэслэлтэй эсэхийг тодорхойлох юм. Энэ үйл явцад оролцогч талууд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагуудыг хамруулан санал болгож буй төслийн талаарх тэдгээрийн үзэл бодлыг авч үзэх ба шийдвэр гаргах тодорхой үндэслэл болно.

Техник эдийн засгийн үндэслэлийн судалгаа нь санал болгож буй төслийн эдийн засаг болон санхүүгийн байдлыг үнэлэхэд бэлтгэх явдал юм. Энд асуудлуудыг иж бүрэн байдлаар, нухацтай авч үзэн тоон хэлбэрээр хэмжигдэхгүй үзүүлэлтүүдэд шинжилгээ хийж өртөг болон үр өгөөжийг гаргах ажил хамрагдана.

2.1. Судалгааны үе шат, хийх ажил, зорилт

Хэрлэн гол дээр олон зориулалттай усан цогцолбор байгуулах төслийн ТЭЗҮ-ийг Монгол Улс болон олон улсад мөрдөж буй стандарт, дүрэм, журмын дагуу гүйцэтгэх бөгөөд зөвлөх үйлчилгээ дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

1. ТЭЗҮ-ийн судалгаа: Эдийн засаг, санхүүгийн судалгаагаар тодорхойлсон санхүүгийн сорилтуудад үндэслэн урьдчилсан үе шатны судалгаагаар хамгийн сайн хувилбар гэж сонгосон хувилбарыг улам боловсронгуй болгоно.

Судалгааны зорилтууд нь:

- a. Техникийн эцсийн шалгуур үзүүлэлтүүдийг бүх иж бүрдлүүдэд тодорхойлох;
 - b. Барилга байгууламжийн байршил, газар ашиглах шаардлагуудыг эцэслэх;
 - c. Техникийн мэдээ мэдээлэл, тоо баримт зэргийг нэгтгэн эцэслэх (геологи, инженер-геологи, геодези гэх мэт);
 - d. Төслийн хил хязгаар, төсөл хэрэгжүүлэх хугацааны талаар гол хэрэглэгч нартай зөвшилцөлд хүрэх;
 - e. Санхүүжилтийн төлөвлөгөөнд техникийн зардлыг эцэслэн тусгах;
 - f. Төслийн бүх иж бүрдлүүдэд инженерийн тооцоог хийж урьдчилсан зураг төслийг гаргах;
 - g. Эцсийн шатны зураг төсөлд тавигдах шаардлагыг тодорхойлох;
 - h. Төслийн бүх оролцогч талуудын сонирхлыг тусгасан төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, графикийг гаргана.
2. Эдийн засаг, санхүүгийн судалгаа:
 - a. Сонгосон хувилбарын санхүүгийн боломжийн үнэлгээг хийхэд шаардлагатай бүх санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, улс төр, байгаль орчин нийгмийн хүчин зүйлүүдийг тодорхойлж тооцох;
 - b. Санхүү, эдийн засгийн загвар ашиглан мэдрэмж, дүн шинжилгээний эрсдэлүүдийг тодорхойлох;
 - c. Санхүүжилтийн төлөвлөгөөнд санал, зөвлөмж дэвшүүлэх;
 - d. Эцсийн ТЭЗҮ боловсруулах шатанд төсөл хэрэгжүүлэхэд анхаарах санхүүгийн сорилтуудын талаар тодорхойлох.
 3. Олон нийттэй зөвшилцсөн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ. ТЭЗҮ-ийн судалгаанд тулгуурлан төслийн бүх иж бүрдэл хэсгүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой эцсийн шийдвэрийг гаргахад чиглэсэн Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээг хийнэ:

- a. Урсац тохируулах байгууламж болон хиймэл нуур;
- b. Ус дамжуулах шугам хоолой, насос станц;
- c. Цахилгаан дамжуулах шугам
- d. Замын бүтээн байгуулалт

БОНБНУ нь төслийн дараах иж бүрдэл хэсгүүдийг хамруулсан байна:

- a. Хууль эрх зүй, бодлогын асуудлуудын дүн шинжилгээ
- b. Үндсэн нөхцөлүүдийн үнэлгээ
- c. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
- d. Биет/Соёлын өвүүд
- e. Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт
- f. Уугуул иргэд
- g. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
- h. Олон нийтийн оролцоо болон зөвшилцөл

Бүх судалгааг үр дүнтэй, мэргэжлийн өндөр түвшинд өмнө хийгдсэн судалгааны мэдээллүүд, тухайн төсөлд шаардлагатай шинээр нэмж хийгдэх судалгаануудад үндэслэнэ. Гэхдээ төслийн хамгийн оновчтой үр дүнд хүрэхийн тулд шинэлэг, дэвшилтэт программ, үйл ажиллагааны горим нэвтрүүлэн хамгийн сайн мэдээ, мэдээлэл, сүүлийн үеийн туршлагыг олж авах зарчмыг баримтална.

ТЭЗҮ-ийн судалгааг гүйцэтгэн тайланг боловсруулснаар холбогдох олон улсын болон Монгол Улсын Засгийн газрын дүрэм, журмын дагуу тайланг хянуулж, хэлэлцүүлэн баталгаажуулан захиалагчид ажлаа хүлээлгэн өгч зөвлөх үйлчилгээний ажил дуусна.

Судалгааны үе шатуудад хийгдэх ажил тус бүрд тавигдах шаардлагуудын талаар дараагийн бүлэгт нарийвчлан оруулсан болно.

В. СУДАЛГААНЫ ҮЕ ШАТУУДАД ХИЙХ АЖЛУУД

3. ТЭЗҮ-ийн судалгаа

3.1. Танилцуулга

Урьдчилсан ТЭЗ-ийн судалгааны ажлын үр дүнд үндэслэн ТЭЗҮ-ийн үе шатны судалгаа нь дараах үндсэн иж бүрдлүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Төсөл хэрэгжүүлэх бүс нутгийн ус хэрэглээний хэтийн төлөвийн тооцоо хийх
- ТЭЗҮ-ийн үе шатны төслийн бүх иж бүрдлийн техникийн зураг төслийг боловсруулна.
- Байгууламжуудын байршил болон газар ашиглалтын шаардлагуудыг эцэслэх,
- Инженер геодези, геологи, геотехник, инженер геологийн зэрэг хайгуул судалгаа, техникийн мэдээллийг эцэслэн гаргана.
- Томоохон ус хэрэглэгч нартай ажлаа уялдуулж, тэдгээрийн саналыг тусган, төслийн хэрэгжилтийн хугацааг гаргана.
- Гадаргын болон газар доорх усыг ашиглах төлөвлөгөө, үе шатуудыг тодорхойлсон байна.
- Санхүүжилтийн төлөвлөгөөнд техникийн оролцоог эцэслэх,
- Төслийн бүх иж бүрдлээр ТЭЗҮ-ийн шатны инженерийн тооцоо хийж, техникийн урьдчилсан зураг төсөв гаргана.
- Эцсийн зураг төсөлд тавигдах шаардлагуудыг гаргана.
- Бүх оролцогч талын сонирхлыг багтаасан төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, цаг хугацааг тодорхойлж гаргана.

Урьдчилсан судалгааны үе шатанд хамгийн сайн үнэлэгдсэн боомтын хөндлүүрийн сонгосон талбайд 2-оос доошгүй дэд хөндлүүрийг сонгож, үндсэн хөндлүүрийг голын эргийн байдал, боомтын өндөр, өргөн, голын голдрилын сэвсэгр х, үндсэн чулуулгийн байдлаас хамааруулан гидротехникийн барилга байгууламжийн хийц, хэмжээг харьцуулалтын аргаар сонголтыг хийнэ.

Энд хувилбаруудын тойм, сонголт, зураг төслийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, төсвийн зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлүүд багтана. Урьдчилсан судалгааны үед боомтын хөндлүүрийн хувилбараас сонгосон хувилбар, ус дамжуулах шугам хоолойн байршлын сонгосон хувилбар дээр ТЭЗҮ-ийн шатны судалгаа хийгдэнэ.

3.2. Инженер-техникийн судалгаа

Урьдчилсан судалгааны шатанд сонгож авсан боомтын хөндлүүр, ус хуримтлуулах сангийн талбай, ус дамжуулах хоолойн трассын дагууд инженер-техникийн судалгаануудыг нарийвчлан гүйцэтгэнэ.

ТЭЗҮ-ийн шатанд хийгдэх инженер-техникийн судалгаа нь Монгол Улсын Барилгын тухай хууль, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа холбогдох БНБД, стандартын шаардлагыг хангах шаардлагатай.

3.2.1. Инженерийн хайгуул, судалгааны ажил

Техник, эдийн засгийн үндэслэлийн ажлын хүрээнд боомт бүхий ус хуримтлуулах сан баригдах талбай, ус дамжуулах хоолойн трассын дагуу болон бусад төлөвлөж байгаа барилга байгууламжийн талбайд техник эдийн засгийн үндэслэлийн үе шатанд хийх шаардлагатай инженерийн иж бүрэн хайгуул судалгааг хийсэн байна. Инженерийн хайгуул,

судалгаа нь тухайн нутаг дэвсгэрийн хүн амын аюулгүй орчны бүтцийг эвдэхгүй байх, барилга байгууламжийн хийц, бат бэхийн шаардлагад нийцсэн, хайгуул судалгаа хийж байгаа нутаг дэвсгэр, талбайн байгалийн болон техноген нөхцөлүүдийг иж бүрэн үнэлж, судлах үйл ажиллагаа байна.

Зөвлөх нь инженерийн хээрийн хайгуулын тухайн ажилбар бүрийг хийж дууссаны дараа хайгуул хийгдсэн талбайг зориулалтын дагуу ашиглахад тохирох төлөв байдалд оруулсан байна. Зөвлөх нь гадаад улсын харьяалалтай бол инженерийн судалгаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий Монгол улсын түнштэй хамтран ажиллана.

3.2.2. Инженер-геодезийн хайгуулын ажил, зураглал бэлдэх

Энэхүү даалгаврын гол зорилго нь байр зүйн үндсэн зураглалыг бий болгож, боловсруулалтын үр дүнг барилга байгууламжийн талбай тус бүрээр нь нэгтгэх зорилготой юм.

Төслийн байр зүйн зурагтай холбоотой бүртгэл мэдээлэл, агаарын зураглал, өмнө хийгдэж байсан судалгаа, тайлангуудыг цуглуулж, нэгтгэж дүгнэнэ. Ингэхдээ Монгол Улсын эрх бүхий байгууллагууд, тусгай зөвшөөрөлтэй компаниудтай зөвшилцөн хамтран ажиллах шаардлагатай. Техник, эдийн засгийн үндэслэлийн инженер геодезийн ажлыг дараах ажлын бүрдлээр гүйцэтгэнэ. Үүнд:

- Объект, талбайн судалгаа, хайгуул хийх,
- Геодезийн тулгуур сүлжээг өргөжүүлэх, шаардлагатай бол барилга байгууламжид зориулж тусгай зориулалтын геодезийн сүлжээ байгуулах,
- Геодезийн сүлжээнд өндрийн холболт хийсэн байх,
- Ус хуримтлуулах сан, боомт бусад гидротехникийн барилга байгууламжийн талбай, ус дамжуулах яндан хоолойн трассын дагууд зурвас байдлаар байр зүйн зураглал хийж боловсруулах,
- Тоон болон дүрс, гэрэл зургийн хэлбэрүүдтэй хосолсон байр зүйн зургийг шинээр хийх, шинэчлэх,
- Ус хэмжилтийн түр харуул, гидрометрийн хэмжилтийн хөндлүүр, инженер-геологийн бүх төрлийн хэмжилт, өрөмдлөгийн цэгүүдийг байр зүйн зурагт оруулах,
- Ус дамжуулах хоолойн трассын дагуу хайгуулын ажил хийхдээ олон хувилбар бүхий трассын урьдчилсан сонголтыг хийж, трассыг байрлуулна,
- Боомтын талбай, усан сангийн хамрах бүс нутгийн зураглалыг хийхдээ тухайн сум, суурин газар, тариалангийн талбай, бэлчээр, зам, цахилгаан дамжуулах шугам гэх мэтийг газрын зурагт тэмдэглэнэ,
- Судалгааны талбай хамрах газар нутагт хөдлөх болон үл хөдлөх объект, талбай, барилга байгууламж болон байгалийн өвөрмөц тогтоц бүхий газрын дэлгэрэнгүй судалгааг хийнэ,
- Ашиглаж байгаа авто замыг зураглалд оруулж, ус дамжуулах хоолойтой огтлолцож байгаа хэсэгт, хөндлөн болон дагуугийн зүсэлт хийх, цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам, шилэн кабель болон бусад хоолойнуудыг зураглалд оруулж, барилга байгууламжийн трасстай огтлолцож байгаа байдлыг үзүүлэх,

Зөвлөх нь төсөл хэрэгжих талбайд байрзүйн зураглалыг тохиромжтой масштаб, үеийн өндөртэйгөөр газарзүйн мэдээллийн системийн программ болон AutoCAD программ дээр дараах байдлаар гүйцэтгэсэн байна.

- Ус хуримтлуулах сангийн усанд автах талбайд 1:10000 масштабтай, үеийн өндөр 5 метр,

- Боомтын хөндлүүр, гидротехникийн барилга байгууламжийн талбайд 1:1000 масштабтай, үеийн өндөр 1 метр,
- Ус дамжуулах шугамын трассын дагууд 200 метр хүртэл өргөнтэй зурвасын байр зүйн зураглалыг 1 : 25 000 эсвэл түүнээс илүү нарийвчлалтай, үеийн өндөр 5 метрээс багагүй,
- Өргөлтийн насос станц, усан сан байгуулах талбайд 1:5000 масштабтай, үеийн өндөр нь газрын гадаргын налуугаас хамааран 1-5м байна.
- Хиймэл дагуулын мэдээллийн боловсруулалтыг газарзүйн мэдээллийн системийн программаар хийнэ.

Байр зүйн зураглал нь боомт бүхий ус хуримтлуулах сан, усан цогцолборын бүрэлдэхүүн хэсгүүд, барилгын ажил явагдах кемп, материал хадгалах талбай, насос станц, ус цэвэршүүлэх байгууламж, шугам хоолой, ус авах байгууламж, цахилгаан дамжуулах шугам, зам, нөөцлөх технологи зэрэг бүхий л барилга байгууламжийг багтаан оруулах боломжтой байна.

Томоохон ус хэрэглэгчид, тэдгээрийн өндөржилт, шугам хоолойн сегментүүдийн урт, насос станц, ус нөөцлөх сангийн байршил, хүчин чадлыг харуулсан ус хангамжийн шугам, сүлжээний газрын зураг байх шаардлагатай. Энэ зурагт төсөл хэрэгжих бүс нутагт одоо ажиллаж байгаа үйлдвэр, уурхайн ус хангамжийн шугам сүлжээний зургийг хамруулан оруулсан байна.

Тооцоо, зураг схемийг агуулсан судалгааны ажлын хүрээнд хийгдсэн бүх ажлуудыг топогеодезийн тайланд оруулсан байна.

3.2.3. Бичил уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийн үнэлгээ

Зөвлөх нь Хэрлэн гол дээр урсцын тохируулга хийж ус хуримтлуулах сан байгуулсны нөлөөгөөр бий болох төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн уур амьсгалын өөрчлөлт, дэлхийн дулаарал, голын урсцын өөрчлөлтөд үзүүлэх хандлагыг тойм байдлаар гаргаж үзүүлнэ.

Зөвлөх нь ус хуримтлуулах сан байгуулснаар тухайн орчны бичил цаг уурт үзүүлэх нөлөөлөл, үерийн улмаас усны түвшин нэмэгдэх тохиолдолд урсцыг хянах зэрэг боломжит нөлөөллийг үнэлэх ёстой.

Зөвлөх нь хил залгаа БНХАУ-тай харьцуулан бүсчилсэн цаг уурын загварчлалын судалгааг тойм байдлаар гүйцэтгэж голын урсцын горимын өөрчлөлтийн магадлалыг үнэлж, усны урсцын хамгийн их магадлалтай урсгалын горимд боловсруулалт хийх аргыг оновчтой болгох, тал бүрийн өөрчлөлт хувиралын харилцан хамаарлыг судална.

3.2.4. Ус зүйн судалгаа

Урьдчилсан шатанд хийгдсэн ажлын хэмжээнд харгалзуулан техник эдийн засгийн үндэслэлд шаардлагатай нэмэлт цаг уурын болон ус зүйн судалгаа хийж тайланг илүү нарийвчлан, шинэчлэн гаргана.

Цуглуулсан мэдээ, мэдээлэлдээ тулгуурлан гидрологийн үнэлгээ судалгааг дараах чиглэлээр хийнэ:

- Боомтын ус хураах талбайн хэмжээг тогтоох;
- Төлөвлөж буй боомтын усан сангийн түвшинг урт хугацааны туршид тооцоолох;
- Хэрлэн голын хагшаасны хөдөлгөөний судалгааг хийх;
- Боомтын усан сангийн талбайн газрын доорх болон гадаргын усны хоорондын уялдаа холбоонд дүн шинжилгээ хийх;
- Усны ууршилтын хэмжээг судлах;
- Хэрлэн голын мөсөн бүрхэвч, температурын өөрчлөлтийг тодорхойлох;

- Боомт байгуулах хөндлүүрт Хэрлэн голын урсцын хангамшлыг 0.01%, 0.1% 1%, 5%, 25%, 50%, 75% -иар тодорхойлох;
- Шаардлагатай гэж үзвэл, боомтын ойролцоо түр зуурын хяналтын систем байрлуулан урсгалын хурдыг тодорхойлох.

Зөвлөх нь усны баланс, урсцын ирээдүйн хандлага, түүнд үзүүлэх уур амьсгал, хүний үйл ажиллагааны хүчин зүйлийн нөлөөллийн тооцоог боловсруулна. Энд сав газрын хэмжээнд иж бүрэн тооцох загварыг сонгон зүгшрүүлж, үр дүнг хэд хэдэн нөхцөлөөр гаргаж, үнэлнэ.

Төсөл хэрэгжсэнээр Хэрлэн голын экосистемд хэрхэн нөлөөлөх асуудал чухалаар тавигдана. Иймд Хэрлэн голын урсцын горимын өөр өөр онцлог үеийг тодорхойлж, энэ нь тухайн голын голдрил, татам, сав газарт орших амьд организм, амьтан, ургамлын төрөл зүйлтэй хэрхэн уялдан зохицож буй хамаарлыг тогтоосны үндсэн дээр экологийн/орчны урсцын тооцоог сонгосон хөндлүүрт боловсруулах нь чухал юм.

Ажлын үр дүнгээр боомт барих хөндлүүрийн барилга байгууламжийн тооцооны үндсэн үзүүлэлтүүдийг тодорхойлж, урсац тохируулгын тооцоог гүйцэтгэнэ.

3.2.5. Геологи, геофизик, гидрогеологи, инженер-геологийн хайгуул, судалгаа

Зөвлөх нь инженер геологийн хайгуулын явцад тухайн төсөлд хамрагдаж байгаа нутаг дэвсгэр, зурвас болон барилга байгууламжийн талбайд урьд өмнө хийгдэж байсан геологи, гидрогеологи, инженер геологийн зориулалттай хийгдсэн ажлын нэр төрөл, хамрагдсан хүрээ, гүйцэтгэсэн хугацаа, судалгааны арга, аргачлал, гарсан үр дүн, судалгаанд ашигласан мэдээллийн чанарын ба тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулалт хийж дүгнэлт өгсөн байна.

Физик газар зүй, уур амьсгал, геологи, геоморфологийн тогтоц, инженер геологийн үзэгдэл, үйл явц, физик, геологи болон техноген нөхцөлүүдийг энэ үе шатны ажлын хүрээнд тодорхойлж гаргаж ирсэн байна.

Техник, эдийн засгийн үндэслэлийн инженер геологийн ажлыг дараах ажлын бүрдлээр гүйцэтгэнэ. Үүнд:

- Төсөл хэрэгжих талбайд урьд өмнө хийгдсэн инженер геологийн ажлын материал, мэдээллийг цуглуулах, судалж боловсруулах,
- Агаарын болон сансрын зурагт болон хамгийн сайн нарийвчлалтай боловсруулсан геологийн зураглалд тайлал хийж боловсруулах,
- Тойм судалгаа
- Маршрутын судалгаа
- Геофизикийн судалгаа
- Өрөмдлөг, малталтын ажил
- Талбайн ул хөрсний туршилт, судалгаа
- Боомт барих талбайн хөндлүүрийн ул хөрсөнд шүүрэлтийг тодорхойлох болон үндсэн чулуулгийн ан цавыг тодорхойлох цутгалтын туршилт, судалгаа,
- Гидрогеологийн судалгаа,
- Хөрсний цэвдгийн гүн зузааныг тодорхойлно,
- Боомт, авто зам болон бусад гидротехникийн барилгад хэрэглэх элс шороон болон чулуу, материалын судалгаа,
- Судалгаа шинжилгээний үр дүнгийн боловсруулалт хийх,

- Техникийн тайланг бичиж, боловсруулах зэрэг ажлууд орно.

Төсөл томоохон нутаг дэвсгэрийг хамарч байгаа учраас орчны инженер геологийн нөхцөл, инженер геологийн төрөл бүрийн үзэгдэл үйл явцыг судалж, хил хязгаарыг тогтоох, үйл явцын эрчмийг судалж дүгнэлт өгөх юм. Дөрөвдөгчийн сэвсгэр хурдасны гарал үүсэл, төрөл, тэдгээрийн тархалтын хил хязгаар, гүний хагарал болон хадан хөрсний ан цавын бүс, гүний ба хөрсний усны тархалт, байршил, түүний тэжээгдэл хуримтлалын бүсийг тогтоох зэрэг болно.

Тойм болон маршрутын судалгаа нь төсөлд хамрагдах нутаг дэвсгэр, зурвасын хамрах хүрээ, орчны инженер геологийн нөхцөлийн талаар ямар нэгэн мэдээлэл байхгүй, эсвэл хүнд нөхцөлтэй байх тохиолдолд газар дээр нь танилцаж, хайгуул явуулах хөтөлбөрийг нарийвчлан боловсруулж, судалгаа явуулах арга, аргачлал, тоо хэмжээг нарийвчлан тогтооход оршино.

Геофизикийн хайгуулыг Хэрлэн гол дээр баригдах боомтын боломжит хөндлүүрүүд, ус хуримтлуулах сангийн талбайг хамруулан явуулна. Энэ судалгаагаар уг талбайн хадан болон цэвдэг хөрсний илрэх гүн буюу дээд хил зааг, зузааныг тодорхойлж, гүний хагарал, ан цавын хил заагийг тогтооход чиглэгдэнэ. Голын хөндийн хөрсний болон гүний усны түвшнийг тогтоож, түүний урсгалын чиглэлийг тогтооно. Мөн сейсмологи, газар хөдлөлийн мужлалын судалгаанд зориулж геофизикийн судалгааг явуулж болно. Зөвлөх нь эдгээр геофизикийн судалгаа бүрд тохирсон арга, аргачлалыг сонгож өрөмдлөгийн хайгуултай хослуулан гүйцэтгэнэ.

Гидрогеологийн судалгаагаар боомт бүхий ус хуримтлуулах сангийн талбайд хөрсний болон гүний усны тоон үзүүлэлтүүд болон усны химийн найрлага, зэврэлт, идэмхий чанарыг ус агуулагч үе давхарга тус бүр дээр тогтоож, барилга ашиглалтын үед гарч болох хөрсний, усны горимын өөрчлөлт, усанд автагдахаас хамгаалах арга зам, горимд ажиглалт, хэмжилт хийх аргачлал, зөвлөмжийг тусгасан байна. Ус дамжуулах хоолойн трассын дагууд хөрсний усны илрэх гүн газрын гадаргад ойр байгаа хэсгүүдийг тогтоож, тайланд үзүүлсэн байна. Шаардлагатай газруудад гидрогеологийн мониторингийн цооног байгуулж газар доорх усны горимын (сар, улирал, жилээр) судалгаа хийж дүгнэлт гаргана.

Зөвлөх нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, талбай, төслийн барилга байгууламжийн (ус хуримтлуулах сан, боомт, ус хаях барилга, ус дамжуулах шугам, өргөлтийн станц г.м) бүрдлийн хэмжээнд инженер геологийн нөхцөлийг тодорхойлно. Төслийн талбай болон барилга байгууламжийн талбайд геологийн зураг, геологийн тайлан гаргана.

Одоо байгаа өгөгдөл, зураг, агаарын зургийн хайгуул дээр үндэслэн бүсчилсэн байдлаар геологийн үнэлгээ хийнэ. Бүсчилсэн геологийн зураг, геологийн зүсэлтүүд болон сейсмо-тектоникийн зураг бэлдсэн байна.

Геологи, геофизик, инженер-геологийн хайгуул судалгаа нь байр зүйн зурагтай холбогдсон байх шаардлагатай. Инженер-геологийн хайгуул судалгаа нь сонгогдсон шугам, профилийн дагуу хийгдэнэ.

Инженер-геологийн хайгуул судалгаагаар хөрсний өрөмдлөг, хадан хөрсний өрөмдлөг, керн авах, дээж авах, суваг шуудуу ухах, цутгалтын тест, боомтын эрэгтэй нийлэх хэсэг дэх галерей, талбай дээрх тест, лабораторийн шинжилгээ болон тайлан, түүний шинж чанарын дагуу хөрсний болон хадан үеийг тодорхойлох ажлууд хийгдэнэ.

Инженер-геологийн үнэлгээ нь төслийн дараах бүрдэл хэсгүүдээр гүйцэтгэсэн байна.

- Ус хуримтлуулах сан (ус хуримтлуулах сангийн ус үл нэвтрүүлэлт, аливаа алдагдал, налуугийн тогтворшил г.м)

- Боомт
- Бусад гидротехникийн барилга байгууламж
- Дэд станц
- Барилгын материалын ордууд
- Боомтын орчмын дэд бүтэц
- Ус дамжуулах шугам хоолой
- Өргөлтийн насос станц, хиймэл нуур
- Ус цэвэршүүлэх байгууламж
- Авто зам

Боомтын хөндлүүрийн сонголт хийх хувилбар тус бүр дээр шаардлагатай бүтэн дээж авах өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэх шаардлагатай бөгөөд энэ ажлын үр дүн нь боомтын үндсэн хөндлүүрийг сонгох гол үндэслэл болно. Ус хуримтлуулах сангийн талбайд 1 км хавтгайд $0.2 \div 0.4$ ширхэг цооног байхаар өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэнэ.

Боомтын хөндлүүрийн хувилбар бүр дээр боомт барихаар урьдчилан сонгосон талбайд шаардлагатай цооног өрөмдөнө. Цооногуудын гүн нь үндсэн чулуулгийг нэвтэрсэн байх бөгөөд боомтын ёроолд өрөмдөх чулуулгийн ан цавыг тодорхойлох шавхалт, цутгалтын ажил хийгдэх цооногийн гүн үндсэн чулуулагт 20 хүртэл метр гүн нэвтэрсэн байна.

Ус дамжуулах хоолойн трассын дагууд 1 км тутамд инженер геологийн өрөмдлөгийг явуулахаар төлөвлөх бөгөөд гүн нь яндан хоолой суулгах гүнээс доош 1-2 метр гүн байна. Тухайн зурвасын дагуух инженер геологийн нөхцөлөөс хамааруулан өрөмдлөг, малталтын хоорондын зайг ихэсгэж, багасгаж болно.

Насос станц, хиймэл нуур болон бусад байгууламж барих талбайд 2-3 цооног өрөмдөхөөр төлөвлөх шаардлагатай. Мөн цахилгаан дамжуулах шугам, автозам шинээр төлөвлөх зурвас талбайд 3 км тутамд 5-6 м гүнтэй цооног өрөмдөхөөр ажлын хэмжээг тооцсон байна. Өрөмдлөг, малталтын 30-аас доошгүй хувьд дээжлэлт хийж лабораторийн шинжилгээ хийнэ. Боомт барих талбайд үндсэн чулуулгийн гүний хагарал, ан цавын байршлыг тодорхойлно. Зөвлөх нь инженер геологийн төвөгтэй нөхцөл эсвэл байж болох эрсдэлийг тодорхойлон тайлбар өгнө.

Хайгуул судалгааны төлөвлөгөөний хугацаанд дээж авах болон талбайн туршилтын ажлыг байнга гүйцэтгэнэ. Сонгосон хөрсний дээж болон цооногийн өрөмдлөгийн үед авсан кернийг лабораторт илгээж хөрсний чанар, үзүүлэлт, барилга байгууламжийн хийцийн сууринд тохиромжтой эсэх, барилгын материалд хэрэглэж болох эсэхийг баталгаажуулна. Ангилсан өрөмдлөгийн кернийг агуулахад цуглуулж, бусад дээжийг аюулгүй газар хадгална.

Инженер геологийн судалгааны ажлын үр дүнгээр боомт, гидротехникийн барилга байгууламжийн талбайд 1:5000, ус хуримтлуулах сангийн талбайд 1:10000, ус дамжуулах хоолойн трассын дагууд 1:25000-ын тус тус масштабтай инженер геологийн зураг, шаардлагатай тооны хөндлөн болон дагуугийн зүсэлтийг хийж тайланд хавсаргана.

Судалгааны бүх ажлын хүрээнд хийгдсэн судалгаа шинжилгээ, тооцооны үр дүнг геологи, геофизик, гидрогеологи, инженер-геологийн хайгуул, судалгааны тайланд оруулсан байна.

3.2.6. Газар хөдлөлт, чичирхийллийн судалгаа

Өмнө нь болж өнгөрсөн газар хөдлөл, чичирхийллийн нөлөөг судалсан ажлын нэр төрөл, хамрагдсан хүрээ, гүйцэтгэсэн хугацаа, судалгааны арга, аргачлал, гарсан үр дүн, судалгаанд ашигласан мэдээллийн чанарын ба тоон үзүүлэлтүүдийг нэгтгэн боловсруулж, судалгааны үр дүнг нягтлан дүгнэлт өгсөн байна.

Хэрлэн гол дээр барихаар төлөвлөж байгаа ус хуримтлуулах сан, боомтын талбайд газар чичирхийллийн судалгааг дэлгэрэнгүй явуулах бөгөөд газрын гадаргууд болон газар доорх үндсэн чулуулагт үүссэн ан цав, хагарлын урт, босоо хэвтээ шилжилт, эвдрэлийн төрлийг тодорхойлох хээрийн хайгуулыг явуулна. Чулуулгийн физик, механик шинж чанар, насыг тодорхойлох лабораторийн шинжилгээг хийсэн байна.

Ус хуримтлуулах сан, боомтын талбайд судалгааны тайлангаар бичил мужлалын зургийг зохиосон байна. Ус дамжуулах хоолойн трассын дагууд газар хөдлөлийн мужийг тодорхойлж гаргасан байна.

Зөвлөх нь боломжит хувилбар тус бүрийн газар чичирхийллийн нөлөөллийг үнэлэх бөгөөд чичирхийллийн судалгааны хүрээнд бүс нутгийн газар чичирхийлэлд тодорхойлолт өгч, газар чичирхийллийн аюулыг үнэлнэ. Энд нөлөөллийн бүс, газар чичирхийллийн эх үүсвэр, тооцоот хамгийн их газар хөдлөлт, төслийн ашиглалтын үеийн тооцоот хамгийн их газар хөдлөлт, тооцоот газар хөдлөлтийн хурдатгал, ус хуримтлуулах сан байгуулахад үүссэн газар чичирхийлэл зэрэг үзүүлэлтийг тодорхойлно.

Бүс нутаг, төслийн талбайд одоо байгаа чичирхийллийн сүлжээг хянан үзэх бөгөөд бүс нутаг, төслийн талбайн газар чичирхийллийн үйл ажиллагааг нягт хянах зорилгоор үүнийг сайжруулах арга замыг санал болгоно.

3.2.7. Барилгын материалын хайгуул судалгаа

Боомт, гидротехникийн бусад барилга байгууламж, авто замд шаардлагатай шавар, элс, хайрга, чулуу зэрэг барилгын шороон материалын хайгуул судалгааг явуулна. Мөн бетонд хэрэглэх хайрга, дүүргэгч материал, элсний орд газрын судалгаа хамрагдана. Барилгын шороон материалын судалгаа нь олборлох шаардлагатай эх үүсвэр, ордуудын талбайн зураг, тоо хэмжээ, чанар, уул геологийн нөхцөлийн талаар зайлшгүй хэрэгтэй мэдээлэл авах боломжийг хангасан байх бөгөөд янз бүрийн байрлал дахь материалын дээжийн тест, байршлын зураг, замын зураг, барилгын материалын орд хүртэлх замын маршрут, барилга барих талбайн байршлыг үзүүлсэн байна.

Нэмэлтээр цемент, ган, модон материал зэрэг бусад гадаад болон дотоод материалын эх үүсвэрийг тодорхойлно. Шороон материалыг судалгааны үед байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг оновчтой ашиглах шаардлагыг үндэслэн холбогдох норм, стандарт, журмын дагуу энэ судалгааг явуулна. Барилгын үед хэрэглэх усны судалгааг явуулсан байна.

Явуулсан судалгаа шинжилгээ, гарсан үр дүн, тооцоо зэргийг агуулсан судалгааны хүрээнд гүйцэтгэсэн бүх ажлыг барилгын материалын тайланд үзүүлнэ.

3.2.8. Техникийн нөхцөл

ҮҮНД:

- Дэд бүтцийн инженерийн барилга байгууламжийн бүхий л зөвшөөрөл
- Газрын зөвшөөрөл
- Замын зөвшөөрөл
- Байгаль орчны асуудалтай холбоотой зөвшөөрөл
- Хууль эрх зүйн зөвшөөрөл
- Ашиглалтын зөвшөөрөл
- Усны хэрэг эрхлэх газрын зөвшөөрөл
- Холбогдох төрийн болон орон нутгийн захиргааны байгууллагын зөвшөөрөл

3.3. ТЭЗҮ-ийн техникийн тооцоо, шийдэл

3.3.1 Хэрлэн голын урсцын тохируулга, гидротехникийн барилга байгууламжийн техникийн шийдэл

Энэ хэсгийн судалгаагаар Хэрлэн гол дээр баригдах боомт, хиймэл нуур, гидротехникийн барилга байгууламжуудын техникийн шийдлийг авч үзнэ. Хэрлэн гол дээр баригдах ус хуримтлуулах сан, боомтын хамгийн боломжтой байршлыг сонгоно. Сонгосон байрлалд ямар хийцтэй боомтыг байгуулах, үндсэн хэрэглэгчдийн ус авах байгууламж, үерийн болон экологийн урсцыг боомтоор дамжуулан өнгөрүүлэх байгууламж, усан цогцолборын барилтын үеийн нөхцөл, ашиглалтын байгууламжууд зэргийн үндсэн тооцоо, сонголтыг хамруулсан байна.

Гадаргын усыг алсын зайнд дамжуулан авч ашиглахын тулд үндсэн ус хэрэглэгчдэд ойрхон, ус шахах станцад бага ачаалалтай байх, хэрэгцээтэй усыг нөөцлөх боломжтой тогтворжилт сайн, бат бэх байх гэсэн үндсэн шаардлагаас гадна ус хуримтлуулах сангийн талбай аль болох бага, усны эзлэхүүн их, боомтын урт, түүний хөрөнгө оруулалт бага байх зэрэг нөхцөлүүдийг харгалзан үзэж ус хуримтлуулах сан, боомт байгуулах хөндлүүрийг сонгох шаардлагатай.

3.3.2 Хиймэл нуурын техникийн үндсэн үзүүлэлтүүдийн хувилбарууд, сонголт

Хэрлэн гол дээр барихаар төлөвлөж байгаа ус хуримтлуулах сангийн геодезийн ажлын үзүүлэлтүүдийг тооцон гаргаж үзүүлэх бөгөөд усны аж ахуйн тооцооны үр дүнд ус хуримтлуулах сангийн үндсэн үзүүлэлтийг тодорхойлно. Усны аж ахуйн тооцооны үр дүнд боомт барихаар сонгосон хөндлүүрт, урсац тохируулгын тооцоог хийн, ус хуримтлуулах сангийн ашигтай эзлэхүүн болон бусад шаардлагатай параметруудийг тодорхойлсон байна. Мөн тооцооны үр дүнд ус хуримтлуулах сангийн усны хамгийн доод түвшин, хэвийн тогтсон түвшин, хамгийн их түвшин, хамгийн их сүр (Форсированный) түвшин зэргийг тодорхойлно.

Ус хуримтлуулах сангийн ууршилт, шүүрэлт зэрэг алдагдлын хэмжээг тооцсон байна. Боомтын доод хашицын усны түвшний тооцоог хийнэ. Мөн өвлийн улиралд доод хашицад үүсэх мөс, халианы горимыг авч үзнэ. Шар усны болон хур тунадасны үерийн тооцоот зарцуулгыг тохируулах, түүнийг боомтоор өнгөрүүлэх асуудал энд хамрагдана. Ус хуримтлуулах сангийн эхний дүүргэлт хагшаас хуримтлагдах тооцоог хийсэн байвал зохино.

Боомтын хийц, хэмжээний хувьд боломжит бүх хувилбаруудыг авч үзэх бөгөөд техникийн шийдлийн сонголтын эцсийн хувилбарыг техник, эдийн засгийн тооцооны харьцуулалт хийж сонгосон байна.

Энд хувилбаруудын тойм, сонголт, зураг төслийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, төсвийн зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлүүд багтана.

3.3.3 Гидротехникийн барилгын төрөл хийц, үндсэн хэмжээнүүдийг тодорхойлох

Зөвлөх нь энэ хэсэгт Хэрлэн гол дээр баригдах боомт болон бусад шаардлагатай үндсэн болон туслах зориулалтын гидротехникийн барилга байгууламжийн төрөл, хийц, үндсэн хэмжээг тодорхойлох юм.

Гидротехникийн барилгын төрөл хийц, үндсэн хэмжээг тодорхойлох ажил нь дараах барилга байгууламжийг хамруулан авч үзнэ.

1. Боомт

2. Ус авах барилга
3. Ус халиагуур, ус хаях барилга
4. Ус зайлуулах хоолой
5. Ёроолын ус гаргуур
6. Загас өнгөрүүлэх, хамгаалах байгууламж
7. Барилгын үед голын зарцуулга өнгөрөөх байгууламж
8. Усан цахилгаан станцын байшин
9. Өргөлтийн насос станц, усан сан
10. Алсын зайд дамжуулах шугам хоолой
11. Цөөрмийн барилга байгууламж

Үндсэн байгууламж болох боомтын их биеийн хийц, хэмжээг нарийвчлан тодорхойлох бөгөөд их биеийн шүүрэлт, суулт, тогтворжилтын тооцоог хийсэн байна. Боомтын их биеийг голын эргийн болон голдирлын доорх үндсэн чулуулаг бүхий хадан хөрстэй холбох, суурь, хадан ул хөрсний шүүрэлтийн эсрэг тооцоог хийж шаардлагатай хийцүүдийг төлөвлөнө.

Усан цахилгаан станц байгуулах боломжийг авч үзсэн байх шаардлагатай бөгөөд хэрэгжүүлэх ач холбогдлыг авч үзэж оновчтой эсэхийг тодорхойлох.

Шар усны болон хур тунадасны тооцоот үер өнгөрүүлэх, хагшаас зайлуулах байгууламжийн тооцоо, сонголтыг хийнэ. Боомт, шаардлагатай бүх байгууламж, голын хэвийн урсцыг өнгөрүүлэх болон алсын зайд ус дамжуулахад зориулсан ус авах барилга, өргөлтийн насос станцыг төлөвлөнө. Ус авах барилгын хувьд боломжит хувилбаруудыг авч үзэх ба Монгол орны нөхцөлд тохирсон ашиглалтын хувьд найдвартай ажиллах байгууламжийн төрлийг сонгох шаардлагатай.

Хог тогтоох болон загас хамгаалах, өргөх механизмууд, доод хашицын байгууламжууд зэрэг шаардлагатай бүх барилга байгууламжуудыг авч үзсэн байна. Боомтын барилгын үед Хэрлэн голын усыг өнгөрөөх түр барилгууд болох дээд ба доод хашицын түр боомтууд, барилгыг үерийн голын урсцыг өнгөрөөх байгууламж болон барилгын ажилд шаардлагатай бусад бүх байгууламжуудын төлөвлөлтийг хийнэ.

Энд хувилбаруудын тойм, сонголт, зураг төслийн техникийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, төсвийн зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлүүд багтана. Төлөвлөж буй хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний зардлын тодорхойлолт, тэдгээрийн хэсэгчилсэн хийцийн жагсаалт, барих ба хүлээлгэн өгөх төсвийн зардлуудыг урьдчилсан байдлаар бэлтгэх ёстой.

3.3.4 Гидравлик судалгаа

Ус хуримтлуулах санд орж ирэх хамгийн их тооцоот хангамшилтай үерийн мөрийн дагуу ус хаях барилгын хүчин чадал, зарцуулгыг тодорхойлохоос гадна ус хуримтлуулах сангийн ажиллагааны дүрэм, боомт, ус хаях барилгын доод хашицын усны түвшнийг тооцно.

Зөвлөх нь үерийн зарцуулгыг өнгөрөөх тооцоонд хэрэглэх туршилт болон критер, загвар, аргачлалыг гаргаж үзүүлсэн байна.

Ус хаях барилгын хүчин чадлыг боомтын эхний болон сүүлийн шатны хугацаанд хамгийн их тооцоот хангамшилтай үерийг өнгөрөөж байхаар төлөвлөсөн байна.

Ус хуримтлуулах сангийн усны түрэлтийн судалгаагаар түүний байршилд усны хамгийн их түвшнийг тодорхойлж, боомтын тэнхлэгээс хамгийн их алсагдах зайг тодорхойлно.

Ус хуримтлуулах сангийн хагшаасны судалгаа нь аргачлал, хагшаасны шинж чанар, эзлэхүүн, ус хуримтлуулах санд хагшаас хуримтлагдах байдал, боомтын дээд хашиц дахь хагшаасны түвшин, ус хуримтлуулах санг ашиглалтад оруулж эхэлснээс хойш 50 жилийн хугацаанд ус хуримтлуулах сангийн хөдөлшгүй эзлэхүүн болон ашигтай эзлэхүүний

бууралт, усны түвшнээс хамаарсан усан мандлын талбай, усны эзлэхүүний муруй гаргасан байна.

Эдгээр судалгааны үндсэн дээр ус хуримтлуулах сангийн талбай түвшний хамаарал $F(H)$, эзлэхүүн түвшний хамаарал $V(H)$ үзүүлэлтийг гаргана.

Урьдчилсан судалгааны ажлын хэмжээнд тулгуурлан техник эдийн засгийн үндэслэлд шаардлагатай нэмэлт судалгаа хийж, боловсруулалт хийн шинэчилсэн тайлан гаргана. Тусгаарлах хана, боомт, ус халиагуур, ёроолын ус гаргуур, барилтын үед голын усны зарцуулга өнгөрөөх байгууламж, суваг зэрэг байгууламжийн хэмжээг тодорхойлох, гидравлик бүтцийг оновчтой болгоход шинэчилсэн тооцоог ашиглана.

Шинжилгээ болон тооцоо, дүгнэлтийг оролцуулан дээрх хүрээнд багтсан бүх ажлыг гидравлик судалгааны тайланд үзүүлнэ.

3.3.5 Усан сангийн ажиллагаа, түүний загварчлал

ТЭЗҮ-ийн үе шатанд төслийн хувилбар бүр дээр дараах ажлууд хийгдэнэ. Хамгийн сүүлийн үеийн үнэн зөв гидрологийн ажиглалтын мэдээлэл дээр үндэслэн ус хуримтлуулах сангийн загварчлал гаргана. Ус хуримтлуулах сангийн усны түвшинг тооцоолно (хамгийн бага, хэвийн болон хамгийн их). Доод хашиц дахь зарцуулгын муруйг байгуулна.

Цахилгаан болон эрчим хүчний шинжилгээнд ус хуримтлуулах сангийн ажиллагаа болон загварчлалын судалгааг авч үзсэн байна. Энэ тайланд загвар, аргачлалын хамтаар шинжилгээний үр дүн болон ашигласан өгөгдөл, критерийг оруулсан байна.

Зөвлөх нь ус хуримтлуулах сангийн ажиллагааны судалгаа хийхдээ сүүлийн үед олон улсад хэрэглэж байгаа арга аргачлалын дагуу компьютерын программ хангамжийг ашиглан ус хуримтлуулах сангийн 50-60 жилийн хугацааны ажиллагааны горимын шинжилгээний загварчлалаар хангасан байна. Эдгээр сценарьг эдийн засаг, санхүү, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн судалгааны үе шатанд үнэлнэ.

Зөвлөх нь барилгын үе шатны ажилтай уялдуулан ус хуримтлуулах сангийн дүүргэлтийн тооцоо хийж дүүргэх хуваарийг бэлтгэн гаргана. Эдгээр сценарьг эдийн засаг, санхүү, байгаль орчин болон нийгмийн нөлөөллийн судалгааны үе шатанд үнэлнэ.

Зөвлөх нь төслөөр тодорхойлсон ажиллагааны горимд нийцэх ус хуримтлуулах сангийн үйл ажиллагаа, дэглэмд хяналт тавих боломжтой зохион байгуулалтын арга хэмжээг олон улсын туршлага дээр тулгуурласан байдлаар дүн шинжилгээ хийнэ. Хувилбаруудын давуу болон сул талуудыг тодорхойлсон байх ёстой. Зөвлөх нь ус хуримтлуулах сангийн эхний дүүргэлтийн төлөвлөгөө хуваарийг гаргахын зэрэгцээ ус хуримтлуулах сангийн байнгын үйл ажиллагааны хувьд ашиглалтын байгууллагын тогтолцоог тодорхойлж, зөвлөмж гаргана.

Ус хуримтлуулах сангийн загвар, урсац тохируулгын загварчлал:

Ус хуримтлуулах сангийн загвар гаргахаас өмнө сонгосон хөндлүүрийн хувьд дараах мэдээллүүд бэлэн болсон байна.

- Голын урсцын сар, жилийн дундаж урсац
- Ус хуримтлуулах сангийн хөдөлшгүй эзлэхүүний түвшин
- Ус хуримтлуулах сангийн хэвийн тогтсон эзлэхүүн, хэвийн тогтсон түвшин
- Ус хуримтлуулах сангийн хамгийн их эзлэхүүн, хамгийн их түвшин
- Ус хуримтлуулах сангийн ашигтай эзлэхүүн
- Усны алдагдал /шүүрэлт, ууршилт, мөс үүсэлт/
- Ус дамжуулах шугамын хүчин чадал

Ус хуримтлуулах сангийн загвар гаргахдаа хамгийн сүүлийн үед олон улсад хэрэглэж байгаа загварчлалыг ашиглана. Загварын зорилго нь Хэрлэн гол дээр байгуулах ус хуримтлуулах сангаас Хэрлэн голын усны нөөц горимд үзүүлж болох нөлөөллийг тодорхойлох шинжилгээ хийх, усан сангийн дүүрэлтийн явцад дүн шинжилгээ хийх үндсэн зорилготой байна.

Загвар нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ. Үүнд:

- Орж ирэх урсацууд (Ус судлалын харуулын мэдээлэл)
- Төлөвлөж буй ус хуримтлуулах сан
- Ус хангамжийн мэдээ (татах усны хэмжээ)
- Бага урсац (хүрээлэн буй орчны урсцын хэмжээ)
- Төгсгөлийн цэг буюу доод хашицад гаргах урсцыг тооцох
- Усан сангийн дүүргэлтийн тооцоо, дүүргэх хугацаа

3.3.6 Усан цогцолборын ашиглалтын хувилбарууд, тэдгээрээс сонголт хийх

Хэрлэн гол дээр төлөвлөж байгаа ус хуримтлуулах сан, гидротехникийн барилга байгууламжийн ашиглалтын үеийн горим, байдлыг авч үзсэн байна. Энэхүү ус хуримтлуулах сан нь хүн ам, үйлдвэр, хөдөө аж ахуйн ус хангамж, голын экологийн зориулалттай урсац тохируулга, байгаль орчин, аялал жуулчлалын зэрэг олон төрлийн зориулалттай ашиглагдана.

Урсац тохируулгын тооцооны үр дүнд ашиглалтын үеийн диспетчерийн графикийг боловсруулах бөгөөд ус хуримтлуулах сангаас хэрэглэгчдэд ус өгөх болон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэл, голын доод хэсэгт байх ёстой хүрээлэн буй орчны урсац нөгөө талаас ус хуримтлуулах сан дахь усны түвшний хоорондох цаг хугацааны уялдаа холбоог нарийвчлан авч үзсэн байна. Энд бага услагтай нөхцөлд ус өгөлтийн хэлбэлзлийг багасгаж ус хуримтлуулах сангийн баталгаат ус өгөлтийг шаардлагатай зохих түвшинд барих, их услагтай жилүүдэд ус хуримтлуулах боломжийг төлөвлөх шаардлагатай.

Боомтын суулт, шилжилт, шүүрэлт, хагшаасны байдлыг хэмжих багаж, хэрэгслийг суурилуулахаар төлөвлөх бөгөөд цаг уурын болон гидрометрийн хэмжилтийн байнгын харуулууд ажиллуулахаар төлөвлөх хэрэгтэй. Ус авах байгууламжийн хувьд төсөлд тусгагдсан тооцоот зарцуулгыг найдвартай авч байх гол нөхцөлийг тооцохоос гадна, ирээдүйд ус хэрэглээ нэмэгдэж болох нөхцөлийг тооцсон байна.

Төлөвлөж буй хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний зардлын тодорхойлолт, тэдгээрийн хэсэгчилсэн хийцийн жагсаалтыг урьдчилсан байдлаар бэлтгэх ёстой.

3.3.7 Техникийн зураг төсөл

Зөвлөх нь төслийг тодорхойлох байдлаар ТЭЗҮ-ийн түвшинд инженерийн зураг төсөл гүйцэтгэнэ. Энд зураг төслийн шалгуурыг тодорхойлон гаргаж, барилга байгууламжийн төлөвлөлтийн зураг гаргана.

Боомтын янз бүрийн төрөл, боомтын өндөр, ус хуримтлуулах сангийн хүчин чадал болон УЦС-ын үндсэн болон оргил ачааллын үед хамаарах үйл ажиллагааны төрөл, ус хуримтлуулах сан болон урсцын менежмент, байгаль орчны хор хөнөөлийг нь бууруулах, ус хуримтлуулах санд үерийн урсацаас орж ирэх усны эзлэхүүн, боомт барилгын ажил

болон тухайн үе шатанд суурилагдсан хүчин чадал зэргийг агуулсан бие биетэйгээ уялдаа холбоотой зураг төсөл, төлөвлөлтийн зургууд гаргаж хувилбаруудыг тодорхойлно.

Техникийн зураг төслийн үр дүн болон түүнтэй уялдаатай төрөл бүрийн зардал, төсвийн элементийн үр дүнд үндэслэн төлөвлөлтийн зохион байгуулалт, түүний янз бүрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг оновчтой болгоно.

Хээрийн хайгуул судалгаа болон оновчтой хувилбарыг сонгох ажлын үндсэн дээр төслийн тодорхойлолт болон зургийн төслийг бэлтгэсэн байна. Оновчтой хувилбарыг сонгохдоо ус хуримтлуулах сангийн хэмжээ, боомтын өндөр, туршилт боловсруулалтын үе, ус хаях барилгын хэмжээ болон төслийн хүчин чадал болон ус гаргах байгууламж ус авах байгууламжийн хэмжээ төрөл, түрэлтэт туннелийн ба хөндлөн огтлолын талбай, тэнцвэржүүлэх сан, түрэлтэт шахт, хаалтууд, клапан, түрэлтэт хоолой, үндсэн механик (турбины хүчин чадал, турбины тоо) болон цахилгаан тоног төхөөрөмж (генератор, трансформатор), бүрэн түрэлт болон ашигтай түрэлт, усан цахилгаан станцын барилга, ус зайлуулах суваг зэргийг оруулсан байна.

Барилга байгууламжийн зураг төсөл, зургууд нь ус хаях барилга, ус авах барилга, ёроолын ус гаргуур, туннель, түрэлтэт хоолой, барилгын үед голын зарцуулга өнгөрөөх, цахилгаан станц, суурилуулсан хүчин чадал болон генераторын иж бүрдлийн тоо болон хэмжээ, гидравлик, цахилгаан болон механик тоног төхөөрөмж зэрэг боомтын үндсэн бүрэлдэхүүн хэсгүүдийг хамарсан байна.

Алсын зайд ус дамжуулах шугамын барилга байгууламжийн зураг төсөл нь өргөлтийн насос станцын тоо, түүний төрөл хэмжээ, хүчин чадал, ус дамжуулах шугам, усан сан, ус нөөцлөх усан сан, ус гаргалгааны барилга байгууламж (10 км тутамд байх) зэрэг үндсэн хэсгүүдийг хамарсан байна.

Төлөвлөлтийн зураг төсөл нь дараах хэсгийг хамруулах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

- Боомт, ус халиагуур, далангийн шаардлагатай хийцлэл, түүнийг дагасан шороон шаардлагатай ордуудыг төлөвлөх (кран, шлюз хаалт бусад), ус халиагуурын хийц (бьефийн тоо, шлюз хаалтын төрөл, түүний хэмжээ гэх мэт) байнгын ашиглалт хамгаалалт дээр авах арга хэмжээ тусгах, байгалийн эрсдэлүүдээс хамгаалах
- Суваг, хоолойн байгууламж (хамгаалалтын сараалж, шандор, шлюз, лебеда, тунгаагуур бүхий ус авах барилга, ус хуримтлуулах сангаас экологийн урсац гаргалгааны төхөөрөмж, түрэлттэй туннель, чулуу болон элс баригч, тэнцвэржүүлэх сан болон түрэлтэт шахт, клапан, загас хамгаалах байгууламж болон бусад
- Ус зайлуулах суваг (шлюз бүхий тэнцвэржүүлэх төхөөрөмж, зайлуулах туннель, хаалт, кран болон бусад) УЦС-ын машины зал (турбин, тохируулагч, хөргүүрийн агааржуулалтын систем, кран зэрэг механик тоног төхөөрөмж, генератор, трансформатор, сэлгэх залгуур, туслах цахилгаан хангамж, хүчний кабель, хяналтын кабель, холбоо, хамгаалалтын болон хяналтын тоног төхөөрөмж, хуваарилах болон диспетчерийн тоног төхөөрөмж зэрэг цахилгаан тоног төхөөрөмжүүд
- Загас үржүүлэх газар
- Ус дамжуулах хоолойн хувьд:
 - Ус цэвэршүүлэх, халдваргүйжүүлэх байгууламж
 - Өргөлтийн насос станц (төлөвлөлт, байршил, хүчин чадал)
 - Ус гаргалгаа (хүйтний улиралд ажиллах боломжтой)
 - Ус нөөцлөх усан сан

3.3.8 Тогтворжилтын тооцоо, судалгаа

Бүтцийн шинжилгээгээр стандарт болон бусад ачаалалд боомт болон түүний бүтцийн нэгдмэл чанар, бүрэн бүтэн байдлыг тодорхойлох зорилготой юм. Эдгээр ачаалалд ус хуримтлуулах сан, доод хашицад усны хамгийн их түвшинтэй байх, дотоод даралт, суурийн хөрсний шилжилт, овоолгын материал, хагшаас, газар хөдлөлийн зэрэг ачаалал орсон байна.

Авч үзэж байгаа, сонгосон боомтын төрлийн хувьд харгалзах боомтын тогтворжилтын тооцоо, судалгаа хийгдсэн байх ёстой.

Төслийн тайлбар бичиг, дүгнэлт, тооцоо, шинжилгээ, төслийн бүрэлдэхүүн хэсгүүдийн оновчтой болгох зэргийг багтаасан зураг төсөл нь тайланд тусгагдсан байна.

3.4. Ус дамжуулах хоолойн гидравлик тооцоо

Хоолойн гидравлик тооцоог хувилбар тус бүр дээр хийх бөгөөд энэ тооцооны үр дүнгээр өргөлтийн насос станцуудын тоо, хүчин чадал, байрлал зэргийн сонголтын тооцоог хийнэ. Хоолойн диаметр, хэсгийн урт, материалын сонголтыг гидравлик цохилтын тооцоотой уялдуулан хийнэ. Гидравлик цохилтын тооцооны үндсэн дээр цохилтоос хамгаалах хамгийн оновчтой шийдлийг гаргаж, шаардлагатай арга хэмжээнүүд, тоног төхөөрөмжийг тусгасан байна.

Хоолойн материал, голчийн сонголтыг Монгол орны болон хүйтэн бүсийн нөхцлийг тооцсон техник, эдийн засгийн шалгууруудаар сонгосон байна. Өөрөөр хэлбэл төслийн ашиглалтын хугацаанд эдийн засгийн хувьд хамгийн ашигтай хоолойн диаметруудийг сонгоно.

3.4.1 Ус дамжуулах хоолойн материалын сонголт

Хоолойн материалын сонголтыг хоолойн материалын физик үзүүлэлтүүд, зориулалт болон тээвэрлэх, угсрах, ашиглах зэрэг нөхцөлүүдийг авч үзсэний үндсэн дээр сонгоно. Энд орчин үеийн, зэврэлтэнд тэсвэртэй, өндөр даралтыг даах чадвар, гидравлик эсэргүүцэл багатай зэрэг үзүүлэлтүүдийг харгалзан үзэх нь зүйтэй.

Шугам хоолойг байршуулах ухлагын гүн, хэмжээг тооцоохдоо Монгол орны болон хүйтэн бүсийн онцлогийг тооцсон байна. Мөн хоолойн газар шорооны ажлын хэмжээг тооцохоос гадна, шугам хоолойг угсрах, суурилуулах аргачлалыг авч үзсэн байна.

Усыг алсын зайд дамжуулах хоолойн техникийн тодорхойлолт, урьдчилсан техникийн саналын түвшинд хийсэн судалгаа, зураг төслийн шаардлага, тооцоо, төсвийн зардал ба хэрэгжилтийн хуваарийг багтаасан хөрөнгө оруулалтын урьдчилсан төлөвлөлт зэргийг боловсруулна.

Энд хувилбаруудын тойм, сонголт, зураг төслийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлүүд багтана. Мөн төлөвлөж буй хөрөнгө оруулалт, барих ба хүлээлгэн өгөх зардлуудыг урьдчилсан байдлаар бэлтгэнэ.

3.4.2 Өргөлтийн насос станцын шийдэл

Өргөлтийн насос станцуудын байрлал, хүчин чадлын сонголт нь хоолойн нийт хөрөнгө оруулалт, насос станцуудын ашиглалтын зардлуудын харьцуулсан эдийн засгийн ашигтай үзүүлэлтээр тодорхойлогдоно. Сонгосон диаметруудийн хэмжээнд хамгийн сайн гэж үнэлэгдсэн хувилбар дээр өргөлтийн насос станцуудын байршил, хүчин чадлыг нарийвчлан тооцож гаргасан байна.

Насос станцуудад хэрэглэх насосны төрөл, тоо, хүчин чадлыг сонгоно. Үндсэн ажлын насосоос гадна нөөц насосуудыг тусгасан байна.

Өргөлтийн насос станцууд, хоолойн хоорондын ажиллагааны гидравлик нөхцөлийг тогтвортой, найдвартай байлгах үүднээс насос станц бүрийн сорох талд усан сан төлөвлөнө. Уг ус хуримтлуулах сангийн хэмжээг ашиглалтын явцад шугам хоолойд гарч болох осол, түүнийг засварлах хугацаа зэрэг үзүүлэлтээс хамааруулж тооцно. Ус хуримтлуулах сангийн хийц, материалыг хүйтэн бүсийн онцлог, технологийн шаардлагын үүднээс шийднэ.

Найдвартай ажиллагааг хангах үүднээс насос станц тус бүрд ослын үед хэрэглэх дизель станцыг төлөвлөнө.

Насос станцуудын барилгын хэлбэр хэмжээ нь үндсэн тоног төхөөрөмжүүд, туслах бусад төхөөрөмж, тоноглолуудын хэмжээ байрлалаас хамаарах бөгөөд барилгын хийцийг төсөллөхдөө Монгол орны нөхцөлд хамгийн тохиромжтой байх шалгуурыг мөрдлөг болгоно. Насос станц бүр нь ашиглалтын ажилтнуудын ажиллах боломжийг хангасан байх ба хамгаалалтын хашаа, харуул хамгаалалт зэргийн байрыг шийдсэн байна. Насос станцуудын ажиллагаа нь бүрэн автомат горимоор ажиллах бөгөөд шаардлагатай онцгой тохиолдолд гараар ажиллах боломжтой байна.

Энд хувилбаруудын тойм, сонголт, зураг төслийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлүүд багтахаас гадна төлөвлөж буй хөрөнгө оруулалт, барих ба хүлээлгэн өгөх зардлуудыг урьдчилсан байдлаар бэлтгэх ёстой.

3.4.1 Ус цэвэршүүлэх, халдваргүйжүүлэх байгууламж

Хэрлэн гол дээр баригдах ус хуримтлуулах сангаас шугам хоолойгоор усыг хэрэглэгчдэд дамжуулахдаа ундны усны стандартын шаардлагын хэмжээнд хүртэл цэвэршүүлэн, халдваргүйжүүлнэ. Усыг халдваргүйжүүлэх арга, технологид сонголт хийхдээ орчин үед хэрэглэж байгаа дэвшилтэт технологийг авч үзэх шаардлагатай.

Ус цэвэршүүлэх, халдваргүйжүүлэх байгууламжуудын байршил, хүчин чадлын сонголтыг хийхдээ боломжит хувилбаруудыг харьцуулж сонгосон байна.

Энд байршлын хувилбаруудын тойм, технологийн дүгнэлт, зураг төслийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлсүүд багтана.

3.4.2 Ус нөөцлөх усан сан (Хиймэл нуур)

Томоохон ус хэрэглэгчтэй бүс нутагт болон ус дамжуулах гол шугамын төгсгөлд системийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах зориулалтаар ус нөөцлөх усан санг төлөвлөнө. Ус нөөцлөх усан сангийн хийц, хэмжээ, байршил зэргийн хувилбаруудыг гаргана.

3.4.3 Дэд бүтцийн барилга байгууламж

Дэд бүтцийн барилга байгууламжийн хэсэгт автозам, цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам, шилэн кабелийн одоогийн шугамуудын байрлал, цаашдын хэтийн төлөвлөлтийг судалсан байна. Цахилгаан эрчим хүчний одоогийн байдал, хэтийн төлөвийг гаргаж, төлөвлөж буй УЦС-ыг төвийн эрчим хүчний системтэй уялдаатай ажиллах нөхцөлийг үнэлнэ.

Зөвлөх нь жилийн турш тасралтгүй төслийн талбайд нэвтрэх авто замын урьдчилсан зураг төсөл, албан контор, засварын газар, орон сууцны барилга байгууламж, цахилгаан эрчим хүч, амралтын газар болон түр барилга байгууламж, ажилчдын түр суурин, барилгын ажилд хэрэглэх тоног төхөөрөмж, барилгын материалын орд газруудын байршил болон шаардлагуудыг тодорхойлж дэд бүтцийг байгуулах ажлыг төслийн хүрээнд шийдвэрлэнэ.

3.4.4 Гидро-механик болон цахилгаан-механик тоног төхөөрөмжийн зураг төсөл

УЦС-д суурилуулах турбины төрөл, тоо, генераторын хүчин чадлыг оновчтой тооцоолох ёстой. Турбиныг сонгохдоо зардал, үр ашиг, найдвартай байдал, хүртээмж, тээвэрлэх хэрэгсэл зэргийг харгалзан үзнэ.

Турбин нь усыг хангалттай гадагшлуулах зохион байгуулалттай байх ба кавитаци үүсэхээс сэргийлсэн, мөстөлт хөлдөлтөөс хамгаалагдсан, засвар үйлчилгээ явуулах орон зайтай байх ёстой.

Төслийн ерөнхий план зураг, боомтын өндөр, боомтын төрөл болон УЦС-ын суурилуулсан чадал зэргийн сонголтыг хамгийн зохистойгоор тооцон тогтоож турбины тоо, хүчин чадал дээр тулгуурлан шаардлагатай генераторыг судална. Станцын дотоод цахилгаан сүлжээнд холбоход шаардагдах нөөц генераторын хүчин чадлыг мөн тооцно.

Турбин болон генераторыг хооронд нь холбох холболтыг судална. Генераторыг сонгохдоо турбин, генератор болон холбогдох тоног төхөөрөмжийг нийлүүлэгч нь нэг байх нөхцөлийг илүүд үзнэ.

Ус дамжуулах түрэлтийн хоолой болон турбины тоног төхөөрөмжид шаардлагатай үед зогсоох, удирдах хаалтыг судална. Цахилгаан-механик тоног төхөөрөмжийг хамгаалах зорилгоор ус дамжуулах түрэлтийн хоолойн гол хаалт хаагдах хугацааг тодорхойлох ба ус дамжуулах түрэлтийн хоолойн усны гидравлик цохилтыг тооцоолно.

Ус дамжуулах түрэлтийн хоолойн ус авах хэсэг болон ёроолын ус гаргуурыг тодорхойлох ба мөн ус зайлуулах камер тэдгээрийн хаалтуудыг тооцно. Эдгээр хаалтуудын тоо, хэмжээг тодорхойлон хийц бүтээцийн тооцоог хийнэ. Лифтэн хаалт өргөх краны төрөл, тоо хэмжээг тодорхойлно.

Турбин, цахилгаан дамжуулах шугам, УЦС-ын байшин, станцын ажиллагсдын оффис, амралтын байр тэдгээрийн бүрдэл хэсгүүдийн байршлыг тодорхойлно.

УЦС-ын суурилагдсан хүчин чадал, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх хэмжээ, ачааллын коэффициент зэрэг УЦС-ын үндсэн характеристикийг нарийвчилсан ТЭЗҮ-д тодорхойлно.

3.4.5 Төслийн эрчим хүчний хэрэглээ, цахилгаан хангамжийн төлөвлөлт

Төслийн хүрээнд шаардагдах цахилгаан эрчим хүчний хэрэглээг тооцон гаргахад энэ хэсгийн зорилго оршино. Боомт, түүн дээр төлөвлөх бусад гидротехникийн байгууламжийн цахилгаан тоног төхөөрөмжүүдийн тоо, хүчин чадлыг тооцсон байна. Энд мөн гэрэлтүүлэг, халаалт зэрэг ашиглалтын үеийн шаардлагатай бусад цахилгаан хэрэглээг авч үзнэ. Ус дамжуулах системийн хувьд өргөлтийн насос станцууд тус бүр дээр үндсэн тоног төхөөрөмжүүд болон бусад шаардлагатай цахилгаан эрчим хүчний хэрэглээг тооцох юм.

Хэрлэн гол дээрх усан цогцолборын байгууламжууд, түүнд ойр байрлах өргөлтийн насос станцуудын болон УЦС-ын өөрийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг УЦС-ын үйлдвэрлэсэн цахилгаан эрчим хүчээр хангана. Хэрлэн голоос хол байрлах өргөлтийн насос станцуудын цахилгаан эрчим хүчний хэрэглээг тухайн орон нутагт ойр орших эрчим хүчний нэгдсэн сүлжээтэй холбох хувилбаруудыг авч үзнэ. Эрчим хүчний системтэй холбогдох алслалаас хамаарч цахилгаан дамжуулах шугамын хүчин чадлыг сонгохоос

гадна бууруулах трансформаторын дэд станцуудын хүчин чадлыг тооцон төлөвлөсөн байна.

Цахилгаан хэрэглэх объект бүрийн цахилгаан тоног төхөөрөмжүүдийн холболтын схем, удирдлагын болон хүчний самбаруудын байрлалын схем зэргийг зурган байдлаар үзүүлнэ. Энд байршлын хувилбаруудын тойм, технологийн шийдэл, зураг төслийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, төсвийн зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлүүд багтана.

3.4.6 Усан цахилгаан станцын техникийн тодорхойлолт

УЦС-ын хүчин чадлыг уг хөндлүүрт хийсэн усны эрчим хүчний тооцооны үр дүнгээр тооцон гаргана. Энд үйлдвэрлэж болох хамгийн боломжит хүчин чадлыг сонгосон байна.

УЦС-ын турбин генераторын төрөл, хүчин чадал, тоог тооцох бөгөөд хөргөлтийн усны болон шүүрүүлэх систем, даралтат агаарын системийн төлөвлөлт, турбины ашиглалтын нөхцөлүүдийг тооцсон байна. УЦС-ын машины барилгын хийц хэмжээг тооцох бөгөөд бусад туслах тоног төхөөрөмжүүдийг төлөвлөнө. УЦС-ын үндсэн схем, өсгөх дэд станцын схемийн сонголт, үндсэн тоноглолууд, цахилгаан дамжуулах шугамын хүчин чадал, трасс, шугамын хөндлөн огтлол зэрэг техникийн шийдлүүдийг тусгасан байна.

Энд системийн тоног төхөөрөмжүүдийг суурилуулах схем, цахилгааны тоноглолуудын схем, зураг төслийн шаардлага, хөрөнгө оруулалтын урьдчилсан төсөв, урьдчилсан төлөвлөгөө, хэрэгжилтийн хуваарь зэргийг багтаасан байна.

3.4.7 УЦС-аас цахилгаан дамжуулах шугам, ТЭХС-д холбогдох байдал

Төслийн хэмжээнд УЦС-аас үйлдвэрлэн гаргах цахилгаан эрчим хүчийг дамжуулах шугам, түүний хүчин чадал, цахилгаан дамжуулах шугамын байршлын судалгаа хийнэ.

Шинээр барих УЦС-ын ажлын горимыг тодорхойлж, төвийн эрчим хүчний сүлжээтэй холбох, хамтран ажиллах хувилбарыг авч үзнэ. Энд эрчим хүчний системийн горимын тооцоог боломжит хувилбаруудаар тооцож, шинжилгээ хийж дүгнэлт гаргана. Мөн эрчим хүчний системийн статик тогтворжилтын тооцоог хийсэн байна.

3.4.8 Авто замын төлөвлөлт, төлөвлөлтийн норм

- “Авто зам төсөллөх” ЗЗБНБД 22-004-2016
- “Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл” АЗУАГН 2.01.01-2004
- “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНБД 32.02.03
- “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНБД 22.01.01*/2006
- “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88;

Зөвлөх нь төсөлд хамрагдах объектуудын барилтын үеийн болон ашиглалтын замын зураг төслийн шаардлага, төлөвлөлтүүдийг авч үзэж, үнэлэх болно. Хэрлэн гол дээрх боомт, бусад гидротехникийн барилга байгууламжуудыг барих үед шаардлагатай авто замын сүлжээний байрлалыг хувилбаруудыг авч үзэж, төмөр замын ойрын өртөөтэй холбогдох хамгийн боломжит хувилбарыг гаргана. Боомт баригдах талбайд томоохон тээврийн хэрэгсэл, машин механизмууд саадгүй нэвтрэн ажиллах боломжтой барилгын болон ашиглалтын үеийн авто замын төлөвлөлтийг хийнэ. Шаардлагатай газруудад гүүр, үерийн хамгаалалт ус өнгөрөөх байгууламжуудыг төлөвлөнө. Барилгын үеийн авто замыг ашиглалтын үед ашиглах боломжийг тооцох бөгөөд шаардлагатай бол боомтын ашиглалтын авто замыг шинээр төлөвлөнө.

Барилгын ажлын үед шаардлагатай барилгын материалуудыг тээвэрлэх автозамын чигийг тогтоох судалгааг хийнэ. Шаардлагатай бол замын саадтай, хүндрэлтэй нутаг районд барилгын болон ашиглалтын авто зам тавих трасс, байршлын сонголтыг хийнэ.

Ус дамжуулах шугам хоолой, өргөлтийн насос станцуудын барилгын үед шаардлагатай тоног, төхөөрөмж, материалыг тээвэрлэх зориулалттай түр замыг БНБД, байгаль орчны хамгаалах үүднээс тооцож төлөвлөх шаардлагатай. Ус дамжуулах трассын дагууд ашиглалтын үеийн авто зам байх бөгөөд шаардлагатай уул, даваануудыг давах зориулалттай замыг засахаар төлөвлөх хэрэгтэй.

Барилгын болон ашиглалтын үеийн авто замын байршлын хувилбаруудын тойм, зураг төслийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, төсвийн зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлүүдийг тодорхойлсон байна.

3.4.9 Холбоо, мэдээлэл, телеметрийн удирдлага

Төслийн хэмжээнд шаардлагатай холбоо, мэдээллийн систем, автомат удирдлагын системийн төлөвлөлтийг тодорхойлсон байна. Хэрлэн гол дээр байх усан цогцолбор, бүх өргөлтийн насос станцууд нь ашиглалтын төв байранд байрлах диспетчерийн удирдлагын төвтэй харилцаа холбооны системээр байнга холбогдсон байх шаардлагатай. Холбооны ямар системээр холбогдох хувилбаруудыг авч үзэж найдвартай системийн сонголтыг хийсэн байна.

Боомтын байгууламж, өргөлтийн насос станцуудын ажиллагааны хоорондын хамтын ажиллагаа нь автомат горимоор ажиллах бөгөөд ажиллагааны харилцан уялдааг төвд байх диспетчерийн системээр удирдах боломжтой байна. Ус дамжуулах шугамын дагууд автомат удирдлагыг телеметрийн системээр удирдахаар төлөвлөнө. Ус дамжуулах шугамд гарсан гэмтлийг зайнаас тодорхойлох орчин үеийн аргыг авч үзнэ.

Энд байршлын тойм, технологийн сонголт, зураг төслийн шаардлагууд, урьдчилсан төлөвлөгөө, зардал, хэрэгжилтийн хуваарь зэрэг зүйлүүдийг багтаасан байна.

3.4.10 Төслийн ашиглалтын байгууламжууд

Төслийн хүрээнд ашиглалтын байгууллагын удирдлага, ажиллагсдын нийт орон тоог тооцон гаргах бөгөөд тэдний ажиллах орчин, ажиллагсадын амьдрах байрны асуудлыг авч үзнэ.

Төсөлд хамрагдаж байгаа нийт байгууламжийн ашиглалтын захиргаа, диспетчерийн төвийн хаана байж болох оновчтой байршлын сонголтыг хийнэ. Ашиглалтын байгууллагын ажиллах нөхцөлийг хангасан албан байрны төлөвлөлт, түүнд шаардлагатай тавилга, авто машин, механизм, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн төрөл тоог гаргаж, шаардагдах хөрөнгийг тооцох, объект тус бүр дээр ажиллах ажиллагсдын ажлын байрны тодорхойлолтыг гаргана.

Ус хуримтлуулах сан, боомт, бусад гидротехникийн байгууламжийн ашиглалтын үед шаардлагатай аж ахуйн болон ажиллагсдын орон сууц, харуул хамгаалалтын зориулалттай барилга байгууламжуудыг төлөвлөсөн байна. Аялал жуулчлалын зориулалттай шаардлагатай байгууламжуудын төлөвлөлтийг хийнэ.

Барилга байгууламжийн ашиглалтын үед тухайн орон нутгийн оролцоог хэрхэн зохион байгуулах, тухайлбал нутгийн захиргаа, иргэд хөдөлмөрчдөд танилцуулах, орон нутгаас ажиллах хүч авах, тэдэнд сургалт зохион байгуулах арга хэмжээг төлөвлөнө.

3.4.11 Ажлын тоо хэмжээ

Зөвлөх нь төслийн бүрдэл хэсгүүдээр тоног төхөөрөмж, барилга угсралтын ажлын хэмжээг ТЭЗҮ-ийн түвшинд тооцож гаргана. Энэ ажлын тоо хэмжээг зураг төслийн тендерт ашиглах боломжтой байхаар гаргасан байна.

Сонгосон боомтын үндсэн зураг төслийг эцэслэн баталгаажуулах ба зураг төслийг техник эдийн засгийн түвшинд боловсруулан техникийн болон зургийн үзүүлэлтүүдийг бэлтгэнэ. Зураг төсөл, зураглал нь барилгын ажлын бүх хэсгүүдийг (зам харилцаа, газар шороо болон талбай, голдирлын ажил, боомт, станцын болон ажилчдын орон сууцны барилга, өргөлтийн насос станц, дамжуулах шугам хоолой) болон цахилгаан-механик, гидро-механик тоног төхөөрөмжийн (турбин, цахилгаан хөдөлгүүр, шилжүүлэгч, дэд станц, сүлжээний холболт) бүх бүрдлийг багтаасан байна.

Барилгын ажлын үе шат бүрийн хэрэгжилтийн хуваарийг боловсруулан, голын гольдролын байгууламжийн зураг төслийг бэлтгэж тухайн гольдролын байгууламжийн хэмжээсийг тооцоолон өгөгдсөн зураг төслийн үнэлгээг хийнэ.

Ашигласан эх үүсвэр, зураг, тайлбарыг багтаасан ажлын хэмжээний тооцоо гаргана.

3.4.12 Худалдан авалт, ханган нийлүүлэлтийн төлөвлөгөө

Төслийн хэмжээнд барилгын ажил, цахилгаан болон механик тоног төхөөрөмжийн, шугам хоолой ханган нийлүүлэх гэрээний хэмжээгээр худалдан авах ажиллагааны стратеги боловсруулна.

Барилгын ажил, цахилгаан болон механик тоног төхөөрөмж, шугам хоолойн томоохон гэрээнд анхаарал хандуулан техникийн нөхцөлийг харгалзан урьдчилсан үнэлгээ хийгдэнэ. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шаардлагатай үе шат бүрд гаргана. Хангамжийн шалгуур, хувилбарын шинжилгээ, сонгосон хувилбарын үндэслэл, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг харуулсан тусдаа тайлан гаргасан байна.

3.4.13 Боомтын аюулгүй байдлын бодлого

Дэлхийн Банк боомтын аюулгүй байдлыг хянах тогтмол ажиглалт хийх ВР 4.37 бодлогыг баримталдаг. Дэлхийн банкны ОР 4.37 / ВР 4.37-ийн дагуу барилгад хэрэглэх чанарын хяналт шалгалт, баталгаа, үйл ажиллагаа, үйлчилгээ зэрэг арга хэмжээг авах ёстой.

Төслийн барилга байгууламж нь иргэдийн амь нас, эд хөрөнгөнд ямарваа нэг хохирол гарз учруулахгүй байхыг өндөр түвшний мэргэжилтнүүд тогтоож үнэлэх бөгөөд байгаль орчны нөлөөллийн төлөвлөгөөнд тодорхой арга хэмжээнүүдийг тусгана.

3.4.14 Ажлын байрны эрүүл мэнд болон аюулгүй байдлын үнэлгээ

Энэхүү судалгааг хийх гол зорилго нь барилга угсралт, ашиглалтын үед ажиллах түр болон байнгын ажилтнуудын аюулгүй ажиллагаа, эрүүл мэндийг хамгаалж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоход оршиж байгаа юм.

Тиймээс зөвлөх нь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй ажиллагааг хангах цогц механизмыг агуулсан төлөвлөгөөг боловсруулж ирүүлнэ. Уг төлөвлөгөөнд өдөр тутмын аюулгүй ажиллагааны шаардлагыг оруулж, хэн, ямар байгууллага тухайн асуудлыг хариуцах, авах арга хэмжээ, гарах зардал зэргийг тусгана.

3.4.15 Ажил гүйцэтгэх төлөвлөгөө

Эдийн засаг, санхүүгийн дүн шинжилгээ хийхэд бэлэн мөнгөний урсгалыг урьдчилан таамаглахын тулд худалдан авалт дээр үндэслэн төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө, график

гаргана. Барилга байгууламжийн барилгын өмнөх ажлууд, төслийн талбайд хүрэх тээвэрлэлтийн арга, замын маршрут, барилгын материалын ордуудын байршил, барилгын арга зүй, барилгын тоног төхөөрөмж, барилга байгууламж барих, дэд бүтцийн барилга, төслийн талбайд ажил эрхлэх ажиллах хүчний шаардлага, оффисын барилга, экологийн шаардлага, хүн амыг нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа зэргийг ажлын төлөвлөгөө гаргахдаа анхаарч үзнэ. Чухал үйл ажиллагаа болон арга хэмжээний дарааллыг ажил гүйцэтгэх графикт тусгаж үзүүлнэ.

Боомтыг хэд хэдэн үе шаттай барьж байгуулах бол үе шат бүрийн ажил гүйцэтгэх хуваарийг гаргана.

4. Санхүү, эдийн засгийн судалгаа

4.1. Танилцуулга

Энэхүү судалгааны зорилго нь сонгосон хувилбарт эдийн засаг, санхүүгийн нарийвчилсан үнэлгээг хийхэд оршино. Зөвлөх нь:

- Сонгосон хувилбарын эдийн засаг, санхүүгийн асуудлууд тухайлбал усны хэрэгцээний динамик, ус болон эрчим хүчний тарифын бүтэц, эрсдэл, цаг хугацааг нарийвчлан үнэлэх.
- Дотоод, гадаад орчны эдийн засгийн өртгийг тооцоолох (байгаль орчин, нийгэм, улс төр)
- Уг төслийн эдийн засагт үзүүлж буй цэвэр үр ашиг нь Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны эдийн засгийн үнэлгээний шаардлагын дагуу бусад эх үүсвэр ашиглахад дэвшүүлсэн хувилбараас илүү их үр ашигтай байгаа эсэхэд нарийвчилсан үнэлгээ хийнэ.

Хандивлагч байгууллага, хөрөнгө оруулагчид, төрийн захиргаа, хяналтын байгууллага нь тухайн төсөл эдийн засгийн хувьд ямар ашигтай, үр өгөөжтэй байх вэ гэдгийг юуны өмнө ихээхэн сонирхдог. Иймд төслийг эдийн засгийн хувьд хэрэгжих үндэслэлтэй эсэхийг тогтоох зорилгоор эдийн засаг, санхүүгийн тооцоо, шинжилгээ хийнэ.

Санхүү, эдийн засгийн судалгаа нь аливаа шууд илэрхийлэгдэх зардал, үр ашиг зэрэг тоо болон тоогоор үл илэрхийлэгдэх шууд ба шууд бус бүхий л үр дүнг илэрхийлэн харуулдаг, нэлээд өргөн хүрээтэй нарийвчлан харуулсан, бодит судалгаа болдгоороо чухал ач холбогдолтой юм. Иймд зөвлөхийн санхүү, эдийн засгийн судалгаа, шинжилгээнүүд нь нарийвчилсан судалгаа, бодит үр дүнгээрээ тулгуур мэдээлэл бүхий төслийн техник эдийн засгийн үндэслэлийн ач холбогдол бүхий бие даасан бүлэг байх болно.

Зөвлөх нь бүхий л үр дүнг мөнгөн дүнгээр үнэлэн илэрхийлэх шаардлагагүй боловч чухал мэдээлэл болохуйц бүх үр дүнг аль болох тогтоож илрүүлэн, тоогоор илэрхийлэхийг эрмэлзэх хэрэгтэй. Тухайлбал боомт бүхий хиймэл нуур, шугам хоолой, насос станцын судалгаа, хээрийн хайгуул судалгаа, зураг төсөл, барилга угсралтын ажил зэрэг төслийн үйл ажиллагаатай шууд хамааралтай бүхий л ажлуудыг эдийн засаг, санхүүгийн судалгаанд тусгахаас гадна төслийг цогц байдлаар илэрхийлэхийн тулд аялал жуулчлал, хүнс хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт төслөөс гарах үр дүн нь хэрхэн нөлөөлөх, үр ашиг нь ямар байх талаар бүрэлдэхүүн хэсэгт нь оруулах нь зүйтэй. Энэ нь “Хэрлэн гол дээр урсцын тохируулга бүхий ус хуримтлуулах сан байгуулах” төслийн нийгэм, эдийн засаг болон байгаль орчны олон талт мөнгөөр илэрхийлэгдэх үр ашгийн хажуугаар бусад шууд бус олон үр өгөөжтэй болохыг авч үзнэ гэсэн үг юм.

4.2. Төслийн санхүү, эдийн засгийн эрсдэл

Энэ ажлын хүрээнд төслийн бүх оролцогч талуудын оролцоог зохицуулах, төслийн урьдчилан тооцсон хөрөнгө оруулалтын хэмжээ түүний зарцуулалтыг тодорхойлох болон эдийн засгийн санхүүгийн үр ашгийг тодорхойлох зэрэг ажлууд багтана.

Усны барилга байгууламжийн томоохон төслүүд өртгийнхөө үр ашгийн зорилтод хүрэх гээд чадалгүй хүндэрвэл Монгол орны эдийн засагт сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай. Иймд санхүү, эдийн засгийн судалгаагаар төслийн өртөг, график, эдийн засгийн үр ашгийн тооцоог хийж төсөл хэрэгжүүлэх боломжтой эсэх мөн тодорхой үр дүнд хүрч болох эсэхэд баталгаа гаргах ёстой.

Түүнчлэн санхүү, эдийн засгийн судалгааны мэргэжилтэн нь байгалийн нөөцөөр мэргэшсэн, эдийн засаг санхүүгийн томоохон төслүүдийн зураг төсөл болон удирдлагын түвшинд ажиллаж байсан өргөн мэдлэг, туршлагатай байх хэрэгтэй.

4.3. Гол судалгаанууд

Усан хангамжийн төсөл нь нийгмийн шинж чанарыг агуулж байдгаараа бусад төслөөс эрс ялгаатай. Төслийн өртгөө нөхөх боломж, төслөөс авах ашиг, хүртээмжийг зөвхөн эдийн засгийн үүднээс авч үзэж дүгнэх нь усан хангамжийн төслийг өрөөсгөл болгодог. Тиймээс эдийн засаг, нийгэм, санхүүгийн үнэлгээг хамтад нь хийж нийгмийн үнэлгээгээр эцсийн үнэлэмжийг гаргах нь төслийн үр ашиг гэхээс илүүтэй улс орны аюулгүй байдал, хүн амын эрүүл мэнд, үүнээс үүдэлтэй тогтвортой хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд голлох үүрэг гүйцэтгэнэ.

4.3.1. Төслийг хэрэгжүүлэх эсвэл төслийг хэрэгжүүлээгүйн улмаас гарах үр дүн

Төслийг хэрэгжүүлэх, эсвэл хэрэгжүүлээгүйн улмаас гарах үр дүнгийн харьцуулсан судалгаа хийх нь үр өгөөжийг тодорхойлох бас нэг арга байх болно. Төслийн эдийн засгийн үр ашгийн шинжилгээг санхүү эдийн засгийн загвар ашиглан техникийн шийдлийн хувилбар тус бүрээр хийнэ. Эдгээр хувилбарт тухайн усны эх үүсвэрийг өөр зорилгоор ашиглах боломжит хувилбарыг нэмэлтээр сонгож шинжилгээ хийнэ. Энэ нь байгалийг унаган төрхөөр нь хадгалах дэлхий дахины нэг шаардлага бөгөөд тухайн байгалийн нөхцөлийг хэвээр хадгалж, өөр зориулалтаар ашиглах нь төслийг хэрэгжүүлснээс илүү ашиг авчрах боломж байсныг алдсан байх магадлалтай гэж үздэг. Ингэснээр энэ нь нэг талаар ус татах төслийг хэрэгжүүлэх ач холбогдлыг илэрхийлэх, нөгөө талаас төсөл хэрэгжээгүй үеийн үр дүнг харуулна гэсэн үг. Тиймээс голын урсцад тохируулга хийж, усыг дамжуулан ашиглахгүй, нийгмийн сайн сайхны төлөө, аль эсвэл эдийн засгийн бусад салбарт ашиглах тийм хувилбарыг сонгож дүн шинжилгээ өгөх эсвэл хэд хэдэн хувилбарыг авч үзэх нь чухал юм.

“Хэрлэн гол дээр олон зориулалттай усан цогцолбор байгуулах” төслийн гол зорилго нь Монголын томоохон голуудын нэг Хэрлэн гол дээр барих боомт бүхий ус хуримтлуулах сан, усан цахилгаан станц, ус дамжуулах хоолой, ус гаргуур, ус өнгөрүүлэх зэрэг усан цогцолборын байгууламжийн тусламжтайгаар өмнөд Говийн бүсийн өсөн нэмэгдэж байгаа ус хэрэглээний өсөлтийг хангах, Хэрлэн гол түүний орчны экосистемийн тогтвортой байдлыг хадгалахад оршино.

Тиймээс харьцуулсан судалгааг байгаль орчин, нийгэм, эдийн засаг, хүн амын эрүүл мэнд зэрэгт хэрхэн нөлөөлж байгааг тал бүрээс нь судалж техник эдийн засгийн үндэслэлийн нэг хэсэг болгон тусгасан байна. Өөрөөр хэлбэл төслийн хэрэгжүүлэх хугацааг хойшлуулах, эсвэл бүр хэрэгжүүлэхгүй байснаас:

- Говь цөлийн бүс нутгийн болон Хэрлэн голын экосистем, цөлжилт, хуурайшилт хэрхэн өөрчлөгдөх, нэмэгдэх;
- Хүн амын ундны усны хомсдол, чанарын асуудал, үүнтэй холбоотой үүсэн гарах тухайн бүс нутгийн хүн ам зүйн үзүүлэлт болох эрүүл мэнд, өвчлөлт нас баралт хэрхэн өөрчлөгдөх;
- Говийн бүсэд байгуулагдаж байгаа томоохон уул уурхайн үйлдвэрүүдийн хэрэглэж байгаа болон хэрэглэх газар доорх усыг ашиглах байдал, усны үнэ зэргийг тодорхойлж, эдийн засгийн үзүүлэлтүүдээр илэрхийлнэ.

Энд төслийг нөгөө өнцгөөс нь авч үзэн төслийг хэрэгжүүлээгүйн улмаас гарах үр дүн, түүний ирээдүйд учруулах аюул, эрсдэлийг урьдчилан тооцож харуулсан судалгааг гаргана.

4.3.2 Хууль журам, дүрэм, үнэ тарифыг тооцох

Төсөл амжилттай хэрэгжих нь холбогдох олон улсын болон дотоодын хууль, эрх зүйн баримт бичиг, гэрээ, хэлэлцээртэй нийцэж байгаа эсэхээс ихээхэн шалтгаалдаг тул төсөлд шууд холбогдох олон улсын гэрээ хэлэлцээр, дотоодын хууль тогтоомж, бусад эрх зүйн баримт бичгийг улам нарийвчлан судлах шаардлагатай.

Энэхүү хууль, эрх зүйн асуудал сэдвийн хүрээнд төсөл хэрэгжүүлэхтэй холбоотойгоор зайлшгүй авч үзэх шаардлагатай зөвхөн Монгол Улсын нэгдэн орсон хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа олон улсын гэрээ конвенц, хоёр талт гэрээ хэлэлцээр, дотоодын хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, эрх зүйн хөтөлбөр бусад баримт бичгийг авч үзнэ.

Төслийн хууль, эрх зүйн хүрээнд хамаарч болох олон улсын гэрээ, хэлэлцээр, дотоодын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг урьдчилсан байдлаар жагсаалтаар гаргаж судалгааны тайланд хавсаргасан бөгөөд энэхүү жагсаалтыг эцсийн бөгөөд бүх баримт бичгийг багтаасан гэж үзэж болохгүй. Өөрөөр хэлбэл, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах явцад өөр хууль, эрх зүйн баримт бичиг төсөлд хэрэглэгдэх нөхцөл байдал үүсвэл тухай баримт бичгийг мөн харгалзан үзвэл зохино.

Төсөлд холбогдох хууль, эрх зүйн асуудлыг судалснаараа төслийг хэрэгжүүлэх гадаад, дотоодын хууль, эрх зүйн нөлөөлөх хүчин зүйлс, үндэслэлийг үнэн зөв гаргаж ирэх, төслийн хэрэгжилттэй холбоотой олон нийтийн дунд үүссэн зарим нэг ташаа ойлголт, мэдээлэлд хууль зүйн үүднээс нэг мөр хариулт өгөх, төслийн хэрэгжилтэд гадаад, дотоодоос тулгарч болох эрсдэлийг зөв тооцоолох, шийдвэрлэх гарц боловсруулах, болзошгүй эрсдэлд бэлтгэлтэй байхын зэрэгцээ төслийг амжилттай хэрэгжүүлэх хууль, эрх зүйн урьдчилсан нөхцөлийг бүрдүүлэх явдал юм.

Усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг 2012 оны шинэчлэн баталсан “Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай” хууль болон “Усны нөөц ашигласны хувь хэмжээг тогтоож, хөнгөлөх тухай” Засгийн газрын 2013 оны 326, 2022 оны 416 дугаар тогтоолын дагуу тооцно. Санхүү, эдийн засгийн тооцоонд Монгол Улсад мөрдөж байгаа бусад хууль, тогтоомжид заасан норм, төлбөрийн хэмжээг баримтална.

Төслийн ач холбогдол, цар хүрээ нь НҮБ-ын Боловсрол, Шинжлэх ухаан, соёлын байгууллагын ивээл дор хэрэгждэг Хүн ба Байгаль хөтөлбөр, Дэлхийн өвийн тухай конвенцийн хүрээнд олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх боломжтой эсэх талаар судлах, ийнхүү хүлээн зөвшөөрөгдөх боломжтой нь тогтоогдвол хэрхэн хэрэгжүүлэх, төслийн байгаль орчин, нийгмийн олон асуудалд хэрхэн эергээр нөлөөлөх, олон улсын түвшинд төслийн ач холбогдлыг яаж томъёолж гаргах, санхүүжилт татахад ашиглах талаар зөвлөмж гаргана.

4.3.3 Төслөөр бий болох үндсэн байгууламжуудын менежментийн хувилбар

Энэхүү зорилтын зорилго нь төслийн дагуу үүсэх аливаа активыг өмчлөх эрхийн сонголтуудыг судалж, хянаж үзэх явдал юм. Зөвлөх нь өмчлөх эрхийн талаар мөн хэд хэдэн улс нэгдэн активаа өмчлөх менежментийн талаар холбогдох одоогийн болоод шинээр бий болж буй дэлхий нийтийн туршлагаас судалж зөвлөгөө өгнө. Оролцогч талууд, ялангуяа төрийн оролцооны талаар санал зөвлөмж гаргана.

Төслийг Концессын тухай хуулийн дагуу “Барих-ашиглах-шилжүүлэх” концессын төрлөөр төсөл хэрэгжүүлэгч гадаад, дотоодын хуулийн этгээдийн консорциум, олон улсын хандивлагч байгууллага, хөрөнгө оруулагч нарын туслалцаа, оролцоотойгоор хэрэгжүүлэх, төслийн дагуу баригдах усны барилга байгууламж, дамжуулах шугам хоолойн барилга байгууламжийг төсөл хэрэгжүүлэгч ашиглах, арчлах, засварлах хугацааг зохистой тодорхойлох, бусад ус хэрэглэгч, ашиглагчтай хэрхэн харилцах, эрх үүрэг, төрийн болон орон нутгийн өмчид шилжүүлэн авах талаарх санал зөвлөмжийг техник-эдийн засгийн үндэслэлд тусгана.

4.3.4 Төслийн хүрээнд усны хэрэгцээ, усны үнэ тарифыг тооцох

Төсөл хэрэгжүүлэх бүс нутгийн ус хэрэглээний хэтийн төлөвийн тооцоо хийх талаар энэ даалгаврын инженер, техникийн судалгааны хүрээнд тусгасан байгаа. Энэ тооцоог хийхэд байгалийн нөөцийн эдийн засагчийн үүрэг хамаарна.

Ус хэрэглэгч тус бүр өөр өөр зориулалтаар усыг хэрэглэх тул усны үнэ тарифыг ялгавартай байхаар тооцох шаардлагатай юм. Усны тарифыг хэд хэдэн хувилбараар тооцно. Ус хүргэх өөрийн өртгийн үндсэн дээр орон нутгийн хэрэглэгчдийн чадавхад тулгуурлан нийгмийн онцлогийг харгалзан тогтооно. Усны үйлчилгээний тарифын санал боловсруулна. Усны өөрийн өртгийг тооцож, бодит үнийн саналаас зөрүүтэй хэсгийг тодотгон саналд тусгана.

4.3.5 Төслийн нийт өртгийн тооцоо

Монгол Улсад оруулж байгаа хөрөнгө оруулалтын талаар дэлхийн санхүүгийн зах зээл дээрх одоогийн нөхцөл байдлын хүрээнд төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг сонгосон дээр тодорхойлон зэрэглэл тогтооно.

Хөрөнгийн жигнэгдсэн дундаж өртгийн бодит дүнг зах зээлийн ханшинд тулгуурлан төслийг санхүүжүүлэх хувилбарууд болон төслийн бүтцийн хувилбарууд дээр тооцон гаргана. Төслийн хувилбаруудыг тодорхойлж санал болгох санхүүжилтийн хувилбаруудыг тооцож гаргана.

Инженерийн байгууламжуудын хөрөнгө оруулалтыг тооцохоос гадна байгаль, орчин, нийгмийн судалгаагаар шаардлагатай байгаа экологийн болон нийгмийн, санхүүжилтийн зардлуудыг хөрөнгө оруулалтын нийт өртөгт тооцсон байна.

4.3.6 Ашиглалтын зардал ба цэвэр орлого

Төслийн сонгосон хувилбарт санхүү, эдийн засгийн тооцоонд дараах ашиглалтын зардлуудыг тооцох боловч энд дурьдсан зардлуудаар хязгаарлагдахгүй.

- Ашиглалтын зардал,
- Элэгдэл хорогдлын шимтгэлүүд,
- Санхүүжилтийн хүүгийн зардал
- Ажилчдын цалин, шагнал урамшуулал,

- Ажилчдын нөхөн олговор
- Нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл,
- Татварууд,
- Усны нөөц ашигласны төлбөр,
- Газрын хураамж,
- Даатгалын зардлууд,
- Байгаль орчны болон нийгмийн зориулалттай зардлууд,
- Ашиглалтын бусад зардал,
- Нүүлгэн шилжүүлэлтийн зардал

Хувьсах зардлыг ажлын бүрдэл бүрээр нарийвчлан гаргаж дүн шинжилгээнд хамруулна.

Орлогын хэмжээ нь ус борлуулсан орлогоос бүрдэх бөгөөд энэхүү ажлын даалгаврын 4.3.5-д заасан усны ялгавартай тарифын орлогоос бүрдэнэ. Хэрлэн гол дээр баригдах УЦС-ын цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл нь орлогын нэг эх үүсвэр болно.

4.3.7 Шууд ба шууд бус өгөөжийн судалгаа

Төслөөс гарах үр дүн дараах салбарт хэрхэн шууд өгөөж өгөхийг авч үзнэ. Үүнд:

- Хүн амын ус хангамж;
- Мал аж ахуй, газар тариалан;
- Цахилгаан эрчим хүч;
- Аж үйлдвэрийн ус хангамж;
- Ажлын байр бий болгож, хүн амын орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх;
- Аялал жуулчлал;
- Уул уурхайн олборлолт, угаах үйлдвэрийн ус хангамж;
- Улсын болон орон нутгийн эдийн засаг, төсөвт үзүүлэх нөлөө
- Цөлжилтийн эсрэг том өгөөж үзүүлнэ

Төсөл хэрэгжсэнээс үүсэх эдийн засгийн шууд бус ач холбогдлыг үнэлэн тооцох хэрэгтэй. Шууд бус эдийн засгийн ач холбогдолд уул уурхайн үйлдвэрлэлийн тасралтгүй ажиллагаа, түүний нөлөөгөөр нэмэгдэх дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ, трассын дагуу бий болох жижиг дунд үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн өсөлтийг оруулж өгнө.

Сонирхогч талууд болох хөрөнгө оруулагч болон санхүүжүүлэгч байгууллага нь тухайн төслийг шууд бус өгөөжид нь үндэслэн үнэлж байдаг гэдгийг анхаарч хэдийгээр тоон буюу мөнгөн утгаар илэрхийлэгдэх боломжгүй байсан ч төсөлд байж болох бүхий л шууд бус үр өгөөжийг аль болох дэлгэрэнгүй задлан бичиж оруулна. Мөн дээрх талуудын харилцан адилгүй үйл ажиллагаа, сонирхлын онцлогоос хамаарч шууд бус өгөөжийг өөр өөр талаас нь тодорхойлж төслийн үр өгөөжийг олон талаас нь харах боломж олгох нь зүйтэй. Төслийн ТЭЗҮ-д шууд бус өгөөжийг дараах байдлаар хамааруулж авч үзэх. Үүнд:

- Хэрлэн голын болон төсөлд хамаарах бүс нутгийн байгаль орчин, экосистемд үзүүлэх нөлөө;
- Цөлжилт, хуурайшилтыг бууруулах нөлөө;
- Унд ахуйн усны чанар, хэмжээ түүний нөлөө, өөрчлөлт;
- Хүн амын эрүүл мэндэд, хүн ам зүйн үзүүлэлтэд үзүүлэх нөлөө;
- Бүс нутгийн хүн амын соёл, амьдралын чанарт үзүүлэх нөлөө;

- Аялал жуулчлал, суурин хотуудын хөгжил зэрэгт биет бусаар илрэх үр өгөөжийг тусгана.

Зөвлөх нь шууд ба шууд бус өгөөжийн судалгааны үр ашгуудыг нэгтгэн, харьцуулж, салган ашиглах боломжтой байхаар хийсэн байна.

4.3.8 Байгаль орчин, нийгмийн салбарт учирч болзошгүй хохирол

Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээг эдийн засгийн утгаар илэрхийлнэ. Уламжлалт мал аж ахуйгаа эрхлээд олон мянган жил амьдрах нөхцөлийг хэвээр үлдээх ёстой гэсэн зарчмыг баримтлах ба газар доорх усанд нөлөөлж буй нөлөөллийг бүрэн тусгаж, хяналтын цооног, малчдын худаг зэрэгт мониторинг хийж газар доорх усанд нөлөөлж байгаа эсэхийг баталгаажуулна.

Нийгэмд үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөл нь хүн амын хэдэн хувь нь зонхилох аж ахуйг эрхэлж байна, уламжлалт аж ахуй эрхлэх хүн амын тооны өөрчлөлт, улмаар уламжлалт аж ахуй эрхлэх нь эрс багасах тохиолдолд нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг тооцож үзэх, аж ахуй эрхлэх хэв маяг өөрчлөгдсөнөөр нутгийн уугуул иргэдэд ирэх ачаалал, өрхийн орлогын өөрчлөлт, ажилгүйдэл, улмаар шилжин суурьших хөдөлгөөний эрчимжилтийг тооцож үзнэ.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 сарын 08 өдрийн 58 дугаар тогтоол Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний журмын дагуу Байгаль орчны нөлөөлөл байдлын нарийвчилсан үнэлгээг гүйцэтгэх.

4.3.9 Төслийн нийгэм эдийн засгийн судалгаа

Төсөлд хамрагдах бүс нутгийн нийгэм, эдийн засгийн төлөв байдлын ерөнхий дүн шинжилгээ хийж, дүгнэлт өгнө.

Хүн амын өсөлтөд тулгуурласан усны эрэлтийн шинжилгээ хийнэ. Бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийн прогнозад тулгуурлан усны эрэлтийн шинжилгээ хийнэ.

Төсөлд хамрах нутаг дэвсгэрт эрхлэх аж ахуйн ашиг, алдагдлын шинжилгээг хийж, дүгнэлт гаргана. Уул уурхайн үйлдвэрлэл хэдийгээр өгөөж ихтэй, олон талын боломжийг нээх боловч хэмжээтэй, хязгаартай баялаг гэдгийг заавал тооцож, бэлчээрийн мал аж ахуй эрхлэх нөхцөлийг хэвээр хадгалан авч үлдэх нь тогтвортой хөгжлийн хойч үедээ унаган байгалиа хэвээр үлдээх зарчимтай нийцэх юм. Иймээс газар доорх усыг уул уурхайн чиглэлээр ашиглахдаа экологийн хязгаарт нь барьж байх нь бэлчээрийн мал аж ахуйг цаашид олон мянган жил эрхлэх, нутгийн хүн ам нь өөрийн гэсэн аж ахуйтай нутаг усандаа амьдрах боломжийг олгоно гэсэн үг. Өөрөөр хэлбэл нэг хэрэглэгчийн эрх ашиг нөгөө хэрэглэгчийн эрх ашгийг хөндөх ёсгүй.

Төслийн нийгмийн ач холбогдлыг эдийн засгийн үнэлгээгээр илэрхийлнэ. Үүнийг шууд ба шууд бусаар тодорхойлно:

- Хүн амын цэвэр усны хүртээмж нэмэгдэх хувь;
- Ундны усны чанар дээшлэх;
- Ус авах зайны өөрчлөлт;
- Усны тарифын өөрчлөлт;
- Нийгмийн үргүй зардлын бууралт;
- Ажлын байрны тоо;
- Өрхийн орлогын өсөлт;
- Бэлчээрийн ургацын нэмэгдэл;

- Газрын доройтол, цөлжилтийг хязгаарлах;
- Малын зүй бус хорогдлын бууралт;
- Малын хээл хаялтын бууралт зэрэг үзүүлэлтээр илэрхийлнэ.

ДНБ-ний өсөлтийн урьдчилсан таамаглал дэвшүүлж шинжилгээ хийнэ. Энэ нь төсөл хэрэгжээгүй тохиолдолд ДНБ хэд байсан, Сайншанд АҮЦ, Шивээ-Овоо, Замын-Үүд ЭЗЧБ бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлснээр ДНБ өсөх боломжтой бөгөөд усны хүрэлцээнээс үйлдвэрлэл шалтгаалан үйлдвэрлэл зогсох тохиолдолд уг үзүүлэлт ямар түвшинд очихыг харуулах хэрэгтэй. Үүнд:

- Улсын төсөвт
- Аймгийн төсөвт
- Орон нутгийн захиргаанд орох орлого
- Орон нутгийн иргэдийн орлого зэргийг шууд ба шууд бус хэмжигдэхүүнээр тооцоолж тусгана.

4.3.10 Төслийн эрсдэлийг харьцуулах хэлбэрээр үнэлэх

ТЭЗҮ-ийг боловсруулахдаа уг төслийг хэрэгжүүлэхэд гарч болох санхүү, эдийн засгийн эрсдэлүүдийг хувилбаруудаар үзүүлж харьцуулан үнэлнэ. Гарч болох эрсдэлийг урьдчилан тодорхойлохдоо Монгол улсын дэд бүтцийн хөгжлийн түвшин, эдийн засгийн чадавх зэргийг харгалзахын дээр улс төрийн болзошгүй нөхцөл байдлыг үнэлж үзэх шаардлага байж болно.

Дээрх тохиолдож болох санхүү, эдийн засгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хохирлыг арилгах арга хэмжээг тодорхой байхаар оруулж өгнө. Аливаа эрсдэлийн хэмжээг цаг хугацааны алдагдал, үргүй зардал гарах түүнийг нөхөх хүч хөрөнгө, төсөл хэрэгжүүлэх явц удааширснаас үүсэж болох эрсдэлийг тооцно.

Санхүү, эдийн засгийн аливаа эрсдэлийн үнэлгээг байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ, түүнийг бууруулах арга хэмжээтэй нэгтгэн дүгнэж, эрсдэлүүдийг бууруулах арга хэмжээг төлөвлөх нь зүйтэй.

4.3.11 Төслийн үр ашгийн тооцоо

Зөвлөхийн нийт зардал үр ашгийн тооцоог хийхдээ дараах зарчмыг баримтална. Үүнд:

- Дээр дурдсан шууд болон шууд бус үр өгөөжүүдийг оруулсан төслийн хүрээнд шаардлагатай бүхий л зардлыг үндэслэл сайтай, нарийвчлан тооцох;
- Үйл ажиллагаанаас олох орлого, ашиг зэргийг эдийн засаг, санхүүгийн параметрууд, боломжит судалгааны аргачлалыг ашиглан илэрхийлэх;
- Шаардлагатай зураг дүрслэл, диаграм, схемээр баяжуулсан байх ба эдгээр тооцоо, илэрхийллүүд нь сонирхогч талуудын хэрэгцээнд нийцсэн, уншиж ашиглахад ойлгомжтой байх.

Зөвлөх нь уламжлалт арга аргачлалаас гадна өөрийн боловсруулсан шинэ арга аргачлалыг хэрэглэх замаар дараах үзүүлэлтүүдийг заавал тооцсон байна. Үүнд:

- Зураг төсөл, хайгуул судалгаа, барилга угсралтын үйл ажиллагаа, ашиглалтын зардлыг тус бүрд нь тооцоолох;
- Орлого, ашгийн тооцоолол;

Төсөл хэрэгжүүлэх үе шатуудын хөрөнгө оруулалтын үр ашгийг хувилбар тус бүрээр тооцож гаргана.

4.3.12 Санхүү, эдийн засгийн шинжилгээ

Зөвлөх нь санхүү, эдийн засгийн шинжилгээнд:

- Одоогийн үнэ, суурь үнэ, одоогийн цэвэр үнэ цэнэ болон эргэн төлөлтийн үнэлгээ;
- Хөрөнгө, өр төлбөрийн шинжилгээний харьцаа, нөхцөлийн хамт судлах, эргэлтийн хөрөнгийн эргэц;
- Мэдрэмжийн шинжилгээг цахилгааны үнэ, хөрөнгө оруулалтын зардал нэмэгдэх, барилга угсралт хойшлох зэргийг харгалзах;
- Санхүү, улс төрийн эрсдэл, үүнд үнийн бууралт, ханшийн зөрүү, хүүгийн өөрчлөлт, төлбөрийн эрсдэл зэргийг оруулан үр дүнг тодорхойлно.

Мөн шинжилгээнд төслийн өмнө ба төслийн дараа гэсэн харьцуулалтыг хийж, төслөөс үр өгөөж хүртэх боломжтой бүхий л салбарыг эдийн засгийн, санхүүгийн судалгаанд хамруулан судалсан байна.

Тооцоололд санхүүгийн загваруудыг ашиглан мэдээллүүдээ гаргана. Үүнд:

- Борлуулалт,
- Зарагдсан барааны өртөг,
- Цэвэр ашиг,
- Ашиглалтын зардал,
- Хүү болон татварын өмнөх орлого,
- Татварын өмнөх орлого,
- Орлогын татвар,
- Цэвэр орлого,
- Хөрөнгийн зарцуулалт,
- Удаан хугацааны зээлийн хэмжээ,
- Удаан хугацааны зээлийн буцаан төлөлт,
- Байгаль орчны зардал,
- Бэлэн мөнгөний чөлөөт урсгал,
- Хөнгөлөлтийн хувь тооцох,
- Бэлэн мөнгөний урсгалын өнөөгийн үнэ цэнэ,

Зөвлөх нь санхүүгийн төлөвлөгөө гэсэн хэсгийг гаргаж санхүүжилтийн төрөл, эх үүсвэр зэргийг тодорхойлно. Ингэхдээ дараах зүйлийг оруулсан байна. Үүнд:

- Боломжит санхүүжилтийн эх үүсвэр бүрийг тэдний санхүүжүүлэх боломжтой төслийн бүрэлдэхүүн хэсгийн хамтаар тогтоож, сонирхлын түвшинг нь тодорхойлно.
- Боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлон хөрөнгө оруулагч талуудтай төслийн аль хэсэгт, ямар хувилбараар ажиллаж болохыг үнэлнэ.

Эдийн засгийн дүн шинжилгээнд сонгосон хувилбарын хөрөнгө оруулалтын дотоод өгөөж, өнөөгийн цэвэр үнэ цэнийг тооцно.

Төслийн эдийн засгийн ач холбогдлын үндэслэлийг эдийн засгийн үр ашгаар бус нийгэм, эдийн засаг, экологийн ач холбогдлыг үнэлсэн үнэлгээний нийлбэрээр төслийн нийт эдийн засгийн ач холбогдлыг тодорхойлно.

С. ЗӨВЛӨХИЙН ХҮЛЭЭЛГЭЖ ӨГӨХ ЗҮЙЛС

5. Ажлын үр дүн

5.1 Танилцуулга

ТЭЗҮ, техникийн зураг болон БОНҮ нь нэгэн зэрэг эхлэх бөгөөд тус тусдаа гэрээгээр гүйцэтгэгдэнэ. Төслийн концепцийн хэрэгжих үндэслэлийг гаргахад чиглэсэн инженер техникийн, санхүү, эдийн засаг, хууль, байгууллагын бүтэц зохион байгуулалтын үүднээс хийгдэх судалгаануудыг хамарсан ТЭЗҮ-ийн судалгаа юм. Нөгөө нь санал болгож буй төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллүүдийг хэлэлцэж, шийдвэрлэхэд чиглэсэн БОНҮ-г иж бүрнээр хийнэ. Энэ хоёр үйл ажиллагаанаас гарсан үр дүн нь санал болгож буй төсөл хэрэгжих эсэх талаар шийдвэр гаргах үндэс болно.

5.2 Боловсруулах материалууд

ТЭЗҮ-ийн судалгааны тайлангуудыг багцлан энэхүү бүлэгт танилцуулж байна.

Монгол Улсад мөрдөж байгаа “Барилгын тухай” хууль, Засгийн газрын 2019 оны 108-р тогтоолоор баталсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, магадлал хийх, дүрэм”-д зааснаар ТЭЗҮ-ийг БХБЯ-ны Барилгын хөгжлийн төвийн магадлалаар, БОАЖЯ-ны усны нөөцийн зөвлөлийн хурлаар оруулж хянуулж баталгаажуулсан байна.

5.2.1 ТЭЗҮ-ийн тайлан

ТЭЗҮ-ийн судалгааны эхлэлийн тайлан: Өмнөх шатны ТЭЗҮС-ны болон бусад судалгаануудын үр дүнг ТЭЗҮ-ийн эцсийн шатны баримт, мэдээлэл дээр үндэслэн шинэчлэх ажлын төлөвлөгөөг тусгасан товч тайланг захиалагчийн ТХН-д хүлээлгэн өгнө.

Эцсийн ТЭЗҮ-ийн тайлангийн төсөл: Энэ шатанд гүйцэтгэсэн техник, байгаль орчин, нийгэм, эдийн засаг, санхүүгийн судалгааны үр дүнг тусган ТХН-нд танилцуулж, хянуулна.

Гүйцэтгэлийн товчоон: Санал болгож буй төслийн хамрах хүрээ, зорилгуудыг тодорхой танилцуулан, түүнийг техникийн, байгаль орчны болон нийгмийн талаас өнөөгийн нөхцөл байдалд хэрэгжих үндэслэлтэй эсэхийг үнэлж, төр, олон нийттэй ажилласан харилцаа холбоо, түүнээс гарсан үр дүнг харуулж, өртгийг тооцож, томоохон эх үүсвэрүүд болон санхүүжүүлэх механизмыг тодорхойлно. Гүйцэтгэлийн товчоо нь бичгэн хэлбэртэй байхаас гадна хүснэгт, зураг, диаграмм болон зураглалыг шаардагдах хэмжээгээр нь оруулсан байна.

ТЭЗҮ-ийн эцсийн тайлан: Эцсийн тайлан нь бүх хийсэн ажлууд, дүн шинжилгээ, хувилбаруудыг сонгосон үндэслэл, санал болгож буй зүйлсийг нарийвчлалтайгаар харуулна. Энэ тайланг хийхдээ өмнө хийгдсэн тайлангуудад үндэслэсэн байх ба ТХН-ийн хяналтын уулзалтууд дээр хөндөгдсөн болон хэлэлцсэн асуудлууд, бичгээр өгсөн саналуудыг тусгасан байна.

Тайланг ТХН-д хүлээлгэн өгч олон нийтэд зориулан төслийн цахим хуудсанд хэвлэх бололцоотой маягтаар оруулна. Үүнээс гадна үндсэн цаасан хувь болон электрон хувийг дахин хэвлэхэд зориулан ТХН-д хүлээлгэн өгнө.

5.2.2 Санхүү эдийн засгийн үнэлгээ

Тайлангийн төсөл: Эцсийн тайлангийн төсөл нь цуглуулсан баримт мэдээллүүдийн нэгтгэл, судалсан зүйлүүд, хийсэн дүгнэлт, санал болгож буй үйл ажиллагаануудад төвлөрөх ба тэдгээр баримт мэдээллүүдийг хөрвүүлэхдээ мэдээллийн эх сурвалжийг заана. Баримт мэдээлэл, дүн шинжилгээний нэгтгэлийг хүснэгт, зураглал, графикийг өргөнөөр ашиглан гаргана. Бэлэн хэвлэгдэн гараагүй баримт бичгүүдийг хавсралтад оруулна. Тайланг ТХН-д хүлээлгэн өгөх ба олон нийтэд зориулж төслийн веб хуудсанд байрлуулан, хэвлэх бололцоотой маягтаар оруулна.

ТХН нь хяналтын уулзалтыг зохион байгуулна. Санхүү, эдийн засгийн судалгааны үндсэн хэсэгт томоохон засвар орох, эсвэл дахин хийх бол бүрэн дүүрэн гүйцэтгэж Төслийн удирдах нэгжид хүлээлгэн өгнө. Тайланд хийсэн засварыг ТХН нь хүлээн авч бичгээр баталсан тохиолдолд зөвлөх нь судалгааны тайланг эцсийн байдлаар хүлээлгэн өгнө.

Гүйцэтгэлийн товчоон: Санал болгож буй төслийн хамрах хүрээ, зорилгуудыг тодорхой танилцуулан, түүнийг техникийн, байгаль орчны болон нийгмийн талаас өнөөгийн нөхцөл байдалд хэрэгжих үндэслэлтэй эсэхийг үнэлж, төр, олон нийттэй ажилласан харилцаа холбоо, түүнээс гарсан үр дүнг харуулж, өртгийг тооцож, томоохон эх үүсвэрүүд болон санхүүжүүлэх механизмыг тодорхойлно. Гүйцэтгэлийн товчоо нь бичгэн хэлбэртэй байхаас гадна хүснэгт, зураг, диаграм болон зураглалыг шаардагдах хэмжээгээр нь оруулсан байна.

Санхүү, эдийн засгийн судалгааны эцсийн тайлан: Санхүү, эдийн засгийн судалгааг эцсийн байдлаар хуваарийн дагуу гаргана. Эцсийн тайлан нь бүх хийсэн ажлууд, дүн шинжилгээ, хувилбаруудыг сонгосон үндэслэл, санал болгож буй зүйлсийг нарийвчлалтайгаар харуулна. Энэ тайланг хийхдээ өмнө хийгдсэн тайлангуудад үндэслэсэн байх ба ТХН-ийн хяналтын уулзалтууд дээр хөндөгдсөн болон хэлэлцсэн асуудлууд, бичгээр өгсөн саналуудыг тусгасан байна.

6. ТЭЗҮ-ийн менежмент

6.1. Үүрэг, хариуцлага

Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үүрэг хариуцлага: Төсөл хэрэгжүүлэх нэгж нь ТЭЗҮ-г хийх ажлыг хянах, менежментээр хангах үүрэгтэй. Ажлын даалгаврын дагуу зөвлөхийн ажлын биелэлтэд хяналт тавьж, үе шатны ажлын тайлангуудыг хүлээн авч холбогдох байгууллагуудаар хянуулж, зөвшөөрүүлэх ажлыг зохион байгуулж ажиллана. Төсөл хэрэгжүүлэх нэгж нь зөвлөхүүдийн үйл ажиллагааг тогтмол хянах ба тэдний судалгааны ажлын явцын талаар захиалагчид тайлагнана.

Захиалагчийн үүрэг хариуцлага: Энэ төслийн хувьд захиалагч нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар байна. Захиалагч нь Төсөл хэрэгжүүлэх нэгжээр дамжуулан хяналтыг явуулж, үе шатны ажлын тайланг хэлэлцэж, шаардлагатай зөвшөөрлүүдийг өгөх үүрэгтэй ажиллана.

Зөвлөхийн үүрэг хариуцлага: ТЭЗҮ-г бэлтгэхдээ үр дүнтэй, цаг хугацаанд нь хийхийн тулд зөвлөхүүд үйл ажиллагаагаа бүрэн дүүрэн зохицуулж, нээлттэй нэгдсэн удирдлагаар ажлаа зохицуулж ажиллана. Зөвлөхийн ажлыг хоорондын уялдаатай явуулж, зөвлөхийн удирдлага, гол мэргэжилтнүүд, судалгааны мэргэжилтнүүд нь тогтмол хугацаанд уулзаж баримт мэдээллийг албан ёсоор солилцож байна. Мөн Төслийн удирдах нэгж, захиалагчид ажил гүйцэтгэх графикайн дагуу ажлаа танилцуулж, тайланг хүлээлгэн өгч хэлэлцүүлэн, санал зөвлөмжийг тусган зөвшөөрүүлж, баталгаажуулж ажиллана.

6.2. Зөвлөхийн ажлын хуваарь

Зөвлөхүүдийн ажлыг захиалагч Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар төсөл хэрэгжүүлэх нэгжээр дамжуулж хянах бөгөөд Засгийн газрын бусад яамд, агентлагууд болон бусад олон улсын байгууллагуудтай харьцаж ажиллахад зохицуулалтыг хийнэ. Мөн түүнчлэн шинжлэх ухаан, шинжилгээ судалгааны хүрээлэнгүүд, иргэний нийгмийн байгууллагууд, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллахад зохицуулалт хийнэ.

Хүснэгт 6.1-6.3-т тайлангуудын тодорхойлолт тэдгээрийн үргэлжлэх хугацааг харуулсан. ТЭЗҮ болон БОНБНҮ хийх зөвлөх багууд нь гэрээ байгуулж баталгаажуулснаар ажлаа эхэлнэ. Зөвлөх багууд нь нарийвчилсан ажлын төлөвлөгөөгөө танилцуулах ба гадаад үнэлгээнүүд болон ТХН-ээр зөвшөөрөгдсөн шийдвэрлэх төслийн хугацааг хуваарилсан байх ёстой.

Зөвлөх нь төслийн бүх хугацаанд сар тутамд тайланг бичгээр тавьж байх ба энэ нь захиалагчид аливаа асуудлыг ерөнхий зорилтын хажуугаар аливаа гэнэтийн асуудал гаргуулахгүй буюу гарсан ч тухай бүрд нь анхаарлаа хандуулж шийдвэрлэхэд тус дөхөмтэй байх болно. Зөвлөхийн эхлэлийн тайлан, сар бүрийн явцын тайлан болон аливаа илтгэл нь англи, монгол хэл дээр бичигдсэн байх ба эхлэлийн тайлан нь ажлын төлөвлөгөө, графикайг гаргаж, тайлангийн утга, гарчгийг тодорхой бичсэн байна.

Ерөнхий болон явцын тайлан түүний хувилбарууд нь мөн англи, монгол хэл дээр бичнэ. Тайлангийн эцсийн төслийг монгол, англи хэл дээр хэвлүүлж захиалагч Усны газар болон Эрдэс Оюу Толгой ХХК, УУХҮЯ, БОАЖЯ, ЭХЯ, аймаг орон нутаг, олон нийтийн төлөөлөгчид танилцуулж саналыг нь авсан байна.

Хүснэгт 6.1: ТЭЗҮ судалгааны ажлын үе шатуудын төлөвлөгөө

д/д	Зорилт	Сар
1	Эхлэлийн тайлан болон ТЭЗҮ-ийн нарийвчилсан ажлын хөтөлбөр хүлээлгэн өгөх	1
2	Судалгаануудыг хянаж багцлаад үнэлэх	2

3	1-р үе шатны ажлын тайлан хүлээлгэн өгөх	2
4	2-р үе шатны ажлын тайлангийн төслийг хүлээлгэн өгөх	2
5	Захиалагч, ТХН-д хянуулж, санал авах	1.5
6	ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгааны төслийг гардуулах	3
7	Экспертизийн магадлал хийлгэх	2
8	ТХН-ээс санал авч, захиалагчаар батлуулах	2
9	Эцсийн ТЭЗҮ-ийн урьдчилсан судалгааны тайлан хүлээлгэн өгөх	5

Хүснэгт 6.2: Санхүү, эдийн засгийн судалгааны ажлын үе шатуудын төлөвлөгөө

д/д	Ажил	Сар
1	Эхлэлийн тайланг хүлээлгэж өгөх	2
2	Судалгааны семинарт оролцох	1
3	Төр, олон нийттэй зөвшилцөх, харилцах хөтөлбөрийг бусад зөвлөхтэй хамтран гаргах	1.5
4	Санхүү, эдийн засгийн судалгааны агуулгыг тайлбарын хамт хүлээлгэж өгөх	2
5	1-р үе шатны ажлын үр дүн тайланг гардуулах	3
6	Эдийн засаг, санхүүгийн судалгааны тайлангийн төслийг хүлээлгэн өгөх	6
7	Захиалагч, ТХН-д хянуулж, санал авах	2
8	Тайланг эцсийн байдлаар хүлээлгэн өгөх	8
9	ТХН-ээс санал авч, захиалагчаар батлуулах	2
10	Санхүү, эдийн засгийн судалгааг эцэслэн гаргах	10

Хүснэгт 6.3: Эцсийн ТЭЗҮ боловсруулах судалгааны төлөвлөгөө

д.д	Зорилт	Сар
1	Эцсийн ТЭЗҮ боловсруулах ажлын төлөвлөгөөг танилцуулах	0.5
2	Ажлын биелэлтийг нэгтгэн хянаж, үнэлгээ өгөх	1
3	Нэгдүгээр шатны ажлын тайланг танилцуулах	0.5
4	Хоёрдугаар шатны ажлын тайланг танилцуулах	0.5
5	Захиалагч болон ТХН-ээр хянуулж, санал авах	1
6	Эцсийн тайлангийн төслийг танилцуулах	2
7	Экспертизээр батлуулах	0.5
8	ТХН-ээс санал авч оруулан захиалагчаар батлуулах	0.5
9	Эцсийн ТЭЗҮ-ийн тайлан болон урьдчилсан зураг төслийг танилцуулах	5

Дээр дурдсан тайлангуудыг бэлтгэж гаргах цаг хугацааны хуваарийн дагуу ажлаа гүйцэтгэнэ. Зөвлөх нь гэрээг баталгаажуулснаар ажлаа эхэлнэ.

6.3. Мэдээлэл, баримт мэдээлэл болон баримт бичгийн эзэмшил болон хяналт

Зөвлөхөд гаргаж өгсөн мэдээлэл, баримт мэдээлэл, оюуны өмч, эзэмшил, лиценз болон тэдгээрийн хэрэглээ нь зөвхөн энэхүү судалгаа, үнэлгээнд хэрэглэгдэнэ. Зөвлөхүүдийн боловсруулсан баримт бичгүүд болон мэдээ мэдээллийг ТХН-ийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад задлах эрхгүй.

7. Зөвлөх багийн шаардлага

Зөвлөх баг нь олон улсын хэмжээнд ижил төстэй төсөл хэрэгжүүлсэн туршлагатай зөвлөх компани болон тэдний түншлэл байна. Ажил гүйцэтгэхээр шалгарсан олон улсын зөвлөх баг нь энэ төсөл дээр ажиллаж байсан туршлагатай Монгол Улсын мэргэжлийн байгууллага, зөвлөхүүдтэй хамтарч ажиллана.

Зөвлөх нь төслийн багт тухайлсан албан тушаалын үүрэг гүйцэтгэх мэргэжилтний нэр, ажлын туршлага чадварыг харуулсан тодорхойлолтыг бэлтгэнэ. Зөвлөх нь судалгааны багийн төслийн удирдагч, төслийн дэд удирдагч нарыг нэрлэхээс гадна багийн гол үндсэн гишүүд болон богино хугацаанд онцгой мэргэжлийн шаардлагаар ажиллах мэргэжилтнүүдийн нэрийг мөн оруулна.

Төслийг хэрэгжүүлэхээр санал болгож байгаа хугацаанд нэр заасан бүх мэргэжилтнүүд ажиллах боломжтойг баталгаажуулна.

Хүснэгт 7.1: ТЭЗҮ боловсруулах зөвлөх багийн голлох мэргэжилтнүүдийн оролцоо

Голлох мэргэжилтнүүд			
Гадаад	Хүн-Сар	Дотоод	Хүн-Сар
Багийн ахлагч	18	Багийн ахлагчийн орлогч	18
Санхүү, эдийн засгийн судалгааны багийн ахлагч	6	Санхүү, эдийн засгийн судалгааны багийн ахлагчийн орлогч	6
Инженер, техникийн судалгааны багийн ахлагч	6	Инженер, техникийн судалгааны багийн ахлагчийн орлогч	12
Байгалийн баялгийн эдийн засагч	4	Байгалийн баялгийн эдийн засагч	3
Санхүүгийн мэргэжилтэн	2	Санхүүгийн мэргэжилтэн	3
Хуулийн мэргэжилтэн	1	Хуулийн мэргэжилтэн	6
Гидрогеологийн инженер	2	Гидрогеологийн инженер	18
Гидрологич	3	Гидрологич	18
Гидравлик инженер	3	Инженер-гидротехникч	18
Ус хангамж, шугам сүлжээний инженер	3	Ус хангамж, шугам сүлжээний инженер	8
Усан сан төлөвлөлтийн инженер	3	Усан сангийн инженер	6
Боомтын зураг төслийн инженер	3	Геодезийн инженер	4
Геологич	4	Геологич	4
		Загас судлаач	3
		Хөрс судлаач	3
		Барилгын инженер	6
		Замын инженер	4
		Механик, шугамын инженер	4
		Цахилгааны инженер	6
		Автоматикын инженер	6
		Газарзүйн мэдээллийн системийн мэргэжилтэн	3
		CAD-ын оператор	18
Бүгд			

Техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх багийн мэргэжилтнүүдийн хамгийн наад захын шалгуур үзүүлэлтүүдийг доор тодорхойлов. Үүнд:

Багийн ахлагч

- Төслийн удирдагч нь тухайн салбарт 20-иос доошгүй жил, хөгжиж байгаа оронд 10-аас доошгүй жил усны инженеринг, байгалийн нөөцийн менежмент, стратегийн нөөцийн менежмент, төлөвлөлтийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж ТЭЗҮ-ийн төслийг удирдаж байсан туршлагатай байх,
- Холбогдох талуудыг оролцуулсан олон чиглэлийн төслийн үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах чадвартай нь хүлээн зөвшөөрөгдсөн байх,
- Ижил төстэй төслүүдэд ажиллаж байсан болон Засгийн газар, иргэний нийгэм, олон нийттэй ажилласан туршлагатай байх,
- Төслийн ажилтнуудад зөвлөгөө өгөх чадвартай байх,
- Төсөлтэй холбоотой санхүү, эдийн засаг, усны инженеринг, техник, технологи, байгаль орчин, нийгэм, байгууллагуудын хөгжлийн талаар өргөн мэдлэг, мэдээлэлтэй, түүнийг амьдрал дээр хэрэгжүүлсэн туршлагатай байх,
- Мэргэжлээрээ мастер болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх,
- Зохион байгуулах болон цагийн ачаалал даан ажиллах чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг байх.

Санхүү, эдийн засгийн судалгааны багийн ахлагч

- Багийн ахлагч нь 10-аас доошгүй жил санхүү, эдийн засаг, байгалийн нөөцийн эдийн засаг, менежментийн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай байх,
- Дээрх чиглэлээр томоохон төслүүд дээр хөгжиж байгаа орнуудад ажиллаж байсан туршлагатай байх, Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төслүүд дээр удирдан болон оролцон ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Томоохон хөрөнгө оруулалтын болон менежментийн төсөлд (Хөрөнгө оруулалтын хэмжээ 1 тэрбум америк доллароос дээш) томоохон компаниудад ажиллаж байсан туршлагатай байх,
- Ижил төстэй төсөлд болон Засгийн газар, иргэний нийгэм, олон нийттэй ажилласан туршлагатай байх,
- Янз бүрийн холбогдох талуудыг оролцуулсан олон чиглэлийн төслийн үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах чадвартай нь батлагдсан байх,
- Төслийн ажилтнуудад зөвлөгөө өгөх чадвартай байх,
- Санхүү, эдийн засгийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Зохион байгуулах, түргэн хугацаанд даалгаврыг биелүүлэх болон цагийн ачаалал даан ажиллах чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Хувийн болон багаар ажиллах үр чадвар сайтай, байх
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг байх.

Инженер техникийн судалгааны багийн ахлагч

- Багийн ахлагч нь 10-аас доошгүй жил усны инженеринг, томоохон боомтын төлөвлөлт, ус дамжуулах хоолойн чиглэлээр төсөл хөтөлбөр хэрэгжүүлж байсан туршлагатай байх, Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төслүүд дээр удирдан болон оролцон ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.

- Дээрх чиглэлээр хөгжиж байгаа орнуудад ажиллаж байсан туршлагатай байх,
- Томоохон төсөлд удирдлагын болон голлох албан тушаалд ажиллаж байсан туршлагатай байх,
- Ижил төстэй төсөлд болон Засгийн газар, иргэний нийгэм, олон нийттэй ажилласан туршлагатай байх,
- Янз бүрийн холбогдох талуудыг оролцуулсан олон чиглэлийн төслийн үйл ажиллагааг үр дүнтэй зохицуулах чадвартай нь батлагдсан байх,
- Төслийн ажилтнуудад зөвлөгөө өгөх чадвартай байх,
- Усны инженерингийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх
- Зохион байгуулах, түргэн хугацаанд даалгаврыг биелүүлэх болон цагийн ачаалал даан ажиллах чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Хувийн болон багаар ажиллах ур чадвар сайтай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг байх

Санхүүгийн мэргэжилтэн

- Тухайн салбарт 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, Олон улсын хэмжээнд, хөгжиж байгаа оронд болон Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төслүүдэд оролцон ажиллаж байсан туршлагатай байх,
- Байгалийн нөөц болон дэд бүтцийн хөгжлийн төслийн хөрөнгө оруулалтын санхүүгийн дүн шинжилгээг тооцоолж үнэлэх чадвартай байх,
- Олон улсын стандартаар хөгжиж буй орнуудад Дэлхийн Банк, Олон улсын санхүүгийн корпорац зэрэг байгууллагаас хэрэгжүүлсэн төслүүдэд санхүүгийн дүн шинжилгээ хийж ажилласан туршлагатай байх,
- Хувилбаруудыг харьцуулан дүгнэж шинжлэх чадвартай байх,
- Төслийн ажилтнуудад зөвлөгөө өгөх чадвартай байх,
- Санхүүгийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Хувийн болон багаар ажиллах ур чадвар сайтай байх,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын болон санхүүгийн хэрэглээний программууд дээр сайн ажилладаг байх.

Хуульч

- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Хөгжиж буй орны байгалийн нөөцийн менежментийн талаар хууль эрх зүйн шаардлагатай орчныг бий болгох төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Хөгжиж буй орнуудын байгалийн нөөцийн менежментийн бодлого, хууль эрх зүйн орчны талаар олон улсын байгууллагуудын төслийн заавар, шаардлага журмын дагуу ажиллаж байсан туршлагатай байх,
- Өргөн хүрээний сонирхлын бүлгүүд бүхий хөгжиж буй орны нөхцөл байдалд ажиллаж байсан туршлагатай байх,
- Хуулийн чиглэлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх
- Англи болон монгол хэлний ярианы болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг байх

Боомт болон ус хуримтлуулах сангийн төлөвлөлтийн инженер

- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Усны дэд бүтцийн томоохон төслүүд дээр ажиллан төлөвлөлт үнэлгээ гаргаж байсан туршлагатай байх, Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Олон улсын стандартаар хөгжиж буй орнуудад Дэлхийн Банк, Олон улсын санхүүгийн корпорац зэргээс хэрэгжүүлсэн төслүүдэд боомт усан сангийн чиглэлээр ажилласан туршлагатай байх,
- Инженерийн тооцоо, аргачлалын сонголтуудыг хийх чадвартай байх,
- Хүйтэн бүсийн орнуудад хэрэгжүүлсэн төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Усны барилгын инженерийн мэргэжилтэй байх,
- Гидрологи, гол мөрөн, усны нөөцийн менежмент усны дэд бүтэц болон цаг уурын өөрчлөлтийн байгаль орчны сөрөг нөлөө болон түүнийг бууруулах арга хэмжээг үнэлэх чиглэлээр ажлын арвин туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг.

Усны барилга байгууламжийн инженер

- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Усны дэд бүтцийн төслүүд дээр ажилласан туршлагатай байх,
- Монгол Улсад буюу хүйтэн бүсэд хэрэгжсэн төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байна.
- Усны барилгын инженерийн мэргэжилтэй, магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Усны төрөл бүрийн барилгын гидравлик тооцоо, гидравлик загварын туршилт, хийцийн загварын туршилт дээр ажиллаж байсан ажлын арвин туршлагатай байх,
- Инженерийн тооцоо, аргачлалын сонголтыг хийх чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг.

Ус дамжуулах хоолойн болон усан сан төлөвлөлтийн инженер

- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Ус дамжуулах хоолойн ижил төстэй томоохон төслүүд дээр ажиллаж байсан туршлагатай байх, Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Усны барилга байгууламжийн эсвэл ус хангамжийн инженерийн мэргэжилтэй, магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх
- Ус дамжуулах хоолойн төлөвлөлт, насос станц болон бусад барилга байгууламжийн төслийн төлөвлөлтийн ажлын арвин туршлагатай байх,
- Хүйтэн бүсийн орнуудад хэрэгжүүлсэн төсөл дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Инженерийн тооцоо, аргачлалын сонголтыг хийх чадвартай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг.

Гидрологич

- Гидрологич, ус зүйч мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй, Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай байна.
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг.

Гидрогеологич инженер

- Гидрогеологич мэргэжилээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх,
- Хуурай бүс нутаг, Монгол Улсад эсвэл ижил төстэй бүс нутагт газар доорх усны хайгуул судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх, Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг.

Загас судлаач

- Ихтиологич мэргэжлээр магистр ба түүнээс дээш зэрэгтэй байх
- Мэргэжлийн чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх,
- Монгол Улсад хэрэгжсэн ижил төстэй төсөл дээр оролцон ажиллаж байсан туршлагатай бол давуу тал болно.
- Ижил төстэй бүс нутагт биологийн төрөл зүйлийн судалгаа, усны амьтад, загасны судалгааны ажлын арвин туршлагатай байх,
- Усан санд загас үржүүлэх ажлын төлөвлөлтийн туршлагатай байх,
- Мэдээллийг боловсруулах мэргэжлийн өндөр ур чадвартай, тооцооллын загварчлал дээр ажиллаж байсан туршлагатай байх,
- Төслийн ажлын үр дүнг дээшлүүлэх талаар идэвх санаачилга сайтай ажиллах,
- Англи хэлний аман болон бичгийн өндөр чадвартай байх,
- Компьютерын хэрэглээний бүх төрлийн программууд дээр сайн ажилладаг.

Геологийн инженер

- Мэргэжилтэн нь Геологийн инженер байна
- Геологийн ухааны магистр буюу түүнээс дээш зэрэгтэй байна. Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай
- Хуурай бүс, Монгол Улс эсвэл ижил төстэй бүс нутагт хэрэгжиж байсан гидравликийн төслийн геологийн хайгуул, судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Мэргэжлийн ур чадвар хөгжүүлэх мэдлэгтэй, тооцооны загварчлал боловсруулж байсан туршлагатай

- Төслийн үйл ажиллагааг үр ашигтай байлгахад чиглэсэн туршлагауудыг хэрэгжүүлэх ур чадвартай
- Англи хэлний өндөр мэдлэгтэй, Компьютерын бүх хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн байна.

Геодезийн инженер

- Геодезийн магистр буюу түүнээс дээш зэрэгтэй;
- Хуурай бүс, Монгол Улс эсвэл ижил төстэй бүс нутагт хэрэгжиж байсан гидравликийн төслийн геодезийн хайгуул, судалгааны чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх
- Мэдээ боловсруулах, тооцооны загварчлал боловсруулж байсан туршлагатай,
- Төслийн үйл ажиллагааг үр ашигтай байлгахад чиглэсэн туршлагауудыг хэрэгжүүлэх ур чадвартай, хийх гэж буй ажлаа ач холбогдлоор нь эрэмбэлэн гүйцэтгэх ур чадвартай байна.
- Англи хэлний өндөр мэдлэгтэй, Компьютерын бүх хэрэглээний программуудыг бүрэн эзэмшсэн байна.

Зөвлөх нь өөрийн ажлын багийн бүрэлдэхүүнийг өөр хэлбэрээр ажиллуулах тухай санал гаргах, голлох мэргэжилтний дээрх жагсаалтад ороогүй бусад мэргэжлийн чиглэлээр зөвлөх мэргэжилтэн нэмж ажиллуулж болно. Бусад шаардлагатай төрөл бүрийн хайгуул, судалгааны мэргэжилтнүүд, УЦС-ын, цахилгааны, авто зам, барилга, барилгын инженерийн хийц, сургалт хариуцсан, байгаль орчин, нийгмийн чиглэлийн шаардлагатай бүх мэргэжилтнүүдийг багтаасан иж бүрэн багийг ажиллуулна.

Энэхүү ажлын удирдамжид заасан ажлыг гүйцэтгэхийн тулд зөвлөх нь ТЭЗҮ боловсруулах судалгааны турш Улаанбаатар хотод төслийн оффистой байх шаардлагатай.

ТЕНДЕРИЙН ҮНЭЛГЭЭНД ХАРГАЛЗАХ НЭМЭЛТ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТҮҮД

“Хэрлэн-Тооно” төслийн Техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг шинэчлэх, тодотгол боловсруулах ажлын хүрээнд “Хэрлэн-Тооно” төслийг хэрэгжүүлэх маршрут, трассыг тодорхойлохдоо “Эрдэнэс ҮТП” ХХК-тай хэлэлцэн, доорх төслүүдтэй уялдуулах арга хэмжээг авч, ТЭЗҮ-д холбогдох хувилбар, тооцооллыг тусгах. Үүнд:

1. “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн боловсруулж буй “Бор-өндөр ҮТП” төслийн талбай, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах;
2. “Эрдэнэс ҮТП” ХХК-ийн боловсруулж буй “Тавантолгой ҮТП” төслийн талбай, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах.

Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 32.1-д үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлт ашиглахаар заасан бол захиалагч тендерийн үнэлгээнд харгалзах шалгуур үзүүлэлтийг үлдээж бусад шалгуур үзүүлэлтийг хасна.

Энэ бүлэг нь ТШЗ-ны зүйл бөгөөд захиалагч өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрсөн бол тендерийн үнэлгээ хийхэд тендерийн маягтад тусгасан үнийн саналаас гадна энэ хэсэгт заасан нэг буюу хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг мөнгөөр илэрхийлэн, тендерийн үнийг хийсвэрээр нэмэгдүүлэх замаар тендерийн харьцуулах үнийг тодорхойлон үнэлгээ хийх зорилгоор ашиглана.

Захиалагч энэ хэсэгт зааснаас өөр шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд харгалзахгүй.

1. Үйлчилгээ дуусгах хугацаа: *["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих]*

Хэрэв "ашиглах" бол: Тухайн тендер шалгаруулалтад холбогдох гэрээний дагуу гүйцэтгэх хуваарьт заасан зөвшөөрөгдөх хугацааны хооронд (гэрээний үүргийн гүйцэтгэлийг эхлэх эхний өдрөөс хойш үүрэг гүйцэтгэвэл зохих сүүлчийн өдрийг оролцуулан) гэрээний үүргийг хэрэгжүүлсэн байх шаардлагатай. Захиалагчийн заасан гэрээний үүрэг гүйцэтгэх хугацаанаас өмнө гүйцэтгэх санал ирүүлсэн тендерт урамшуулал, эсхүл үнэлгээнд бусад тендерээс давуу нөхцөл олгохгүй.

*Захиалагч уг шалгуур үзүүлэлтийг үнэлгээнд ашиглахаар тусгайлан зөвшөөрсөн тохиолдолд захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас хоцорч гүйцэтгэхээр санал болгосон тендерээс татгалзахгүй ба үнэлгээнд харгалзах зорилгоор хоцорсон хоног тутамд **[хувь бичих]**-аар тооцож тендерийн харьцуулах үнэ дээр нэмнэ.*

*Захиалагчаас заасан гэрээний гүйцэтгэлийн хуваарьт зааснаас **[тоо бичих]**-аас илүү **["сар", "өдөр" гэдэг үгнээс сонгож бичих]** хоцроож гүйцэтгэх санал болгосон тендерээс татгалзана. Харин өгөгдлийн хүснэгтэд тусгайлан зөвшөөрөөгүй тохиолдолд захиалагчийн тогтоосон гүйцэтгэлийн хуваариас хойш гүйцэтгэх санал ирүүлсэн тендерийг шаардлагад нийцээгүй гэж үзнэ.*

2. Үйлчилгээний гэрээний гүйцэтгэлийн дараах үйлчилгээг захиалагчийн заасан газар үзүүлэх боломж: *["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих.]*

Хэрэв "ашиглах" бол урсгал засвар үйлчилгээний цэг бий болгох болон үндсэн/шаардлагатай сэлбэг хэрэгслээр хангахын тулд захиалагчид шаардагдах зардлыг тусад нь үнэлж ирүүлсэн бол түүнийг үнэлгээний зорилгоор тендерийн харьцуулах үнэ дээр нэмж үнэлнэ.

3. Байгаль орчинд нөлөөлөх байдал: *["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих.]*

*Гэрээний гүйцэтгэлийн явцад байгаль орчинд нөлөөлөх байдалтай холбоотой дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

4. Хуульд нийцсэн бусад шалгуур үзүүлэлт: *["Ашиглана" эсхүл "Ашиглахгүй" гэж бичих.]*

*Гэрээний гүйцэтгэлд хамаарах хуульд нийцсэн дараах үзүүлэлтийг үнэлгээнд харгалзан үзэж, тендерийн харьцуулах үнэ дээр хийсвэрээр нэмж үнэлнэ. **[Захиалагч харгалзан үзэх шалгуур үзүүлэлт, түүнд хамаарах утгыг доор жагсааж бичих.]***

Тухайлбал хуулийн 12.3-т заасныг үндэслэн тендерийн үнэлгээнд эрчим хүч, байгалийн нөөцийн хэмнэлттэй, эдийн засгийн үр ашигтай хэрэглээний тогтвортой байдлыг хангах, байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй,

хүлэмжийн хийн ялгарал болон хаягдал багатай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, ногоон орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйлчилгээ үзүүлэх тендерийн харьцуулах үнийг тодорхойлж болно.

V БҮЛЭГ.ТЕНДЕРИЙН ЖИШИГ МАЯГТ Маягт 1.Тендер илгээх маягт

[огноо]

[Захиалагч байгууллагын нэр]-д

Манай [оролцогчийн нэр] нь танай байгууллагаас зарласан [тендер шалгаруулалтын нэр, дугаар] тендер шалгаруулалтад [үнийн хөнгөлөлт тооцоогүй тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичигт заасан хуваарийн дагуу үйлчилгээ үзүүлэхээр, дор дурдсан нөхцөлийг баталж энэхүү тендер (цаашид “тендер” гэх)-ийг хүргүүлж байна. Үүнд:

1. Тендерийн баримт бичиг, түүнд заасан гэрээний нөхцөл (гэрээний ерөнхий нөхцөл, тусгай нөхцөл, гэрээ баталгаажуулах маягт)-тэй танилцаж, бүрэн хүлээн зөвшөөрч тендер шалгаруулалтад оролцсон.
2. Оролцогч, түүний түншлэлийн гишүүн худалдан авах ажиллагаанд оролцох холбоотой хуулиар хориглосон нөхцөлд хамаарахгүй бөгөөд үүний дотор дараах нөхцөлийг гэрчилж байна:
 - 2.1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д заасан нөхцөл үүсээгүй;
 - 2.2. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний эцсийн өмчлөгч, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэгт заасан албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд биш;
 - 2.3. Захиалагчийн удирдлага, хяналт, захиргаанд ажилладаг албан тушаалтанд ашиг олгодоггүй.
 - 2.4. Оролцогчийг төлөөлж буй этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалтад заасан хязгаарлалтад хамаарахгүй.
3. Тендертэй холбоотой нотлох баримт, мэдээллийг холбогдох этгээдээс гаргуулах эрхийг захиалагчид үүгээр олгож байна.
4. Тендерт үнийн хөнгөлөлт [**“санал болгоно” эсхүл “санал болгохгүй” гэж бичих**]. [**Хэрэв үнийн хөнгөлөлт санал болгох бол түүнийг хэрхэн хэрэглэх нөхцөл, аргачлалыг бичих**].
5. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер нээснээс хойш [**ажлын 30 ба түүнээс дээш хоногийн тоо**] хоногийн хугацаанд хүчинтэй байна.¹
6. Тендерийн баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 6 дугаар зүйл, 13.4 болон 17.1-д заасныг зөрчсөн, эсхүл тендерт хуурамч баримт бичиг, мэдээллийг хүргүүлсэн бол уг тендерийг илт худал мэдээлэл бүхий тендер гэж тооцохыг хүлээн зөвшөөрч байна.
7. Тендерт санал болгосон үйлчилгээ нь окууны өмчийн зөрчилгүй, эрхийн болон биет байдлын доголдолгүй болохыг баталж байна.

¹ Хэрэв тендер шалгаруулалт нь урьдчилсан худалдан авах ажиллагааны журмаар зохион байгуулагдах бол “5. Тендер нь тендерийн баримт бичигт зааснаар хугацаагүй хүчинтэй байна.” гэж сольж бичнэ үү.

8. Тендерийг холбогдох журмын дагуу бусад оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч, тендерийг нууцлах аливаа үүргээс захиалагчийг бүрэн чөлөөлж байна.

***[Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээд,
эсхүл түүнээс эрх олгогдсон этгээдийн нэр,
албан тушаал, гарын үсэг,
байгууллагын тамга, тэмдэг]:***

Хаяг:

Маягт 2. Ижил төстэй үйлчилгээ үзүүлсэн гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Хугацаа /эхэлсэн, дууссан/

Маягт 3.Ижил төстэй гэрээний дэлгэрэнгүй мэдээлэл

Оролцогчийн нэр: *[түншлэлийн гишүүн тус бүр бүрэн дуусгавар болсон гэрээ тус бүрээр бөглөнө].*

1.	Захиалагчийн нэр
2.	Гэрээний нэр
3.	Гэрээний дугаар
4.	Гэрээ байгуулсан огноо
5.	Гэрээ дуусгавар болсон огноо
6.	Гэрээний дүн
7.	Гэрээ гүйцэтгэсэн хаяг, байршил
	Гэрээнд оролцсон байдал (нэгийг сонгох) <input type="checkbox"/> Үндсэн нийлүүлэгч <input type="checkbox"/> Түншлэлийн гишүүн <input type="checkbox"/> Туслан гүйцэтгэгч

Маягт 4.Хэрэгжүүлж байгаа, хэрэгжүүлэхээр эрх авсан гэрээний мэдээлэл

Гэрээний нэр	Захиалагчийн нэр, хаяг, холбоо барих утас	Төсөвт өртөг	Гэрээ эхэлсэн хугацаа	Хүлээгдэж буй гүйцэтгэлийн хувь, мөнгөн дүнгээр	Дуусах хугацаа

Маягт 5. Үйлчилгээг үзүүлэх ажлын хөтөлбөр болон аргачлалын талаарх танилцуулга

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврыг гүйцэтгэх аргачлалын талаарх танилцуулга болон хэрэв ажлын даалгаврын талаар гаргах санал, зөвлөмж ирүүлнэ.

Маягт 6. Үйлчилгээ үзүүлэх хуваарь

Техникийн тодорхойлолтод тусгагдсан ажлын даалгаврын дагуу үзүүлэх үйлчилгээг гүйцэтгэх хуваарийг боловсруулж ирүүлнэ.

Маягт 7. Хүний нөөцийн мэдээлэл

Албан тушаал	Ажилтны нэр	Боловсрол, мэргэжлийн ур чадвар	Нийт ажлын туршлага, жилээр	Тухайн албан тушаалд ажилласан туршлага, жилээр

Маягт 10. Санал болгож буй ажилтны жишиг намтар (сv)

Санал болгож буй албан тушаал: _____

Овог, нэр: _____

Мэргэжил: _____

Төрсөн он, сар, өдөр: _____

Тухайн байгууллагад ажилласан жил: _____ Иргэншил: _____

Мэргэжлийн холбооны гишүүнчлэл: _____

Хариуцах ажил: _____

Ур чадварын:

[Хариуцах ажлын чиглэлээр туршлагажсан, сургалтад хамрагдсан байдлыг товч харуулна. Өмнө гүйцэтгэж байсан ижил төрлийн зөвлөх үйлчилгээнд хариуцаж байсан ажил, хугацаа, байршилыг зааж харуулах. Эдгээр мэдээллийг хагас хуудсанд багтааж бичнэ.]

Боловсрол:

[Мэргэжилтний их, дээд сургууль, коллеж болон бусад эзэмшсэн мэргэжлийн боловсролын байдал, сургуулийн нэрс, оролцсон/дүүргэсэн хугацаа болон хамгаалсан эрдмийн зэргийн хамт нэгтгэж харуулах. Эдгээр мэдээллийг хуудасны дөрөвний нэгт багтааж бичнэ.]

Ажилласан туршлага:

[Өнөөгийн байдлаас эхлэн эсрэг дарааллаар ажилласан туршлагыг бич. Сургууль төгссөнөөс хойш ажилласан бүх албан тушаалын нэр, ажил эрхэлсэн хугацаа, ажил олгогч байгууллага, байршил зэргийг бичнэ. Сүүлийн 10 жилийн туршлагын хувьд гүйцэтгэсэн ажил, үйлчилгээ болон шаардлагатай бол харилцагчийн тодорхойлолтыг хавсаргана. Эдгээр мэдээллийг бичгийн 2 хуудсанд багтаан бичнэ.]

Хэлний мэдлэг:

[Эзэмшсэн хэлний мэдлэгийн түвшинг ярих, унших, бичих тус бүрд онц, сайн, дунд эсхүл муу гэж тодорхойлно.]

Батламж:

Дээрх мэдээлэл нь миний мэдлэг, чадвар, туршлагыг үнэн зөв харуулсан болохыг үүгээр баталж байна.

Мэргэжилтний овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Эрх бүхий этгээдийн овог, нэр, гарын үсэг: _____ Огноо: _____

Маягт 11. Үндсэн тоног төхөөрөмж, техник хэрэгслийн мэдээлэл

Машин механизм, тоног төхөөрөмжийн нэр, зориулалт	Хүчин чадал	Тоо ширхэг	<i>["Өөрийн эзэмшил" эсхүл "түрээс" аль нэгийг бичих]</i>

Маягт 12. Нууцалсан баримт бичиг, мэдээллийн жагсаалт

		Нууцалсан баримт бичиг, мэдээлэл	Хүний эмзэг мэдээлэлд хамаарах хууль зүйн үндэслэл
1.			
2.			
3.			
4.			
5.			

VI БҮЛЭГ. ГЭРЭЭНИЙ НӨХЦӨЛ

Захиалагч, түүнээс томилсон үнэлгээний хороо нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн дагуу тендер шалгаруулалт зохион байгуулж үйлчилгээ үзүүлэхэд энэхүү гэрээний загварыг боловсруулж ашиглана.

Гэрээний ерөнхий нөхцөл (цаашид “ГЕН” гэх) болон гэрээний тусгай нөхцөл (цаашид “ГТН” гэх), гэрээ баталгаажуулах маягт, түүнд заасан бусад баримт бичиг нь хоёр талын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох баримт бичиг болно. Энэ гэрээ нь захиалагчаас ажил, түүнтэй холбогдох бараа нийлүүлэх, үйлчилгээг үзүүлэх харилцааг зохицуулсан жишиг заалтуудыг агуулна. Гэрээний нөхцөлийг боловсруулахад ГЕН-д өөрчлөлт оруулахгүй.

ГТН-ийг тухайн ажлыг гүйцэтгүүлэх нөхцөлд тохируулан ГЕН-ийн холбогдох зүйл, заалтыг тодруулах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор ашиглана. *Гэрээний нөхцөлийг бэлтгэхэд дараахыг анхаарна:*

ГЕН-ийн аль нэг зүйлд тодорхой мэдээллийг ГТН-д тусгахаар заасан бол холбогдох мэдээллийг ГТН-д заавал оруулна. ГЕН-ийн аль нэг зүйл, заалтыг тухайн ажлыг гүйцэтгэхэд хэрэглэхгүй бол энэ тухай ГТН-д тусгах;

1. Гэрээ баталгаажуулах маягтад шалгарсан тендерт оролцогчийн мэдээлэл болон “хамгийн сайн” үнэлэгдсэн тендерийн мэдээллийг тусгах;
2. Гэрээний үнийг тендерийн үнэд залруулга болон хөнгөлөлтийг тооцох бол түүнийг тооцож, нэг валютад хөрвүүлсний дараах үнээр тогтоох;
3. Гүйцэтгэх ажил, дагалдах бараа, үйлчилгээний дэлгэрэнгүй тодорхойлолт, зураг зэргийг гэрээнд хавсаргах;
4. ГЕН, ГТН болон холбогдох хавсралтууд нь өөр хоорондоо зөрчилдөөнгүй байх;
5. Гэрээ баталгаажуулах маягтын хаалтны дотор бичсэн жишээ, зааврыг тендер шалгаруулалтын үр дүнд шалгарсан тендерийн нөхцөлд тохирох үг, өгүүлбэр, тоо хэмжээ зэргээр тусгана. Зарим жишээ нөхцөлийг зөвхөн санаа өгөх зорилгоор оруулсан ба тухайн гэрээний онцлогийг харгалзан захиалагч эцэслэнэ.
6. Гэрээний зүйл болон бусад хэсгийн гарчиг нь гэрээний нөхцөлийн утга агуулгыг тайлбарлах үндэслэл болохгүй.

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

НЭГ. ТОДОРХОЙЛОЛТ БА ТАЙЛБАР

Тодорхойлолт

- 1.1. Энэхүү гэрээнд хэрэглэсэн үг, хэллэг, илэрхийлэл дор дурдсан утгыг агуулна:
 - 1.1.1. “Захиалагч” гэж Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.2. “Захиалагчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Гүйцэтгэгчтэй харилцах, хяналтыг хэрэгжүүлэх эрхтэй Захиалагчаас томилогдсон этгээдийг;
 - 1.1.3. “Гүйцэтгэгч” гэж гэрээ байгуулах эрх авсан бөгөөд Гэрээ баталгаажуулах маягтад нэрлэсэн этгээдийг;
 - 1.1.4. “Гүйцэтгэгчийн төлөөлөгч” гэж Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахаас бусад Гэрээтэй холбоотой бүх асуудлаар Захиалагчтай харилцах эрхтэй Гүйцэтгэгчээс томилогдсон этгээдийг;
 - 1.1.5. “Талууд” гэж Захиалагч болон Гүйцэтгэгчийг хамтад нь нэрлэснийг;
 - 1.1.6. “Хууль” гэж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг;
 - 1.1.7. “Үйлчилгээ” гэж ажлын даалгавар, техникийн тодорхойлолтод заасан ажлыг;
 - 1.1.8. “Ажлын байр” гэж ажил гүйцэтгэж байгаа газрыг;
 - 1.1.9. “Баталгаат хугацаа” гэж гүйцэтгэсэн ажлыг ашиглах явцад ажилд илэрсэн доголдлыг Гүйцэтгэгч хариуцах хугацааг;
 - 1.1.10. “Гомдлын шаардлага гаргах хугацаа” гэж Захиалагчаас баталгаат хугацаанд илрүүлсэн доголдолтой холбогдуулж Гүйцэтгэгчид шаардлага гаргах хугацааг;
 - 1.1.11. “Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал” гэж талуудын хараа хяналтаас гадуур болсон, урьдчилан таамаглах боломжгүй, гэрээний үүргийг гүйцэтгэх боломжгүй болгох байгалийн гамшиг, Төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтны үйлдэл /эс үйлдэхүй/, гоц халдварт, олон улсын хөл хориот өвчин, цар тахлын улмаас бүх нийтийн хорио цээр тогтоосон нөхцөл байдал бий болохыг ойлгоно.

- Тайлбар
- 1.2. Гэрээг тайлбарлах, хэрэглэхэд дараах журмыг баримтална:
 - 1.2.1. Ганц тоогоор илэрхийлсэн үг нь олон тоон утгыг, олон тоогоор илэрхийлсэн үг нь ганц тоон утгыг илэрхийлж болно.
 - 1.2.2. Бүлэг болон зүйлийн гарчиг нь гэрээг системчлэх зорилготой бөгөөд гэрээг тайлбарлахад ашиглахгүй.
 - 1.2.3. Зүйл, заалт, үг өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд Иргэний хуульд заасан журмыг баримтлан тайлбарлана.
 - 1.2.4. Ерөнхий нөхцөл болон тусгай нөхцөл хоорондоо зөрчилдсөн тохиолдолд тусгай нөхцөлийг баримтална.
 - 1.2.5. Гэрээний хэрэгжилтийн явцад харилцах хэл нь Монгол хэл байх бөгөөд гэрээг өөр хэл дээр байгуулснаас хувиуд нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Монгол хэл дээрх хувийг баримтална.

ХОЁР. ЗАХИАЛАГЧ

- | | | |
|------------------------|---------|---|
| Захиалагчийн үүрэг | нийтлэг | <ol style="list-style-type: none"> 2.1. Захиалагч нь ажлын үр дүнг хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд үнийг төлнө. 2.2. Захиалагч хууль тогтоомж болон гэрээнд заасан баримт бичиг, зөвшөөрлийг Гүйцэтгэгчид зохих ёсоор гаргаж өгнө. 2.3. Захиалагч нь үйлчилгээ авахтай холбоотой гаргаж өгсөн ажлын даалгавар, техникийн нөхцөл зэрэг баримт бичгийн алдаатай холбоотой үр дагаврыг хариуцна. |
| Захиалагчийн төлөөлөгч | | <ol style="list-style-type: none"> 2.4. Захиалагчийг төлөөлөн гүйцэтгэгчтэй харилцах, хяналт тавих төлөөлөгчийг Захиалагч томилно. 2.5. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээллийг Гэрээ баталгаажуулах маягтад заана. 2.6. Захиалагчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно. |
| Талбайд зөвшөөрөл | нэвтрэх | <ol style="list-style-type: none"> 2.7. Захиалагч нь ажил эхлэхээс дуусах хүртэлх хугацаанд ажлын талбайд нэвтрэх, үйл ажиллагаа явуулах эрхийг Гүйцэтгэгчид бичгээр олгоно. 2.8. Ажлын талбайд нэвтрэх эрх олгоогүйгээс ажил гүйцэтгэх хугацаа хэтрэх болон түүнтэй холбоотой үүссэн аливаа үр дагаврыг Захиалагч хариуцна. |

ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧ

- | | | |
|---------------------------------|---------|---|
| Гүйцэтгэгчийн үүрэг | нийтлэг | <p>3.1. Гүйцэтгэгч нь ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагад нийцүүлэн гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж, Захиалагчид хүлээлгэн өгнө.</p> <p>3.2. Гүйцэтгэгч нь ажлын талбайд ажиллах хүч (удирдах ажилтан, инженер, техникийн ажилтан гэх мэт) болон ашиглаж буй тоног төхөөрөмж, машин механизмын дэлгэрэнгүй жагсаалт, мэдээллийг Захиалагчид өгнө.</p> <p>3.3. Ажил гүйцэтгэхэд шаардагдах материал, техник, тоног төхөөрөмж, машин механизм, сэлбэг хэрэгсэл, баримт бичгүүд, Гүйцэтгэгчийн түр ба байнгын ажлын байранд ажиллах ажилтан болон үйлчилгээг гүйцэтгэгч хариуцна.</p> <p>3.4. Ажлын явцад шаардлагатай ус, хий, цахилгаан холбооны болон бусад хангамжийг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>3.5. Гүйцэтгэгч нь нийт ажлын 20 (хорь) хувиас дээш ажлыг Туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>3.6. Гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бусдад шилжүүлэхгүй байх үүрэгтэй.</p> <p>3.7. Гүйцэтгэгч нь захиалагч, түүний эрх олгосон этгээдийг ажлын талбайд чөлөөтэй нэвтрүүлэх үүрэгтэй.</p> |
| Гүйцэтгэгчийн төлөөлөгч | | <p>3.8. Гүйцэтгэгч нь Захиалагчтай харилцах эрх бүхий этгээдийг томилж, гэрээ баталгаажуулах маягтад заана.</p> <p>3.9. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь гэрээнд заасан ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай тухайн салбараар мэргэшсэн, дадлага туршлага бүхий хүн байна.</p> <p>3.10. Гүйцэтгэгчийн төлөөлөгч нь төлөөлүүлэгчээс бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр эрх, үүргээ аливаа хэлбэрээр бусдад шилжүүлэхийг хориглоно.</p> |
| Техникийн болон талбайн өгөгдөл | ажлын | <p>3.11. Захиалагч нь үйлчилгээтэй холбоотой нөхцөл байдлын талаарх өөртөө байгаа бүх өгөгдөл мэдээллийг Гүйцэтгэгчид мэдээллийн журмаар ажил эхлэхээс өмнө өгнө.</p> |
| Аюулгүй байдал | | <p>3.12. Гүйцэтгэгч ажлын талбайд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Галын аюулгүй байдлын хууль зэрэг хөдөлмөрийн аюулгүй байдалд холбогдох бусад хууль тогтоомж, техникийн зохицуулалт, стандарт, норм ба дүрмийг дагаж мөрдүүлнэ.</p> <p>3.13. Гүйцэтгэгч нь ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангана.</p> <p>3.14. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг байгалийн болон бусад хүчин зүйлийн нөлөөллөөс хамгаална.</p> <p>3.15. Ажилчдын хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.</p> |

- 3.16. Гүйцэтгэгч нь хөдөлмөрийн аюулгүй байдалтай холбоотой үүссэн аливаа хариуцлагыг бүрэн хариуцна.
- 3.17. Гүйцэтгэгч нь ГЕН-ийн 3.19-3.22-т заасан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүсэх аливаа үр дагаврыг бүрэн хариуцна.
- 3.18. Ажилд ашигласан эсхүл бий болгосон аюултай, хортой, бохирдсон материал, бодисыг холбогдох хууль тогтоомж, Захиалагчийн шаардлагын дагуу хадгалж, устгана.

ДӨРӨВ. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА, ЯВЦЫН ТАЙЛАН

Ажил эхлэх

- 4.1. Гүйцэтгэгч нь ГТН-д заасан хугацаанд ажлыг эхлүүлж, ажлын хуваарийн дагуу гүйцэтгэнэ.
- 4.2. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө)-ийг ГТН-д заасан хугацаанд захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.3. Хөтөлбөрт ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажлыг эхлэхээс дуусах хүртэл ажлын үе шатны хугацааг болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан байна.
- 4.4. Хөтөлбөр (төлөвлөгөө)-т өөрчлөлт оруулсан тохиолдолд Захиалагчийн төлөөлөгчид мэдэгдэнэ.

Хугацаа сунгах

- 4.5. Гүйцэтгэгч дараах тохиолдолд ажил гүйцэтгэх хугацааг сунгах тухай хүсэлт гаргаж болно:
 - 4.5.1. ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон;
 - 4.5.2. холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандарт шинээр батлагдсан, өөрчлөгдсөн нь ажлын гүйцэтгэлд нөлөөлөхөөр байвал;
 - 4.5.3. Захиалагч хугацаандаа төлбөр төлөх үүргээ биелүүлээгүй;
 - 4.5.4. Захиалагч зөвшөөрөл, баримт бичиг гаргуулах хүргүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй нь ажлын хугацаанд нөлөөлсөн.

Ажлын явцын тайлан

- 4.6. Гүйцэтгэгч хугацаа сунгах хүсэлтийг холбогдох нотлох баримтын хамт Захиалагчид ирүүлнэ.
- 4.7. ГЕН-ийн 4.5.1-т заасан нөхцөл байдал үүссэн болохыг Гүйцэтгэгч нотлох үүрэгтэй.
- 4.8. Захиалагч ГЕН-ийн 4.5-д заасан үндэслэлийн аль нэг нь бүрдсэн тохиолдолд Гүйцэтгэгчийн хүсэлтийг үндэслэн хугацааг сунгаж болно.
- 4.9. Гүйцэтгэгч ажлын явцын тайланг ГТН-д заасан хуваарийн дагуу гаргаж Захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.
- 4.10. Явцын тайланд үйл ажиллагаа бүрийн бодит гүйцэтгэлийн хувийг гаргаж, түүнийг төлөвлөсөн хувьтай харьцуулсан харьцуулалт, хийгдээгүй ажил

байвал тухайн ажлын талаарх мэдээлэл, хэзээ хийх санал, Захиалагчийн төлөөлөгчийн шаардсан бусад мэдээллийг тусгана.

- 4.11. Гүйцэтгэгч нь ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг ажиллуулж, техник үйлчилгээ хийх, задлах, буцаан угсрах, тохиргоо хийх болон засварлах талаар ашиглалт үйлчилгээний зааварчилгааг Захиалагчид гаргаж өгнө.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ҮНЭ БА ТӨЛБӨРИЙН НӨХЦӨЛ

Гэрээний үнэ	5.1. Гэрээний үнийг гэрээ баталгаажуулах маягтад заана.
	5.2. Гэрээний үнэд хуулийн 11.11-д заасан үндэслэлээр тохируулга хийх эсэх, тохируулга хийх бол аргачлалыг ГТН-д тусгана.
	5.3. ГЕН-ийн 5.2-т заасны дагуу үнэ тохируулж, гэрээний үнэ өөрчлөгдсөн тохиолдолд гэрээнд нэмэлт, өөрчлөлт орсноос хойш өөрчлөгдсөн үнийг баримтална.
Урьдчилгаа төлбөр	5.4. Тендер шалгаруулалтын баримт бичигт урьдчилгаа төлбөр олгохоор заасан бөгөөд Гүйцэтгэгч урьдчилгаа төлбөрийн хүсэлт гаргасан бол Захиалагч урьдчилгаа төлбөрийг ГТН-д заасан хэмжээгээр олгоно.
	5.5. Захиалагч нь урьдчилгаа төлбөрийн баталгааг хүлээн авснаас хойш Гүйцэтгэгчид ГТН-д заасан хугацаанд урьдчилгаа төлбөр олгоно.
Төлбөрийн нөхцөл	5.6. Захиалагч нь төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхийг үндэслэн ГТН-д заасан хугацаанд төлбөрийг төлнө.
	5.7. Захиалагч гэрээний үүргийг зохих ёсоор гүйцэтгэсэн тухай баримтын хуулбар хувь болон холбогдох баримтыг төлбөрийн хүсэлт, нэхэмжлэхэд хавсаргахыг шаардаж болно.
	5.8. Гүйцэтгэгчийн хүсэлтээр Захиалагч ажил хүлээлгэн өгөх хугацааг ГЕН-ийн 4.8-д заасны дагуу сунгасан бол сунгагдсан хугацаагаар Захиалагчийн төлбөр төлөх хугацааг сунгагдсан гэж үзнэ.
	5.9. Захиалагчийн төлсөн аливаа төлбөрийг ажил, түүний бүрэлдэхүүний хэсгийг хүлээн зөвшөөрсөн гэж үзэх үндэслэл болохгүй.
	5.10. Төлбөрийн нэхэмжлэх нь Монгол Улсын Үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлэгдсэн байна.
	5.11. Захиалагч нь алданги болон бусад төлбөр шаардах эрхтэй бол Гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутгана.

ЗУРГАА. БАТАЛГАА БА БАТАЛГААТ ХУГАЦАА

- | | | | |
|-----------------------|-----------|-------|--|
| Урьдчилгаа баталгаа | төлбөрийн | 6.1. | ГЕН-ийн 5.4-д заасны дагуу урьдчилгаа төлбөр олгохоор бол ГТН-д заасан хэмжээний урьдчилгаа төлбөрийн баталгааг ГТН-д заасан хугацааны дотор хуульд заасан хэлбэрээр, холбогдох маягтын дагуу ирүүлнэ. |
| Гүйцэтгэлийн баталгаа | | 6.2. | Гүйцэтгэлийн баталгаа гаргуулахаар Өгөгдлийн хүснэгтэд заасан бол Гүйцэтгэгч нь тухайн төсвийн жилд санхүүжих дүнгийн 3 хувийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг холбогдох маягтын дагуу захиалагчаас шаардсан хугацааны дотор ирүүлнэ. Төсвийн жил дамжин хэрэгжих гэрээний гүйцэтгэлийн баталгааг Гүйцэтгэгч жил бүр шинэчлэн ирүүлнэ. |
| | | 6.3. | Захиалагч дараах нөхцөл бий болсон тохиолдолд үүргийн гүйцэтгэлийг Гүйцэтгэлийн баталгаагаар үл маргах журмаар хангуулна:
6.3.1. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ аливаа шалтгааны улмаас гүйцэтгээгүй;
6.3.2. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор гүйцэтгээгүй;
6.3.3. Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон. |
| | | 6.4. | Захиалагч Гүйцэтгэлийн баталгаагаар үүргийн гүйцэтгэлийг хангуулсан нь Гүйцэтгэгчээс алданги, хохирол шаардах эрхийг хязгаарлахгүй. |
| | | 6.5. | ГЕН-ийн 4.8-д заасны дагуу хугацаа сунгагдсан тохиолдолд Гүйцэтгэгч гүйцэтгэлийн баталгааг мөн хугацаагаар сунгуулна. |
| | | 6.6. | Чанарын баталгаа шаардсан тохиолдолд ГЕН-ийн 6.8-д заасан Чанарын баталгаа гаргаснаар Гүйцэтгэлийн баталгааг чөлөөлнө. |
| Чанарын баталгаа | | 6.7. | Үйлчилгээний чанарын баталгааг хангуулах зорилгоор баталгаат хугацаанд Чанарын баталгаа гаргуулж болно. Чанарын баталгаа гаргуулах бол чанарын баталгааны хэмжээг ГТН-д заана. |
| | | 6.8. | Гүйцэтгэгч Чанарын баталгааг хуулийн 42.5-д заасны дагуу баталгаажуулж болно. |
| | | 6.9. | ГЕН-ийн 6.9-д заасны дагуу баталгаажуулсан тохиолдолд Захиалагч барьцаалсан мөнгийг баталгаанд заасан дүнтэй тэнцэх хэмжээгээр олгоно. |
| | | 6.10. | Баталгаат хугацаанд үйлчилгээнд аливаа доголдол илрээгүй бол Чанарын баталгааг чөлөөлнө. |
| | | 6.11. | ГЕН-ийн 8.6-д зааснаар Захиалагч доголдлыг арилгасан бол доголдол арилгахтай холбоотой гарсан зардал, хохирлыг суутгаж, баталгаат хугацаа дуусмагц үлдсэн мөнгийг Гүйцэтгэгчид олгоно. |
| | | 6.12. | ГЕН-ийн 8.5-д заасны дагуу доголдлыг арилгасан тохиолдолд баталгаат болон гомдлын шаардлага гаргах хугацаа хэвийн үргэлжилнэ. |

- Баталгаат хугацаа
- 6.13. Ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт баталгаат хугацаа тогтоох бөгөөд баталгаат хугацааг ГТН-д заана.
- 6.14. Захиалагч нь баталгаат хугацаанд илэрсэн доголдлыг арилгуулахыг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй.

ДОЛОО. ЭРСДЭЛ БА ДААТГАЛ

- | | |
|---|---|
| Бусдад
учруулсан
хохирлыг арилгах | <p>7.1. Үйлчилгээ үзүүлэх хугацаанд Гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч түүний эрх бүхий этгээдийн аливаа үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас бусдад эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол хохирлыг Гүйцэтгэгч хариуцна.</p> <p>7.2. Захиалагч түүний эрх олгогдсон этгээдийн үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас эдийн болон эдийн бус хохирол (хүний амь нас, эрүүл мэнд) учирсан бол Гүйцэтгэгч хариуцахгүй.</p> |
| Захиалагчийн
эрсдэл | <p>7.3. Захиалагч дараах эрсдэлийг хариуцна:</p> <p>7.3.1. Үйлчилгээний үр дүнг захиалагчид шилжүүлснээс хойш ажлын үр дүн Гэнэтийн буюу давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас гэмтсэн, устсан;</p> <p>7.3.2. гүйцэтгэсэн үйлчилгээг хүлээлгэн өгөх мэдэгдэл өгсөн боловч захиалагч ажлыг хүлээн авах үүргээ биелүүлээгүйгээс ажил, түүний бүрэлдэхүүн хэсэг гэмтсэн, устсан;</p> <p>7.3.3. Захиалагчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-н улмаас үйлчилгээ, материал болон тоног төхөөрөмж гэмтсэн, устсан;</p> <p>7.3.4. Захиалагчийн ажлын даалгаврын алдааны улмаас үүссэн аливаа эрсдэл.</p> <p>7.4. Үйлчилгээний доголдлын улмаас захиалагч ажлын үр дүнг хүлээн авахаас татгалзсан бол ажлыг хүлээн авах хүртэлх хугацаанд бий болсон аливаа эрсдэлийг захиалагч хариуцахгүй.</p> |
| Даатгал | <p>7.5. Гүйцэтгэгч нь ажлын явцад учирч болзошгүй эрсдэлийг ажил эхлэх өдрөөс дуусах хүртэл хугацаанд ГТН-д заасан даатгалд даатгуулна.</p> <p>7.6. Захиалагч болон гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгчийн буруутай үйлдэл (эс үйлдэхүй)-ээс гуравдагч этгээдийн амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөнд учирч болзошгүй хохирлыг Гүйцэтгэгч даатгуулна.</p> <p>7.7. Гүйцэтгэгч нь даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг захиалагчийн төлөөлөгчид хүргүүлнэ.</p> <p>7.8. Гүйцэтгэгч даатгалын гэрээ, гэрчилгээний хуулбар хувийг ирүүлээгүй бол захиалагч уг даатгалын гэрээг байгуулж, даатгалын хураамжийг Гүйцэтгэгчээс гаргуулна.</p> <p>7.9. Даатгалын нөхцөлийг Захиалагчийн төлөөлөгчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөхийг хориглоно.</p> |

НАЙМ. ДОГОЛДОЛ, ДАЛД ДОГОЛДОЛ

- | | | |
|------------------------|-----------|---|
| Доголдлыг арилгах | илрүүлэх, | 8.1. Гүйцэтгэгчээс ирүүлсэн үйлчилгээ, түүний хэсэг нь зөрчил, доголдолгүй байна. |
| | | 8.2. Захиалагчийн төлөөлөгч үйлчилгээний явцад зөрчил, доголдолтой байж болзошгүй аливаа ажилд зөрчил, доголдлыг илрүүлэх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг Гүйцэтгэгчид өгнө. |
| | | 8.3. Захиалагч хүлээж авсан ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт ГТН-д заасан баталгаат хугацааны дотор зөрчил, доголдол илэрвэл гомдлын шаардлага гаргах хугацаа дуусахаас өмнө зөрчил, доголдол арилгах тухай мэдэгдлийг Гүйцэтгэгчид хүргүүлнэ. |
| | | 8.4. Гүйцэтгэгч Доголдол арилгах тухай мэдэгдлийг хүлээн авмагц доголдол арилгах ажлыг эхлүүлнэ. |
| | | 8.5. Доголдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр Гүйцэтгэгч уг зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд өөрийн зардлаар арилгана. |
| | | 8.6. Гүйцэтгэгч зөрчил, доголдлыг мэдэгдэлд заасан хугацаанд арилгаагүй бол Захиалагч өөрийн зардлаар арилгаж болно. |
| | | 8.7. Захиалагчийн гаргасан зардлыг Гүйцэтгэгч үл маргах журмаар төлнө. |
| | | 8.8. Доголдлыг арилгах явцад ажил, түүний бүрэлдэхүүн хэсгийг Захиалагч ашиглаж чадаагүй бол доголдлыг арилгах хугацаагаар баталгаат хугацаа сунгагдана. |
| Далд доголдол | | 8.9. Ажил хүлээн авсан баримт (акт) үйлдсэн ч ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт илэрсэн, далд доголдол, түүний улмаас үүссэн аливаа үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна. |
| Зураг төслийн доголдол | | 8.10. Зураг төслийг Захиалагч боловсруулсан бол зураг төсөлтэй холбоотой аливаа асуудал (зураг төслийн үнэн зөв, түүнээс үүссэн ажлын доголдол гэх мэт)-ыг Захиалагч хариуцна. |
| | | 8.11. Гүйцэтгэгч нь өөрийн гүйцэтгэсэн Ажлын зураг төсөл, холбогдох баримт бичгүүд, мэдээлэл ба өгөгдлүүдийн үнэн зөвийг хариуцна. |

ЕС. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

- | | | |
|-------------------------|------|--|
| Захиалагч гэрээг цуцлах | 9.1. | Захиалагч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
9.1.1. Гүйцэтгэгч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр үйлчилгээ үзүүлээгүй;
9.1.2. Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацааг тогтоосон боловч үр дүн гараагүй;
9.1.3. Гүйцэтгэгч Гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн бусдад шилжүүлсэн, бусдаар гүйцэтгүүлсэн; |
|-------------------------|------|--|

- 9.1.4. Гүйцэтгэгч нь тендерт оролцохдоо буюу гэрээг гүйцэтгэх явцдаа авилгийн гэмт хэрэгт холбогдсон нь шүүх болон холбогдох байгууллагаар тогтоогдсон;
- 9.1.5. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
- 9.1.6. Гүйцэтгэгч нийт ажлын 20 (хорь)-аас дээш хувийг нэг буюу түүнээс дээш туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлсэн;
- 9.1.7. Ажил гүйцэтгэх хугацаанд Гүйцэтгэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл дуусаж сунгагдаагүй, түдгэлзүүлсэн, хүчингүй болсон.
- 9.1.8. Гүйцэтгэгч өөрийн тендерийн давуу эрх тооцуулсан нөхцөлийн дагуу гэрээний үүргийг биелүүлээгүй, эсхүл хуулийн этгээдийн хувьд тус нөхцөлийг хангахгүй болсон.
- 9.2. Захиалагч ГЕН-ийн 9.1-д заасан үндэслэлээс гадна хэдийд ч гэрээг цуцалж болно.
- 9.3. Гүйцэтгэгч дараах үндэслэлээр гэрээг цуцалж болно:
 - 9.3.1. Захиалагч нь гэрээнд заасан үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бөгөөд тогтоосон нэмэлт хугацаанд биелүүлээгүй;
 - 9.3.2. ГТН-д заасан алдангийн нийт дүн гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 (тавин) хувиас хэтэрсэн;
 - 9.3.3. Захиалагч нь ажлыг түр зогсоосон нь гүйцэтгэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөхөөр бол.
- 9.4. Гэрээг цуцлах тал нь нөгөө талдаа үүргийн зөрчлийг арилгах нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэл хүргүүлнэ. Нэмэлт хугацаа нь үүргийг гүйцэтгэх ердийн боломжит хугацаа байна.
- 9.5. Тогтоосон нэмэлт хугацаанд үүргээ гүйцэтгээгүй эсхүл нэмэлт хугацаа тогтоосон ч үр дүнд хүрэхгүй болох нь илт, ГЕН-ийн 4.8-т зааснаар хугацаа сунгагдсан бол Захиалагч үүрэг гүйцэтгэх нэмэлт хугацаа тогтоохгүй байж болно.
- 9.6. Нэмэлт хугацаа тогтоох шаардлагагүй, нэмэлт хугацаа тогтоосон мэдэгдэлд хариу ирүүлээгүй эсхүл тогтоосон хугацаанд зөрчлийг арилгаагүй тохиолдолд гэрээг цуцлах тал нь нөгөө талд гэрээг цуцлах мэдэгдэл хүргүүлнэ.
- 9.7. Гүйцэтгэгч ГЕН-ийн 9.6-т заасан мэдэгдлийг хүлээн авсан бол нэн даруй эсхүл мэдэгдэлд заасан хугацаанд ажлын гүйцэтгэсэн хэсгийг хамгаалах, ажлын талбайг цэвэр аюулгүй нөхцөлд үлдээхэд чиглэснээс бусад цаашид гүйцэтгэх бүх ажлаа зогсоож, Гэрээг цуцлах өдөр хүртэл гүйцэтгэсэн

- ажил, түүний бүрэлдэхүүн хэсэгт холбогдох баримт бичгүүдийг Захиалагчид баримт (акт үйлдэн)-аар хүлээлгэн өгнө.
- Гэрээг цуцалсны дараах төлбөр
- 9.8. ГЕН-ийн 9.1-д заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Гүйцэтгэгч гэрээг цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөрийг шаардах эрхтэй.
- 9.9. ГЕН-ийн 9.2-т заасны дагуу Гэрээг цуцалсан тохиолдолд Захиалагч гүйцэтгэгчид дараах төлбөрийг төлнө:
- 9.9.1. Гэрээ цуцлах өдөр хүртэлх гүйцэтгэсэн ажлын төлбөр;
- 9.9.2. Ажлын талбайгаас Гүйцэтгэгчийн тоног төхөөрөмжийг нүүлгэхтэй холбоотой үүссэн зардал;
- 9.9.3. Гэрээг цуцалсантай холбоотойгоор Гүйцэтгэгчээс туслан гүйцэтгэгчид төлөх шаардлагатай болсон аливаа төлбөр;
- 9.9.4. Гүйцэтгэгчээс ажлыг хамгаалах, ажлын талбайг цэвэр, аюулгүй нөхцөлд үлдээхэд зарцуулсан зардал;
- 9.9.5. Гэрээг цуцалсантай шууд холбоотой бусад зардал, учирсан хохирол.

АРАВ. БУСАД ЗААЛТ

- Мэдэгдэл
- 10.1. Талуудын мэдэгдэл, зааварчилгаа, мэдээлэл болон бусад харилцаа төлөөлөгчөөр дамжина.
- 10.2. Гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой бүх мэдэгдэл (зөвшөөрөл, татгалзал, баталгаа, баталгаажуулалт, нэхэмжлэх, гэрчилгээ, шийдвэр, хүсэлт, захидал үүгээр хязгаарлагдахгүй) нь бичгээр үйлдэгдэнэ.
- 10.3. Мэдэгдлийг биечлэн хүргүүлэх эсхүл баталгаат шуудангаар гэрээ баталгаажуулах маягтад заасан төлөөлөгчийн хаягаар илгээнэ.
- 10.4. Дараах тохиолдолд мэдэгдлийг хүлээн авсанд тооцно:
- 10.4.1. баталгаат шуудангаар илгээсэн тохиолдолд шууданд хийсэн өдрөөр төлбөр төлсөн баримтыг үндэслэн;
- 10.4.2. биечлэн хүргүүлсэн мэдэгдлийг нөгөө талын төлөөлөх эрх бүхий этгээд хүлээн авсан огноогоор, тэмдэглэлийг үндэслэн.
- 10.5. Аль нэг тал нь ажлын газрын хаяг, утас, шуудангийн хаягаа сольсон тохиолдолд нөгөө талдаа нэн даруй бичгээр мэдэгдэнэ.

- 10.6. ГЕН-ийн 10.5-д заасан үүргээ биелүүлээгүйгээс үүсэх үр дагаврыг мэдэгдээгүй тал хариуцна.
- 10.7. Нэн даруй мэдэгдэх шаардлагатай яаралтай мэдэгдлийг ГЕН-ийн 10.2-т зааснаас өөр хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд мэдэгдлийг дараа нь баталгаажуулж бичгээр хүргүүлнэ.
- Төлөөлөгч өөрчлөгдөх 10.8. Талууд төлөөлөгчийг өөрийн санаачилгаар өөрчилж болно.
- 10.9. Төлөөлөгч өөрчлөгдсөн тохиолдолд нэн даруй нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.
- 10.10. Мэдэгдэлд төлөөлөгчийн эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, холбоо барих утас (ажлын болон хувийн), цахим шуудангийн хаягийг заавал тусгасан байна.
- 10.11. Төлөөлөгч өөрчлөгдсөн мэдэгдлийг нөгөө талд хүргүүлснээр өмнөх төлөөлөгчийн эрх, үүрэг дуусгавар болно.
- Үйлчилгээнд өөрчлөлт, залруулга хийх нөхцөл 10.12. Талууд үйлчилгээний чанар, үр ашиг, аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор ажлын ерөнхий гүйцэтгэлийн хүрээнд хамаарсан, техник технологийн хувьд боломжтой бөгөөд гэрээний хугацаа, үнэд нөлөөлөхгүй бол ажилд өөрчлөлт оруулж болно.
- 10.13. Гүйцэтгэгч болон Захиалагч өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд өөрчлөлтийн төслийг гүйцэтгэгч гаргана.
- 10.14. Захиалагч төслийг үндэслэн ГЕН-ийн 10.12-т заасан нөхцөл, шаардлага хангасан гэж үзвэл өөрчлөлт хийх мэдэгдлийг хүргүүлнэ.
- 10.15. Захиалагчийн зөвшөөрөлгүй өөрчлөлт хийсэнтэй холбоотой техник, технологийн алдаа гарсан, гэрээний хугацаа хэтэрсэн, үнэ өссөн тохиолдолд үр дагаврыг Гүйцэтгэгч хариуцна.
- Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал 10.16. Үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэх боломжгүйд хүргэсэн Гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд Гүйцэтгэгч энэ тухай нэн даруй Захиалагчийн төлөөлөгчид бичгээр мэдэгдэнэ. Бичгээр мэдэгдэх нь хугацаа шаардахаар бол ГЕН-ийн 10.7-д заасан хэлбэрээр урьдчилан мэдэгдэж болно.
- 10.17. Гүйцэтгэгч нь Захиалагчаас зааварчилгаа өгөх хүртэл гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга замыг хайна.
- 10.18. Захиалагч ердийн боломжит хугацаанд зааварчилгаа өгөх бөгөөд талууд харилцан зөвшилцөж гэрээг хэрэгжүүлэх боломжит бүх арга хэмжээг авна.

- 10.19. Гэрээг хэрэгжүүлэх захиалагчийн зааварчилгаа, Гүйцэтгэгчийн авсан арга хэмжээ үр дүнд хүрээгүй тохиолдолд Гүйцэтгэгч ГЕН-ийн 4.5-д заасан хүсэлтийг гаргаж болно.
- Оюуны өмчийн эрх зөрчих 10.20. Үйлчилгээг үзүүлэх явцад болон үйлчилгээ үзүүлсэнтэй холбоотойгоор гуравдагч этгээдийн оюуны өмчийн эрх зөрчигдсөн нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон бол буруутай тал нь хариуцлагыг хүлээж, холбогдон гарах зардал, хохирлыг арилгана.
- Алданги 10.21. Захиалагч нь төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Гүйцэтгэгчид төлнө.
- 10.22. Гүйцэтгэгч нь үйлчилгээг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгээр ГТН-д заасан хувь хэмжээгээр алдангийг Захиалагчид төлнө.
- 10.23. Талууд гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан хуулиар тогтоосон болон байгууллагаас нууц гэж нууцалж хамгаалалтад авсан аливаа мэдээллийг нөгөө тал зөвшөөрсөн эсхүл эрх бий байгууллага шаардсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй, дамжуулахгүй, нийтэд ил болгохгүй.
- 10.24. Талуудын хувьд нууц мэдээллийг нөгөө талдаа ил болгож байгаа тохиолдолд нууц гэсэн тэмдэглэл хийж, нууцыг задруулахгүй байх мэдэгдлийн хамт өгнө.
- Маргаан шийдвэрлэх 10.25. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.
- 10.26. Маргааныг зөвшилцөж, шийдвэрлэж эс чадвал Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

ГЕН 4.1.	<p>Үйлчилгээ үзүүлж эхлэх хугацаа: Гэрээнд талууд гарын үсэг зурж Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойш.</p>
ГЕН 4.2.	<p>Үйлчилгээ үзүүлэх дэлгэрэнгүй хөтөлбөр (төлөвлөгөө) ирүүлнэ.</p>
ГЕН 4.9.	<p>Үйлчилгээний явцын тайлан гаргах хуваарийг ирүүлнэ.</p>
ГЕН 5.2.	<p>Үнийн тохируулга: “Хийхгүй”</p>
ГЕН 5.4.	<p>Урьдчилгаа төлбөр олгох эсэх: “Үгүй”</p>
ГЕН 5.5	<p>Урьдчилгаа төлбөр олгох хугацаа:</p>
ГЕН 5.6.	<p>Төлбөр төлөх хугацаа:</p> <p>Гүйцэтгэгчийн гүйцэтгэлийн үндсэн шалгуур үзүүлэлт, төлбөрийн үе шат болон хуваарь, ажлын үр дүн зэргийг үйлчилгээний гэрээнд тусган байгуулна.</p> <p>Үйлчилгээний гэрээнд дурдсан нөхцөлийг Санхүүжилтийн гэрээнд тусган Захиалагч, Гүйцэтгэгч, Санхүүжүүлэгч талууд Санхүүжилтийн гэрээг байгуулна.</p> <p>Санхүүжилтийн гэрээний дагуу гүйцэтгэлийг үндэслэн төлбөрийг төлнө.</p> <p>Төлбөрийг захиалагч болон үйлчилгээ үзүүлэгчийн хооронд үйлдсэн ажил хүлээлцэх акт, нэхэмжлэх болон холбогдох баримт бичгийг үндэслэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дансанд бэлэн бусаар шилжүүлнэ</p>
ГЕН 6.1.	<p>Урьдчилгаа төлбөрийн хэмжээ: “Үгүй”</p>
ГЕН 6.7.	<p>Чанарын баталгаа:</p> <p>Чанарын баталгаа шаардах эсэх: “Шаардахгүй”</p>
ГЕН 6.13.	<p>Баталгаат хугацаа: “Шаардахгүй”</p>
ГЕН 7.5.	<p>Даатгал:</p> <p>Ажил гүйцэтгэгч тал бүрэн хариуцна.</p>
ГЕН 10.21.	<p>Захиалагчийн төлөх алдангийн хувь: Санхүүжилтийг “Оюу Толгой” ХХК хариуцна.</p> <p>Алдангийн хувь: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь</p>
ГЕН 10.22.	<p>Гүйцэтгэгчийн төлөх алдангийн хувь:</p> <p>Алдангийн хувь: Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.05 хувь</p>

ХЭРЛЭН-ТООНО ТӨСЛИЙН ТЕХНИК, ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛИЙН СУДАЛГААГ ШИНЭЧЛЭХ, ТОДОТГОЛ БОЛОВСРУУЛАХ” ҮЙЛЧИЛГЭЭГ САНХҮҮЖҮҮЛЭХ ГЭРЭЭ

[огноог оруулах]

№ [гэрээний дугаарыг оруулах]

Хэрлэн-Тооно төслийн техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийн судалгааг шинэчлэх, ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах үйлчилгээг Санхүүжүүлэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г

Оюу Толгой ХХК (цаашид “ОТ ХХК” буюу “Санхүүжүүлэгч” гэх),

Эрдэнэс Оюу Толгой ХХК (цаашид “ЭОТ ХХК” буюу “Захиалагч” гэх) болон

[Шалгарсан гүйцэтгэгчийг оруулах] (цаашид “Гүйцэтгэгч” гэх) (цаашид хамтад нь “Талууд” гэх ба тусад нь “Тал” гэх) нарын хооронд [огноог оруулах] байгуулав.

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

- 1.1. Энэхүү Гэрээгээр ОТ ХХК-ийн санхүүжилтээр Хэрлэн-Тооно төслийн техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийн судалгааг шинэчлэх, ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах үйлчилгээ (цаашид “Үйлчилгээ” гэх)-г санхүүжүүлэх, түүнд хяналт тавихтай холбоотой Талуудын хоорондын харилцаа, тэдгээрийн хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлсон болно.
- 1.2. Талууд энэхүү Гэрээг [огноог оруулах] өдөр Эрдэнэс Оюу Толгой ХХК (“Захиалагч”) болон [Шалгарсан гүйцэтгэгчийн оруулах] (“Гүйцэтгэгч”)-ийн хооронд байгуулсан үйлчилгээний гэрээ гэрээн дээр үндэслэн ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30.4 дэх хэсэгт заасны дагуу шалгарсан оролцогчийн баталгаажуулан ирүүлсэн гэрээг хүлээн авснаас хойш ажлын таван өдрийн дотор Санхүүжилтийн гэрээ байгуулсан болно.
- 1.3. Энэхүү Гэрээний дагуу хийгдэх Нийт Санхүүжилт нь гагцхүү үйлчилгээнд зориулагдана.
- 1.4. Үйлчилгээтэй холбоотой (урьдын, одоогийн, цаашид хийгдэх) аливаа тохиролцоог гагцхүү Захиалагч болон Гүйцэтгэгч нар хариуцна.

2. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү Гэрээнд дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.

Хариуцлага гэж аливаа төрлийн хохирол, нэхэмжлэл, алдагдал, хариуцлага, зардал зэргийг ойлгоно.

Ажилтан гэдэгт Гүйцэтгэгчтэй холбоотойгоор түүний аливаа ажилтнууд (туслан гүйцэтгэгчийн ажилтнуудыг хамааруулан), Үйлчилгээтэй шууд болон шууд бусаар холбогдох агент болон төлөөлөгчид хамаарна.

Нийт санхүүжилт гэж [Үйлчилгээг үзүүлэх зорилгоор энэхүү Гэрээний дагуу Санхүүжүүлэгчээс олгох нийт мөнгөн дүнг хэлнэ.

Үйлчилгээ гэж Санхүүжүүлэгчийн санхүүжүүлэх Хэрлэн-Тооно төслийн техник, эдийн засгийн үндэслэл (цаашид “ТЭЗҮ” гэх)-ийн судалгааг шинэчлэх, ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах Үйлчилгээг хэлнэ.

Ажлын хуваарь гэж Үйлчилгээг тендерийн баримт бичигт туссан, тохиролцсон хугацааны дотор тодорхой үе шатуудад хийж гүйцэтгэх болон ажлын явцыг хянах зорилгоор Захиалагч болон Гүйцэтгэгч нар Үйлчилгээ үзүүлэх гэрээгээр тохиролцсон Хавсралт Г-д заасан хуваарийг хэлнэ.

3. САНХҮҮЖИЛТИЙН НӨХЦӨЛ

- 3.1. ОТ ХХК нь Үйлчилгээнд зориулж нийт [санхүүжилтийн хэмжээг үсгээр/тоогоор оруулах] төгрөгийн санхүүжилт (“Нийт санхүүжилт”) олгоно. Санхүүжилтийг энэхүү Гэрээний Хавсралт Б-д заасан Төлбөрийн хуваарийн дагуу Үйлчилгээний гүйцэтгэлийг үндэслэн Гүйцэтгэгчид олгоно.
- 3.2. Энэхүү Үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой Гүйцэтгэгчээс гарах бүх зардлууд нь төлбөл зохих аливаа татварын хамт Нийт санхүүжилтэд багтсан болно.
- 3.3. 3.1 дэх заалтыг харгалзан, энэхүү Гэрээний бусад заалтын үйлчлэл, ач холбогдлыг хөндөхгүйгээр ОТ ХХК нь Гүйцэтгэгч, Захиалагч нар дараах шаардлагыг хангасан тохиолдолд санхүүжилтийг олгоно:
 - 3.3.1. Үйлчилгээг үзүүлэх хууль ёсны тусгай зөвшөөрөл бүхий Гүйцэтгэгчээр холбогдох журам, стандарт, тэргүүн туршлагын дагуу чанартай, сайн гүйцэтгүүлнэ.
 - 3.3.2. Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор шаардсан төрийн болон мэргэжлийн байгууллагын хяналт, дүгнэлт, аудит, зөвшөөрөл авахтай холбоотой хууль тогтоомж, стандартыг дагаж мөрдөх.
 - 3.3.3. Монгол Улсын авлигын эсрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх аливаа холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх.
 - 3.3.4. Санхүүжүүлэгч хүсэлт гаргасан тохиолдолд Гүйцэтгэгч, (хэрэв байгаа бол) түүний туслан гүйцэтгэгч, Захиалагч нь Үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой материал, бичиг баримттай танилцах, Ажилтнуудтай уулзах боломжоор Санхүүжүүлэгчийг бүрэн хангах бөгөөд ингэхдээ ямар нэгэн чирэгдэл төвөг учруулж, татгалзахгүй.
 - 3.3.5. Энэхүү Гэрээнд гарын үсэг зурахаас өмнө Үйлчилгээтэй холбоотой хийж гүйцэтгэсэн ажлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, баримт бичгүүдийг Санхүүжүүлэгчийн хүсэлтийн дагуу түүнд гаргаж өгнө.
 - 3.3.6. Энэхүү Гэрээнд заасан бусад үүргээ зохих ёсоор биелүүлэх.

4. ЗАХИАЛАГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 4.1. Захиалагч дараах үүргийг хүлээнэ:

- 4.1.1. Үйлчилгээтэй холбоотой хууль тогтоомж, стандартыг дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах,
- 4.1.2. Үйлчилгээг холбогдох дүрэм, журмын шаардлага, холбогдох гэрээний дагуу тохиролцсон стандарт, шаардлага, Ажлын хуваарийн дагуу хийж байгаа эсэхэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэх,
- 4.1.3. Гүйцэтгэгчээс энэхүү гэрээний Хавсралт А болон холбогдох гэрээний дагуу Нийт санхүүжилтийг захиран зарцуулж буй байдалд цаг тухайд нь үр дүнтэй хяналт тавих,
- 4.1.4. Захиалагчийн хяналтыг Захиалагч хэрэгжүүлэх бөгөөд (хэрэв хамаарах бол) холбогдох хуульд заасан шаардлагыг хангасан байх.
- 4.1.5. Гүйцэтгэгчийн ажлын үе шат бүрд тохиролцсон Ажлын хуваарийн дагуу хяналт тавьж, ямар нэгэн зөрчил доголдол илэрвэл Гүйцэтгэгчид шаардлага тавьж уг зөрчил дутагдлыг даруй арилгах, залруулах арга хэмжээг авах, холбогдох хууль тогтоомжид заасан бусад үүрэг хариуцлага, чиг үүргийг хүлээнэ.

5. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

- 5.1. Гүйцэтгэгч нь холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагуудыг чанд мөрдөн, Үйлчилгээг чанартай, сайн гүйцэтгэнэ гэдгээ бүрэн хүлээн зөвшөөрч байна.
- 5.2. Гүйцэтгэгч Нийт санхүүжилт нь Үйлчилгээг Ажлын хуваарийн хугацаанд бүрэн хийж гүйцэтгэхэд хүрэлцээтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа.
- 5.3. Хэрэв Гүйцэтгэгч нь Үйлчилгээ болон түүний аливаа хэсгийг цаг хугацаанд нь бүрэн гүйцэтгээгүй бол тухайн ажлыг өөрийн зардлаар хийж гүйцэтгэх ба Санхүүжүүлэгч болон Захиалагчаас нэмэлт зардал шаардахгүй.
- 5.4. Гүйцэтгэгч нь Үйлчилгээг үзүүлэхдээ Хавсралт Г-д заасан Ажлын хуваарийн дагуу зардлыг үр дүнтэй удирдан, өөрийн Ажилтнуудыг үр дүнтэй зохион байгуулах үүрэгтэй. Санхүүжүүлэгч аливаа цаг хугацаа хойшилсон, ажиллах хүч болон ажлын бүтээмжтэй холбоотой ямар нэгэн үүрэг, хариуцлага болон учирсан нэмэлт зардлыг хариуцахгүй.
- 5.5. Гүйцэтгэгч нь Үйлчилгээг зохих ёсоор гүйцэтгэхэд шаардагдах ажиллах хүчээр хангагдсан байна. Тухайн Ажилтнууд нь Үйлчилгээг гүйцэтгэхтэй холбоотой өөрийн ажил үүргийг биелүүлэхэд шаардагдах сургалтад хамрагдаж, шаардлагатай ур чадвар, дадлага туршлага эзэмшсэн байна.
- 5.6. Гүйцэтгэгч нь судалгааны үр дүн тайланг орон нутаг болон холбогдох төрийн байгууллагуудаар хэлэлцүүлнэ.
- 5.7. Санхүүжүүлэгч болон Захиалагчид Үйлчилгээний явцын талаарх мэдээллийг Ажил гүйцэтгэх хуваарьт заасны бүрэн хангах.

6. АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЯНАХ, ТАЙЛАГНАХ

6.1. Гүйцэтгэгч нь “14 хоног тутмын явцын тайлан”-г Захиалагчид гаргаж өгнө.

6.2. Тайланд дараах мэдээллийг тусгана:

6.2.1. Ажлын бодит гүйцэтгэлийг тоо хэмжээ, хувиар илэрхийлэх: /гүйцэтгэсэн ажлын хувь хэмжээ, Ажлын хуваарь болон Төлбөрийн хуваарийн дагуу гүйцэтгэсэн ажлын тухай мэдээлэл/

6.2.2. Ажлын хуваарь болон бодит гүйцэтгэл хооронд зөрүү үүссэн эсэх

6.3. Захиалагч нь Гүйцэтгэгчийн ажлын явц, гүйцэтгэлийг Ажлын хуваарьтай тулган нягталж хяналтаа хэрэгжүүлэх бөгөөд дор дурдсан хугацаанд дараах агуулга бүхий тайланг Санхүүжүүлэгчид хүргүүлнэ:

6.3.1. **Ажлын гүйцэтгэл ...%-д хүрсэн өдөр:** Ажлын 1-р үе шатны гүйцэтгэл болон явцын тайланд:

- Ажлын хуваарь (Хавсралт Г)-тай ажлын гүйцэтгэлийг харьцуулан дүгнэж, Захиалагчийн хяналтын үр дүнг тодорхой тайлагнаж, албан тоотыг холбогдох нэхэмжлэхийг хамтад нь хүргүүлэх,
- Гүйцэтгэгчийн гаргасан явцын тайланг хянан баталгаажуулах,

6.3.2. **Ажлын гүйцэтгэл ...%-д хүрсэн өдөр:** Ажлын 2-р үе шатны гүйцэтгэл болон явцын тайланд:

- Ажлын хуваарь (Хавсралт Г)-тай ажлын гүйцэтгэлийг харьцуулан дүгнэж, Захиалагчийн хяналтын үр дүнг тодорхой тайлагнаж албан тоотыг холбогдох нэхэмжлэхийг хамтад нь хүргүүлэх,
- Гүйцэтгэгчийн гаргасан явцын тайланг хянан баталгаажуулах

6.3.3. **Ажлын гүйцэтгэл ...%-д хүрсэн өдөр:** Ажлын 3-р үе шатны гүйцэтгэл болон эцсийн тайланд:

- Ажлын хуваарь (Хавсралт Г)-тай ажлын гүйцэтгэлийг харьцуулан дүгнэж, Захиалагчийн хяналтын үр дүнг тодорхой тайлагнаж албан тоотоор хүргүүлэх,
- Гүйцэтгэгчийн гаргасан эцсийн тайланг хянан баталгаажуулах;

7. ӨМЧЛӨЛ, ХЯНАЛТ БОЛОН ХУУЛИЙН ХАРИУЦЛАГААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ

7.1 Үйлчилгээг гүйцэтгэж дуусгасны дараа буюу түүнийг гүйцэтгэх аль ч хугацаанд Санхүүжүүлэгч Үйлчилгээ, түүний аль нэг хэсгийг өмчлөхгүй болно.

7.2 Захиалагч нь ОТ ХХК болон түүний хамааралтай этгээд, эрх шилжүүлэн авсан, залгамжлан авсан этгээдийг Үйлчилгээтэй холбогдон үүсэх аливаа хариуцлага, нэхэмжлэл, гомдлоос чөлөөлөх хууль ёсны болон зөвшөөрөгдсөн бүх арга хэмжээг авна.

8. НЭМЭЛТ БОЛОН НЭМЭГДСЭН ЗАРДЛЫГ НЭХЭМЖЛЭХГҮЙ БАЙХ

Захиалагч болон Гүйцэтгэгч нь төлөвлөөгүй зардлууд тухайлбал, мөн эдгээрээр хязгаарлагдахгүй хугацаа хойшлолт, зардлын тооцоо, бэлэн мөнгөний урсгалд үүссэн асуудал, эдийн засгийн хүндрэл, мөнгөний ханшийн өөрчлөлт, Давагдашгүй хүчин зүйл,

материал болон ажиллах хүчтэй холбоотойгоор үүссэн нэмэлт буюу нэмэгдсэн зардлыг Санхүүжүүлэгч байгууллагаас нэхэмжлэхгүй.

9. МЭДЭГДЭЛ

9.1 Энэхүү Гэрээний дагуу мэдэгдэл өгөхдөө:

- (a) доор дурдсан хаягаар буюу хүлээн авагч талын хамгийн сүүлд шинэчилж мэдэгдсэн хаягаар бичгээр үйлдэж илгээнэ:

Санхүүжүүлэгч байгууллага: Оюу Толгой ХХК

Хэнд: [оруулах]

Холбоо барих хаяг: Монгол Улс, Улаанбаатар 14240, Сүхбаатар дүүрэг, Чингисийн Өргөн Чөлөө 15, Моннис цамхагийн 12 давхар

Цахим шуудан: [оруулах]

Захиалагч: Эрдэнэс Оюу Толгой ХХК

Хэнд: [оруулах]

Холбоо барих хаяг: [оруулах]

Цахим шуудан: [оруулах]

Гүйцэтгэгч: [оруулах]

Хэнд: [оруулах]

Холбоо барих хаяг: [оруулах]

Цахим шуудан: [оруулах]

- (b) Илгээгчийн эрх бүхий албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулсан байх:
(c) Дээрх хаягаар хүргүүлсэн, хүлээн авсан эсхүл үлдээсэн бол тухайн мэдэгдлийг хүргэсэнд тооцно.

9.2 Талууд захидал, мэдэгдлийг биеэр хүргэсэн эсвэл дээр дурдсан цахим шуудангаар илгээсэн бол тухайн илгээсэн өдөр нөгөө талыг хүлээн авсанд тооцно. Хэрэв илгээсэн өдөр нь Ажлын Өдөр биш байвал дараагийн ажлын өдөр нь хүлээн авсанд тооцно. Хэрэв төлбөртэй шуудангаар илгээсэн бол илгээснээс хойш тохиох долоо /7/ дахь өдрийг хүлээн авсан болон хүргэсэн өдөрт тооцно.

10. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

Урьдчилан харах боломжгүй, Талуудын хяналтаас гадуурх аливаа үзэгдэл, үйл явдал нь Давагдашгүй хүчин зүйлд тооцогдох бөгөөд Талууд Давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацаа, хэмжээнд түүний нөлөөнд өртсөн үүрэг, хариуцлагаас чөлөөлөгдөнө. Энэхүү Гэрээний зорилгоор Давагдашгүй хүчин зүйл нь төрийн байгууллагын шийдвэр, эмх

замбараагүй байдал, байгалийн гал түймэр, газар хөдлөлт, маш хүчтэй салхи шуурга, их хэмжээний үерийг хамаарна.

11. ЭРСДЭЛ БОЛОН ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Захиалагч нь [Санхүүжүүлэх ажлыг оруулах]-тай холбогдох эрсдэлүүдийг бүрэн хариуцах ба эдгээр эрсдэлүүдийг үнэлэх, сэргийлэх, бууруулах, удирдахад бүх хүчин чармайлтаа гаргаж, онцгой анхаарал хандуулж ажиллана.

12. ХОХИРОЛГҮЙ БОЛГОХ

Захиалагч, Гүйцэтгэгч нь ОТ ХХК-ийг энэхүү Гэрээ болон холбогдох хуулийн дагуу үүсэх/гэрээний болон хуулийн/ аливаа нэхэмжлэл, хариуцлага, зардлаас чөлөөлж, хохиролгүй болгоно.

13. ХЭРЭГЛЭХ ХУУЛЬ БОЛОН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

13.1 Энэхүү Гэрээнд Монгол Улсын хуулийг хэрэглэж, түүний дагуу тайлбарлагдана.

13.2 Талууд Энэхүү гэрээтэй холбоотой үүссэн маргааныг маргаан үүсгэсэн мэдэгдлийг хүлээн авснаас хойш гуч /30/ хоногийн дотор эсхүл Талуудын өөрөөр тохиролцсон хугацаанд хэлэлцэн шийдвэрлэнэ. Ингэж шийдвэрлэж чадахгүй тохиолдолд маргааныг Монгол улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

14. ГЭРЭЭ ЦУЦЛАХ БУЮУ ДУУСГАВАР БОЛГОХ

14.1 Гүйцэтгэгч нь энэхүү Гэрээний 3.3 дугаар зүйлийн нөхцөл, шаардлагыг биелүүлээгүй буюу зөрчсөн бөгөөд Санхүүжүүлэгч зөрчлийг арилгуулахаар хүргүүлсэн мэдэгдэлд заасан хугацаанд зөрчлийг арилгах буюу залруулах арга хэмжээ аваагүй тохиолдолд Захиалагч, Санхүүжүүлэгч нар зөвшилцөн холбогдох хууль, дүрэм журмын хүрээнд шаардлагатай тохиолдолд энэхүү Гэрээг цуцалж, Нийт санхүүжилтийн аливаа төлбөр, шилжүүлгийг зогсоож болно.

14.2 Гэрээ цуцлагдмагц Захиалагч болон Гүйцэтгэгч Үйлчилгээний зардал, эрсдэлийг бууруулахад шаардлагатай бүх арга хэмжээг авна. Цаашилбал, Гэрээ цуцалсантай холбогдуулан, Санхүүжүүлэгчийн төлсөн буюу шилжүүлсэн Нийт санхүүжилтийн дүнгийн аль ч хэсгийг Гүйцэтгэгчээс буцаан нэхэмжлэх, нөхөн төлүүлэх эрхтэй.

15. БУСАД ЗҮЙЛС

15.1 Энэхүү Гэрээнд Талууд бичгээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.

15.2 Захиалагч болон Гүйцэтгэгч нь Санхүүжүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, ашиг сонирхол, үүргээ бүхэлд нь буюу хэсэгчлэн гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

- 15.3 Тал тус бүр энэхүү Гэрээг байгуулах, түүнд заасан үүргийг биелүүлэх бүрэн эрхтэй бөгөөд энэ зорилгоор шаардлагатай бүх бүрэн эрх, зөвшөөрлийг авсан гэдгээ баталж байна.
- 15.4 Энэхүү Гэрээг Англи болон Монгол хэл дээр тус бүр гурван хувь үйлдэж тал тус бүр нэг, нэг хувийг хадгална. Англи болон Монгол хэл дээрх хоёр хувилбарын хооронд зөрүүтэй байдал үүсэх тохиолдолд тухайн зөрүүтэй байдлын хэмжээнд Англи хувь нь давуу хүчинтэй байна.

Хүлээн зөвшөөрч гарын үсэг зурсан:

Санхүүжүүлэгчийг төлөөлж:

_____ (гарын үсэг)

Нэр: [оруулах]

Албан тушаал [оруулах]

Захиалагчийг төлөөлж:

_____ (гарын үсэг)

Нэр: [оруулах]

Албан тушаал [оруулах]

Гүйцэтгэгчийн төлөөлж:

_____ (гарын үсэг)

Нэр: [оруулах]

Албан тушаал [оруулах]

ХАВСРАЛТ А**ЗАРДЛЫН ЗАДАРГАА**

№	Зардлын төрөл	Тайлант үеийн гүйцэтгэл ...% №1	Тайлант үеийн гүйцэтгэл ...% №2	Тайлант үеийн гүйцэтгэл ...% №3	Нийт төсөвт өртөг
1	Ажиллах хүч				
2	Материал				
3	Тээвэр				
4	[оруулах]				
5	[оруулах]				
6	[оруулах]				
7	[НӨАТ 10%]				
8	Бүгд дүн				

ТӨЛБӨРИЙН ХУВААРЬ

1. Нэхэмжлэл өгөх зааварчилгаа

- 1.1 Нэхэмжлэхийн нэг эх хувь болон нэг хуулбар хувийг хамтад нь ОТ ХХК-ийн албан ёсны хаягаар [хаяглан ирүүлэх хүнийг оруулах] гэсэн нэр дээр хүргүүлнэ.
- 1.2 Нэхэмжлэл нь дараах мэдээллийг агуулсан байна:
 - 1.2.1. [шаардагдах бичиг баримтууд]
 - 1.2.2. Нэхэмжлэх үнэн зөв, жинхэнэ баримт болохыг баталгаажуулж эрх бүхий этгээд гарын үсэг зурж тамга дарсан байна.

2. Төлбөр төлөх хэлбэр

- 2.1 Гэрээний дагуу хийх бүх төлбөр нь Гүйцэтгэгчийн өгсөн хууль ёсны банкны дансруу бэлэн бус хэлбэрээр төгрөгөөр хийгдэнэ.
- 2.2 Гүйцэтгэгч нь төлбөрийг түүнд төлөхөд шаардлагатай тохиолдолд мэдээлэл, баримт бичгийг Санхүүжүүлэгчид өгнө.
- 2.3 Бүх төлбөрийг Монгол Төгрөг (MNT)-өөр төлнө.
- 2.4 Төлбөрийг нэхэмжлэхийн огнооны дараагийн сарын эхний өдрөөс хойш 45 хоногийн дотор төлнө.

3. Татвар

- 3.1 Нийт санхүүжилт нь бүх татвар, хураамж, зардал багтсан дүн болно.
- 3.2 Энэхүү Гэрээ, санхүүжилт болон Нийт санхүүжилттэй холбоотойгоор Захиалагч болон Гүйцэтгэгч нь холбогдох хуулийн дагуу өөрт ногдуулсан бүх татвар, төлбөр, хураамжийг төлөх үүрэгтэй.

4. Нэхэмжлэхэд тавигдах шаардлага

- 4.1. Төлбөрийн нэхэмжлэхэд дурдсан Гүйцэтгэгчийн нэр нь энэ Гэрээнд заасан Гүйцэтгэгчийн нэртэй тохирч байх ёстой.
- 4.2. Бүх нэхэмжлэх Монгол хэлээр үйлдэгдсэн байна.
- 4.3. Нэхэмжлэхээ энэхүү Хавсралт Б болон түүнд заасан төлбөрийн хуваарийн дагуу үйлдэж ирүүлнэ.
- 4.4. Санхүүжүүлэгчийн шаардлагын дагуу, хэрэв Гүйцэтгэгч нь нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгч бол и-баримт (татварын байгууллагын нэгдсэн цахим систем)–ээс гаргасан Нэхэмжлэх гаргаж өгөх шаардлагатай. Иймд, Гүйцэтгэгч рүү төлбөрийг шилжүүлсний дараа төлбөрийг хүлээн авснаас хойш 5 өдрийн дотор дараах алхмуудыг хийж гүйцэтгэх шаардлагатай: Гүйцэтгэгч нь и-баримт систем дээр Нэхэмжлэхийг (татварын байгууллагын нэгдсэн цахим систем дээр) “төлбөр төлөгдсөн” гэх сонголтыг сонгож шалгах шаардлагатай.

5. Гүйцэтгэлд үндэслэсэн төлбөр

Санхүүжүүлэгч нь Үйлчилгээний санхүүжилтийг дараах гүйцэтгэлүүд хийгдсэний дараагаар олгоно.

Санхүүжилтийн хуваарь	Ажлын гүйцэтгэл	Ажлын гүйцэтгэлийн хуваарь	Шаардагдах бичиг баримтууд
Нийт санхүүжилтийн [...%] болох [оруулах] төгрөг	•	Ажлын гүйцэтгэл ...%-д хүрсэн өдөр	•
Нийт санхүүжилтийн [...%] болох [оруулах] төгрөг	•	Ажлын гүйцэтгэл ...%-д хүрсэн өдөр	•
Нийт санхүүжилтийн [...%] болох [оруулах] төгрөг	•	Ажлын гүйцэтгэл ...%-д хүрсэн өдөр	•

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Хэрлэн-Тооно төслийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгааны ажлын зорилго, судлагдсан байдал

Судалгааны ажлын зорилго нь Хэрлэн голын тооцоолсон байршил дээр олон зориулалттай усан цогцолбор байгуулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, Өмнөд говийн зүүн бүсийн өсөн нэмэгдэж байгаа ус хэрэглээний хэтийн төлөвийг хангах ус хангамжийн хувилбаруудыг нарийвчлан гаргаж, бүх хувилбаруудын инженер техникийн шийдэл, санхүү эдийн засаг, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн хувьд харьцуулан судалж боломжтой хувилбарыг сонгох асуудал юм.

ТЭЗҮ-ийг урьд өмнө хийгдсэн хайгуул, судалгаа, тооцооны материалд үндэслэн нарийвчлан шинэчлэн боловсруулсан байна.

- ТЭЗҮ ажлын үр дүнгээр усны нөөц, техник технологийн боломж, санхүү, эдийн засгийн нөхцөлүүд, байгаль орчин ба нийгмийн нөлөөллүүдийн харьцуулалтаар Өмнөд говийн Зүүн бүсийн ус хэрэглээг говийн газар доорх усны эх үүсвэр болон хойд бүсийн гадаргын усны эх үүсвэрээс хосолсон байдлаар хангах буюу Хэрлэн голын урсцад тохируулга хийж говийн бүс рүү далд шугам хоолойгоор усыг дамжуулан ус хэрэглэгчдэд хүргэх явдал юм.
- Монгол улсын нийт газар нутаг болон говийн бүс нутагт сүүлийн жилүүдэд эрчимтэй явагдаж байгаа цөлжилтийг бууруулах багасгахын тулд техник технологийн шинэ шийдлийг эрэх хайх замаар инженерчлэлийн шийдлийг гаргах
- Хэрлэн гол дээр боомт бүхий олон жилийн урсцын тохируулгатай ус хуримтлуулах хиймэл нуур байгуулах замаар гадаргын усыг ашиглах хувилбарыг сонгоно.
- ТЭЗҮ-ийн хүрээнд шаардлагатай инженерийн байгууламжийг байгальд ээлтэйгээр шийдэх хэд хэдэн хувилбар гаргах, түүний ажлын зураг боловсруулах, байршлыг шийдэх .
- Тухайн бүс нутагт аялал жуулчлал хөгжүүлэх хямд зардлаар эрчим хүчийг ашиглаж бэлчээрийн аж ахуй, газар тариалангийн бүс нутгийг хөгжүүлэх усан хангамжийн систем бий болгох

Хэрлэн гол дээр болон говийн бүсийн ус хангамжийг нэмэгдүүлэх урьдчилсан судалгааны дараах ажлуудыг гүйцэтгэсэн. Үүнд:

1. ҮХААЯ-ны захиалгаар 2014 онд боловсруулсан **Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор төслийн хүрээнд “Бүс нутаг хооронд ус тээвэрлэх боломж, ТЭЗҮ боловсруулах” эрэл, хайгуулын судалгаа /Хэрлэн-Тооно/**
2. 2015 онд боловсруулсан **Хэрлэн гол дээр олон жилийн урсцын тохируулга бүхий ус хуримтлуулах усан сан байгуулан голын экологийн чадамжийг сайжруулах “Хэрлэн-Говь” төсөл. Техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа.**
3. Усны газрын захиалгаар 2021 онд боловсруулсан **Говийн бүсийн үйлдвэр уурхайн ус хангамжийг нэмэгдүүлэх төслийн техник эдийн засгийн үндэслэл.**

Төсөлд хамрагдах бүс нутаг

Хэрлэн гол дээр урсцын тохируулга хийх зорилгоор боомт бүхий томоохон хиймэл нуур байгуулж, гадаргын усыг хуримтлуулан хамгаалж зохистой ашиглах төсөл нь Монгол орны

эдийн засгийн ач холбогдол бүхий Зүүн бүс, Өмнөд говийн бүсийн зүүн хэсгийг хамрах бөгөөд энэ нутгийн ихэнх хэсэг нь байгалийн хуурай бүс нутагт хамаарах юм. Өөрөөр хэлбэл төсөл хэрэгжих нутаг дэвсгэрт Хэнтий аймгийн 3 сум, Төв аймгийн 2 сум, Говьсүмбэр аймгийн 3 сум, Дорноговь аймгийн 8 сум, Өмнөговь аймгийн 3 сумын газар нутаг хамрагдаж байна.

ХАВСРАЛТ Г**АЖЛЫН ХУВААРЬ****А. Ажлын талбайд хийх шинжилгээ, судалгаа**

	<i>[Зөвлөхийн үйлчилгээг эхэлсэн нэг дэх сар, хоёр дахь сар гэх мэт]</i>											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Үйл ажиллагаа (ажлууд)												

В. Ажлыг дуусгаж тайлан өгөх

Тайлан	Он, сар, өдөр
1. Эхлэлийн тайлан	
2. Явцын тайлан (а) 1 дэх тайлан (б) 2 дахь тайлан	
3. Тайлангийн төсөл	
4. Эцсийн тайлан	

ГЭРЭЭ БАТАЛГААЖУУЛАХ МАЯГТ

[Тендер шалгаруулалтын нэрийг бичих] гэрээ.

Дугаар № **[Тендер шалгаруулалтын дугаарыг бичих]**

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэрийг бичих]** (цаашид “Захиалагч” гэх), нөгөө талаас **[гүйцэтгэгчийн нэрийг бичих]** (цаашид “Гүйцэтгэгч” гэх) нь Гүйцэтгэгчийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах бараа нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь “Үйлчилгээ” гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх Үйлчилгээний үнэ нь **[гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэлд заасан үнийн дүнг тоогоор болон үсгээр бичих]** төгрөг (цаашид “гэрээний үнэ” гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна.
2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **[Гүйцэтгэгчийн нэрийг бичих]**-ийн харилцах **[Банкны нэрийг бичих]** банкны **[дансны дугаар бичих]** дугаар дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 3.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
 - 3.2. Гүйцэтгэгч тендер илгээсэн маягт;
 - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
 - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
 - 3.5. Гүйцэтгэлийн баталгаа;
 - 3.6. Урьдчилгаа төлбөрийн баталгаа;
 - 3.7. Техникийн тодорхойлолт;
 - 3.8. Үйлчилгээ үзүүлэх хуваарь.
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
 - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

4.2. Гүйцэтгэгчийн төлөөлөгчийн мэдээлэл

Эцэг/эх-ийн нэр:

Нэр:

Албан тушаал:

Ажлын утас:

Гар утас:

Цахим шуудан:

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

[Гарын үсэг] _____

ТАМГА

ТАМГА

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАРЛАЛ

Огноо: **2024.07.02**

Тендер шалгаруулалтын төрөл: Үйлчилгээ

Тендер шалгаруулалтын нэр: **“Хэрлэн Тооно” төслийн ТЭЗҮ-ийн тодотгол боловсруулах**

Тендер шалгаруулалтын дугаар: **ЭОТХХК/20240101004**

Нийт төсөвт өртөг: **10,143,960,000.0 (Арван тэрбум нэг зуун дөчин гурван сая есөн зуун жаран мянга) төгрөг**

Тендер шалгаруулалтын арга: Нээлттэй

1. **“Эрдэнэс Оюу Толгой” ХХК** нь тендер шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан аж ахуй эрхлэгчийг тендер ирүүлэхийг урьж байна.
2. Тендер шалгаруулалт нь дараах багцуудаас бүрдэнэ: **“Үгүй”**
3. Тендерийг **2024.08.20**-өөс өмнө тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаар илгээх ба тендерийг **2024.08.20**-ний өдрийн, **11:30** минутад нээнэ.
4. Тендерийн хувилбарт саналыг зөвшөөрөх эсэх: **“Зөвшөөрөхгүй”**
5. Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй эсэх: **“Эрхтэй”**
6. Тендер нь түүнийг нээснээс хойш ажлын 30 өдрийн хугацаанд хүчинтэй байна.
7. Тендерийн баталгаа шаардах эсэх: **“Туйм”**
Тендерийн баталгаа шаардах бол тендер шалгаруулалтын баримт бичгийн заасан үнийн бүхий тендерийн баталгааг холбогдох журмын дагуу цахим системээр ирүүлснээр тендер нээх болохыг анхаарна уу.
8. Тендер шалгаруулалтыг урьдчилан зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
9. Тендер шалгаруулалтыг хоёр үе шаттай зохион байгуулж байгаа эсэх: **“Үгүй”**
10. Оролцогч цахим системийн үйлчилгээний хураамж төлснөөр тендер илгээх эрхтэй байна.

Хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Блю ский цамхаг 8 дугаар давхар, 803 тоот.**

Утасны дугаар: **7007 8085**

Цахим шуудангийн хаяг: **tender.gov.mn**